

Лицонона

Насанд хүрсэн
хүүхдүүдээ
халамжлах нь,
34-р хуудас

Бразил: Өсөлт хөгжилтийн
зуун, 18-р хуудас

Аврагчийг бэлгэдлүүдээс
олж харах нь, 52-р хуудас



“Заримдаа бид
итгэл бишрэлийг
маань шүүмж-
лэгчдийн бай
болоод зогсохгүй,
Бурханы жишгүү-
дийг тууштай
баримталж,
Түүний ажлыг
хийснийхээ
төлөө ‘хурц
шүүмжлэл’
хүлээх ёстой
болдог. Хэрэв
бид Түүний
сургаалд суури-
лагдсан бол айх
хэрэггүй гэдгийг
би гэрчилж
байна. Бид үл
ойлголцол,
шүүмжлэл болон
хуурамч гүтгэл-
гийг хүртэл
амсаж болно,
гэвч бид хэзээ ч
ганцаардахгүй.
Бидний Аврагч
‘үзэн ядагдаж
мөн хүмүүсээр
орхигдсон’
[Исаиа 53:3]
билээ. Түүнтэй
хамт зогсох
нь бидний
хувьд онцгой
боломж юм!”

Арванхоёр Төлөөлөгчийн
чуулгын ахлагч Робэрт
Д.Хэйлс, “Ариун газруудад
бат зогсоцгооё,” *Лиахона*,
2013 оны 5-р сар, 50.



ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас
бичиг: Зүрх сэтгэлийг
өөрчлөн эргүүлэх амлалт
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
- 7** Айлчлагч багшийн захиас
бичиг: Есүс Христийн
тэнгэрлэг зорилго: Өмгөөлөгч

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 18** Газар бүрийн анхдагчид:
Бразил дахь сүм: Ирээдүй
бидний үед ирлээ
Марк Л.Гровер
*Бразил дахь сүм цагаачилж
ирсэн нэг жижиг гэр бүлээс
нэг сая гаруй гишүүнтэй
болтлоо өслөө.*
- 24** Мормоны Ном, Израилын
цугларалт ба Хоёр дахь
ирэлт
Ахлагч Рассэлл М.Нэлсон
*Мормоны Ном бол бурханлаг
хоёр зорилгыг биелүүлэхэд
туслах Бурханы зэмсэг мөн.*
- 30** Аммон шиг бай
Тойрог эсвэл салбарынхаа ги-
шүүдийг идэвхжүүлэхэд танд
Аммоны түүх тусалж чадах
болов уу?
- 34** Залуучуудын эцэг эхэд
зориулсан арван зөвлөгөө
Вэнди Улрич
*Эдгээр 5 бэрхшээл ба 10 зөвлө-
гөө насанд хүүрсэн хүүхдүүдээ
ойлгоход тань туслах болно.*

АЛБАД

- 8** 2014 оны 4-р сарын чуулганы
тэмдэглэлээс
- 10** Бид юунд итгэдэг вэ?:
Бид Ариун Сүнсний хүчээр
заадаг
- 12** Сүмд үйлчлэх нь:
Аврагчтай адил удирдах нь
Раян Карп
- 14** Хуучин Гэрээний
бошиглогчид: Елиа
- 15** Залуучуудын бат бөх байд-
лын төлөө товхимлоос заах
нь: Ажил хөдөлмөр ба бие
даан амьдрах чадвар
- 16** Сүмийн мэдээ
- 38** Хожмын үеийн
гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80** Биднийг дахин уулзтал:
Эрэг рүү хар
Ричард М.Ромни
*Та давалгаа руу анхаарлаа
төвлөрүүлээд байвал эрэгт
хурч чадахгүй.*

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн таад: Гэрэл зураг чимэглэлийг Коди
Бэлл, Дотор таагын хавтсанд: Гэрэл зургийг
© Robert Harding World Imagery/Corbis.



42 Христээр төгөлдөржих нь
Ахлагч Гэррит В.Гонг
Аврагчийн төгс төгөлдөр байдал нь перфекционизм буюу төгс байх үзэл, өөртөө хэт шүүмжлэлтэй ханддаг зан болон бодит бус сэтгэлгээг даван туулахад бидэнд тусалж чадна.



Энэ дугаарт нуусан Лиана-наг олоорой. Санамж: Нил ягаан цэцгүүдийг сонгоорой.



48 Бурханлаг гэрээнүүд тууштай Христэд итгэгчдийг төрүүлдэг
Ахлагч Д. Тодд Кристоффэрсон
Бид ёс суртахууны болон сүнслэг хүч чадлыг хэрхэн олж авдаг вэ?

52 Танд юу харагдаж байна?
Дэвид А. Эдвардс
Сайн мэдээний ёслолуудыг анхааралтай хар. Та ямар нэг шинэ зүйл сурах болно.

55 Бидний орон зай

56 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Ажил хөдөлмөр хэнд хэрэгтэй вэ?
Рандалл Л.Ридд

58 Шавартай гуталтайгаа хоолой зөөсөн нь
Рэймонд М.Алтон
Чуулгынхаа зөвлөгчийг манай гадаа ирэх үед би өглөөний ажлаасаа амсхийгээд байлаа.

60 Нүдээ олсон хариулт

61 Зурагт хуудас: Аливаа зүйл харагдаж байгаа шигээ дандаа байдаггүй

62 Зөв учир шалтгаанаар үйлчлэх нь
Расим Малуфф
Хөл бөмбөгөөр амжилт гаргах ирээдүй надад байсан юм. Би үнэхээр номлолд үйлчлэх хэрэгтэй байсан гэж үү?

64 Мормончууд Бурханд итгэдэг
Брэнда Хэрнандез Руиз
Намайг тэр эмэгтэйд мормон гэдгээ хэлэхэд тэр надтай ярилцахыг хүссэнгүй.



66 Онцгой гэрч: Бид Сүнстэй хамт байхуйц зохистой байхын тулд юу хийж чадах вэ?
Ерөнхийлөгч Боид К.Пакэр

67 Итгэлийн тухай миний заасан хичээл
Эмма Р.
Хулууны ганц үр надад итгэлийн тухай заасан юм.

68 Миний бие бол ариун сүм
Марисса Виддисон
Танд бие махбодынхоо талаар асуух зүйл байна уу?

70 Хүүхдийн хэсгийг гэртээ авчрах нь: Бид баптисм ба гишүүний баталгаагаар дамжуулан сүмийн гишүүд болдог
Жэннифер Мадди

72 Бидний хуудас

73 Үйлчлэхэд бэлтгэсэн нь
Ахлагч Эдуардо Гаваррэт
Ус маш хүйтэн байсан ч би баптисм хүртэх хүсэлтэй хэвээр байв.

74 Дэлхий даяар найзуудтай болох нь: Би Бразилын Педро байна
Эми Жэйн Лэвитт

76 Бага насны хүүхдүүдэд зориулав: Сара алхсаар л байв
Хэйди Поэлмэн

81 Бошиглогчийн хөрөг: Томас С. Монсон

2014 ОНЫ ДОЛООДУГААР САРЫН ДУГААР 15 NO. 4
ЛИАХОНА 10987 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Боид К.Пакэр,
Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,
М.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсен

Эрхлэгч: Крэйг А.Кардон

Зөвлөхүүд: Хосе Л.Алонсо, Мэрвин М.Арнольд, Шэйн
М.Бөүэн, Стэнли Г.Эллис. Бага Кристоффэл Голдэн

Удирдах захирал: Дэвид Т.Варнер

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон, Дэвид
А.Эдвардс, Жэнифер Грэйс Фэллон, Маттью Д.Флиттон,
Минди Рая Фрийдман, Лори Фүллэр, Гаррэт Х.Гарфф,
ЛэРин Портэр Гаунт, Майкл Р.Моррис, Салли Жонсон
Одэжерк, Жосуа Ж.Пэркий, Жан Пинборроу, Ричард М.
Ромни, Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй
П.Андрус, Мэндэл М.Бэнгли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан
Лобгран, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брад Тизэри,
П.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Кэвин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли
Бурдэтт, Браян У.Гиги, Дэнис Керби, Жинни Ж.Нилсон,
Гэйл Тэйт Раффэрти

Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт
liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь уггаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаж, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гарт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

July 2014 Vol. 15 No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Post
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to
Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаанууд
багтсан. Дор хоёр жишээ өгөв.



ГЭРЛЭЭРЭГ ЧИМЭГЛЭЛИЙГ КОДИ БАЛ

"Христээр төгөлдөржих нь" 42-р
хуудас: Перфекционизм буюу төгс байх
үзлийн талаар ахлагч Гонгийн заасан
зүйлийг ашиглан, үнэн эсвэл худал гэсэн
хариулттай асуултууд бэлтгэв. Үүнийгээ
ашиглан гэр бүлийнхээ гишүүдэд ийм
хандлагатай эсэхээ мэдэхэд нь тусал. "Би
алдаа гаргасан үедээ ч аз жаргалтай байж
чадна" эсвэл "миний хувьд бусдыг уучлах
хэцүү" гэх мэт өгүүлбэрүүдийг та асуулт-
даа оруулж болно. Аврагчид найдах тухай
ахлагч Гонгийн заасан зүйлийг хамтдаа
унш. Мөн та хэрхэн зөв зорилгууд тавьж,
перфекционизм буюу төгс байх үзлийг
даван туулах талаар заахын тулд *Ми-
ний сайн мэдээг номло*: *Номлогчийн
үйлчлэлд зориулсан удирдамж* номын
146–147-р хуудсыг ашиглаж болно.

Хүүхдүүдээ өөрсдийн бие махбодыг
хэрхэн хүндэтгэж, хайрлах талаар заахын
тулд 68-р хуудсан дахь **"Миний бие
бол ариун сүм"** өгүүллийн асуултуудыг
ашиглаарай. Мөн зөв хооллох дадал
хэвшлийн талаар хүүхдүүдээ заахдаа
жимс юм уу хүнсний ногоогоор эрүүл
зууш бэлтгэн өгч болно. Та эрүүл чийрэг
болон эрч хүчтэй байхын үнэ цэнийг
ойлгоход нь хүүхдүүдээ туслахын тулд
спорт тоглоомоор тоглох юм уу ямар
нэг үйл ажиллагаа гадаа зохиож ч
болох юм. Тойрог, салбарынхаа юм уу
сургуулийнхаа хөгжлийн бэрхшээлтэй
ямар нэг хүүхэд туслахад нь хүүхдүүдээ
урамшуулан дэмж. Та мөн "I'll Walk
with You" дууг дуулж болно (*Children's
Songbook*, 140).

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон сүмийн бусад материалыг languages.lds.org вэбсайт дээр олон
хэлээр үзэх боломжтой.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.

Ажил хөдөлмөр, 15,
56, 58

Анхдагчид, 18, 76

Ариун Сүнс, 10, 40, 66

Ариун сүм, 18

Ариун ёслол, 52, 70

Баптисм, 52, 70, 73

Бие махбод, 68

Бошиглогчид, 14, 81

Гишүүний баталгаа,
52, 70

Гэр бүл, 34, 39, 40, 41, 80

Гэр бүлийн түүх, 4, 6,

14, 55

Гэрлэлт, 41

Гэрчлэл, 64

Гэрээнүүд, 24, 48

Дуудлагууд, 12

Есүс Христ, 7, 12, 42

Ёслолууд, 52, 70

Заасан зүйл, 10

Залуучуудад зориулав, 34

Зарлигууд, 60

Идэвх султай гишүүдийг

идэвхжүүлэх нь, 30, 38

Итгэл, 48, 67

Мормоны Ном, 24, 30,
38, 55

**Мөнхийн талаас нь
харах үзэл баримтлал,**
42, 80

Номлолын ажил, 18, 30,
62, 64

Үйлчлэл, 12, 56, 58, 62, 73

Хоёр дахь ирэлт, 24

Хуучин Гэрээ, 14

Хөрвөлт, 18

Цагаатгал, 7, 42

Эцэг эх болох нь, 34



**Ерөнхийлөгч
Хэнри Б.Айринг**

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх

Зүрх сэтгэлийг ЭРГҮҮЛЭН ӨӨРЧЛӨХ АМЛАЛТ

Миний ээж Милдрэд Бэннион Айринг АНУ-ын Юта мужийн хөдөө аж ахуй эрхэлдэг суурин болох Грэнжэрт өссөн. Ах нарынх нь нэг Роя, хонь өсгөж үржүүлэх гэр бүлийнхээ бизнесийг цааш үргэлжлүүлсэн юм. Тэрээр залуу байхдаа олон долоо хоногийг гэрээсээ хол өнгөрүүлдэг байв. Цаг хугацаа өнгөрөх тусам түүний сүмд явах сонирхол буурсан байв. Хожим нь тэрээр АНУ-ын Айдахо руу нүүсэн бөгөөд тэндээ гэрлэж, гурван хүүхэдтэй болсон юм. Түүнийг 34-тэйдээ нас барах үед эхнэр нь 28 настай, хүүхдүүд нь бага байв.

Хэдийгээр Роягийн бяцхан гэр бүл Айдаход амьдарч, ээж маань 2500 бээр (4025 км)-ийн зайд орших АНУ-ын Нью Жерсид нүүж очсон байсан ч тэрээр хайрын болон урмын үгстэй захидуудыг тэдэнд бичдэг байжээ. Нагац ахын маань гэр бүл ээжийг минь хайрлан “Авга эгч Мид” гэдэг байв.

Олон жил өнгөрсний дараа нэг үеэл минь надтай утсаар ярьсан юм. Роягийн бэлэвсэн эхнэр нас барсан тухай тэр надад дуулгаад “Авга эгч Мид чамайг үүнийг мэдээсэй гэж хүсэх байсан байх” гэж билээ. Авга эгч Мид өөд болоод удсан ч гэр бүлийнхэн нь түүний хайрыг үргэлж санан дурсдгийг тэр надад хэлсэн юм.

Нифайчуудын бошиглогчид Есүс Христийн сайн мэдээнд авчрахыг хүссэн садан төрлүүдтэйгээ аль болох ойр дотно байх замаар тэдгээр гэр бүлд чухал үүрэг гүйцэтгэсний адилаар ээж минь энэ гэр бүлд ямар их үүрэг гүйцэтгэснийг мэдээд би их гайхаж билээ. Нифай өөрсдийн патриарх Лихайн итгэлд эргэн ирэхэд нь нөлөөлөх байх гэсэн найдвар тээн, ахынхаа хүүхдүүдэд зориулан нэгэн цэдэг бичжээ. Мозаягийн хөвгүүд Лихайн үр удамд сайн мэдээг номлох үедээ мөн үүнтэй адил хайрыг үзүүлсэн юм.

Гэр бүлүүдэд үүрд мөнх үргэлжлэх хайрыг мэдрэх арга замуудаар Их Эзэн биднийг хангасан юм. Өнөөдөр сүм дэх залуу хүмүүс гэр бүлээ гэсэн өөрсдийн зүрх сэтгэлийг мэдэрч байна. Энэ амьдралд авралын ёслолуудыг хүлээж авах боломжгүй байсан гэр бүлийнхээ гишүүдийн нэрсийг тэд хайж байна. Тэд эдгээр нэрийг ариун сүмд авчирдаг. Баптисмын усанд орох үедээ тэд ёслолуудыг нь төлөөлөн хийлгэж буй хүний гэр бүлийнх нь гишүүдийн болон Их Эзэний хайрыг мэдрэх боломжтой болдог.

“Ээж минь өөд болчихлоо, Авга эгч Мид чамайг үүнийг мэдээсэй гэж хүсэх байсан байх” хэмээн хэлсэн үеэлийнхээ дууны өнгөнд мэдрэгдсэн хайрыг би одоо ч гэсэн санаж байна.

Гэр бүлийнхээ гишүүдийн төлөө ёслолууд гүйцэтгэж байгаа та бүхэн Мозаягийн хөвгүүд шиг мөн бошиглогч Нифай шиг хайраар тусламжийн гараа сунгаж байгаа билээ. Та нар ч бас тэдний нэгэн адилаар саналыг тань хүлээн авах хүмүүсийн өмнөөс баяр баяслыг мэдрэх болно. Түүнчлэн холын төрөл садангуудынхаа дунд хийсэн номлолын үйлчлэлийн талаар:

“Тиймийн тул, бахархацгаая, тийм ээ, бид Их Эзэнээр бахархах болно; тийм ээ, бид баясах болно, учир нь бидний баясал дүүрэн байна; тийм ээ, бид Бурханаа үүрд магтан дуулах болно. Болгоогтун, хэн Их Эзэнд хэтэрхий их алдрыг өргөж чадах билээ? Тийм ээ, түүний агуу их хүчний тухай, мөн түүний нигүүлслийн тухай, мөн хүмүүний үрсэд хандах түүний тэсвэрийн тухай хэн хэтэрхий ихийг хэлж чадах билээ? Болгоогтун, би та нарт хэлнэ, би өөрийн мэдэрч байгаагийнхаа хамгийн бага хэстийг ч хэлж чадахгүй” (Алма 26:16) хэмээн Аммоньхтой адил агуу сэтгэл ханамж мэдрэхийг ч та нар хүсэн хүлээж байж болох юм.

—Гэр бүлийнхэн нь хаана ч байсан гэсэн, тэдний



төлөөх та нарын хайрын мэдрэмж бол Елиа ирэх болно хэмээх амлалтын биелэлт мөн гэдгийг би гэрчилж байна. Тэрбээр ирсэн. Хүүхдүүдийн зүрх сэтгэл эцгүүд рүүгээ мөн эцгүүдийн зүрх сэтгэл хүүхдүүд рүүгээ эргэж байна (Малахи 4:5–6; Иосеф Смит—Түүх 1:38–39-ийг үзнэ үү). Та нар өвөг дээдсийнхээ нэрийг олж, тэдгээрийг ариун сүмд аваачихаар өдөөгдсөн үедээ энэхүү бошиглолын биелэлтийг мэдэрдэг билээ.

Зүрх сэтгэл эргэнэ гэсэн амлалт биелж буй цаг үед амьдрах нь адислал юм. Милдрэд Бэннион Айринг

тэрхүү өдөөлтийг сэтгэл зүрхэндээ мэдэрсэн юм. Тэрээр ахынхаа гэр бүлийг хайрладаг байсан бөгөөд тэдэнд тусламжийн гараа

сунгасан. Авга эгч Мид өөрсдөд нь хайртайг мэдсэн учраас л түүн рүү эргэх зүрх сэтгэлийнхээ хайрыг тэд мэдэрсэн ажээ. ■

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та айлчилж очих хүмүүстээ Елиагийн сүнсний тухай бошиглолыг уншиж өгөхийг хүсэж болно (Малахи 4:5–6; Иосеф Смит—Түүх 1:38–39-ийг үзнэ үү). Индексжүүлэлт, гэрэл зураг авах ба блог хөтлөх зэрэг арга хэрэгслүүдээр дамжуулан гэр бүлийн түүхийн ажилд оролцох арга замуудын талаар ярилцаарай. Таны айлчлан очсон хүмүүс FamilySearch.org-тай танилцаж амжаагүй байвал цаг гарган, үүнийг тэдэнд үзүүлэхийг бодоорой.

Эмээгээ мэддэг болсон минь

Жювилин Картэр



Би Залуу эмэгтэйчүүдийн төслүүдийн нэг болгож АНУ-ын Аризонагийн Меса дахь гэр бүлийн түүхийн төвд буй олон бичил хальсыг гүйлгэн үзэж, эмээдээ өвөг дээдсийнхээ мэдээллийг олоход нь туслахаар сайн дураараа шийдсэн юм. Эмээтэйгээ зэрэгцэж суугаад гэр бүлийн-

хээ тухай ярилцаж байхдаа би: “Би чинь яг одоо дэргэдээ сууж байгаа эмээгийнхээ тухай тийм их юм мэддэг бил үү?” хэмээн бодлоо.

Бид хоёр гэр бүлийнхээ олон гишүүний тухай олж мэдэн, мэдээллүүдийг нь бэлтгээд тэдний өмнөөс баптисм хүртэж, гишүүний баталгаа хийлгэхээр Аризонагийн Меса ариун сүм рүү очлоо. Үүнээс хойш удалгүй эмээ минь надад гэр бүлийнхээ түүхийг эмхэтгэсэн зузаан хавтсаа өгсөн юм.

Эмээ маань үе мөчний өвчтэй учраас түүний хувьд юм шивж бичих нь их зовиуртай байдаг бөгөөд компьютер дээр ажиллахад нь би түүнд туслах дуртай. Бид гэр бүлийнхээ сүнсэлг ашиг тусын тулд эмээгийнхээ амьдралын түүхийг хамтдаа бичдэг. Би эдгээр төсөл дээр хамтран ажиллах үедээ сүмийн түүхийн талаар маш их зүйл мэдэж авч, эмээгийнхээ амьдралын нэгээхэн хэсэг болсондоо дуртай байна.

Зохиогч нь АНУ-ын Виржиниад амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Гэр бүлийн хайр

Гэр бүлийнхэн бие биенээ хайрлацгаах юм бол

Тэнгэрийн таалалд нийцнэ;

Гэр бүлийнхэн бие биенээ хайрлацгаах юм бол

Аз жаргал бялхана.

(“Гэр бүлийн хайр,” Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х. 44)

Тэнгэрлэг Эцэг биднийг гэр бүлээ хайрлаасай гэж хүсдэг бөгөөд ингэснээр бид аз жаргалтай байж чадна. Бид гэр бүлийнхэндээ үйлчлэх тусам Тэнгэрлэг Эцэгийг болон гэр бүлийнхээ гишүүдийг улам их хайрлах болно.



Үүнтэй адил зүрхнүүдийг цаасан дээр зураад хайчил. Зургууд дээр урам хайрласан үгс бичих юм уу зураг зураад гэр бүлийнхээ гишүүдэд нууцаар өгч, энэ нь тэднийг хэр зэрэг баярлуулахыг хараарай!

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдээж авахаар эрэлхийл. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшлалтаар дамжуулан харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг reliefsociety.lds.org—ээс үзнэ үү.

Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Өмгөөлөгч

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Есүс Христ бол Эцэгийн өмнө бидний өмгөөлөгч юм. Өмгөөлөгч гэдэг үг латин гаралтай бөгөөд “өөр хүний өмнөөс гуйх” гэсэн утгатай.¹ Аврагч ойлголцол, шударга ёс болон нигүүлслийг ашиглан бидний өмнөөс гуйдаг. Үүнийг мэдэх нь хайр ба Түүний Цагаатгалын төлөөх талархлаар биднийг дүүргэж чадна.

“Эцэгийн өмнө өмгөөлөгч болох [Есүс Христийг], түүний өмнө та нарын өмнөөс гуйх намайг анхаарагтун—

“Өгүүдрүүн: Эцэг минь, нүгэл үйлдээгүй, таны таалад нийцсэн түүний зовлон хийгээд үхлийг болгоогтун; мөн Хүүгийнхээ асарсан цусыг, мөн та өөрөө алдаршихын тулд таны өгсөн, бас түүний цусыг болгоогтун;

“Иймийн тул, Эцэг минь, тэд надад ирж бас мөнх амьдралыг авч болохын тулд миний нэрэнд итгэх эдгээр ах дүүсийг минь



өршөөгөөч” (С ба Г 45:3–5).

Бидний өмгөөлөгч Христийн тухай Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон: “Би ямар ч үед, ямар ч нөхцөлд байсан залбирлаар дамжуулан ач ивээлийн сэнтийд хүрч, Тэнгэрлэг Эцэг маань миний гуйлтыг сонсож мөн ямар ч нүгэл үйлдээгүй хэрнээ цусаа урсгасан миний өмгөөлөгч өмнөөс минь гуйна гэдэг бол миний хувьд агуу ач холбогдолтой зүйл юм” гэж хэлжээ.²

Нэмэлт судрууд

Мозая 15:8–9; Моронай 7:28; Сургаал ба Гэрээ 29:5; 110:4

Үүнийг эргэцүүлэн бод

Бусдад нигүүлсэл болон уучлал үзүүлэхэд Есүс Христийн өмгөөлөл бидэнд хэрхэн сүнслэгээр нөлөөлж чадах вэ?

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Jesus Christ—Our Master and More” (Бригам Янгийн Их Сургуулийн галын дэргэдэх ярилцлага, 1992 оны 2-р сарын 2), 4; speeches.byu.edu.
2. Д. Тодд Кристоффэрсон, “I Know in Whom I Have Trusted,” *Ensign*, 1993 оны 5-р сар, 83.
3. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 180-ыг үзнэ үү.



Итгэл, гэр бүл, халамж

Судруудаас

Их Эзэний сүмийн түүхийн туршид Есүс Христийн эмэгтэй дагалдагчид Түүний үлгэр жишээг дагасаар ирсэн билээ. Естер итгэлтэй бөгөөд зоригтой байв. Түүний үеэл Мордехаи иудейчүүдийг устгахаар хааны гаргасан зарлигийн эх бичгийн хуулбарыг түүнд илгээж, “хаан уруу орж . . . өөрийн ард түмнийхээ төлөө гуйхыг тушаав.” Тэрээр цааш нь: “Чиний хааны эрх дарханд хүрсэн нь энэ цагийн төлөө ч юм бил үү, хэн мэдэх вэ?” (Естер 4:8, 14) хэмээн хэлжээ.

Естер өөрийн хүмүүсийн төлөө аюулыг үл хайхран, “Энэ нь хуулийн дагуу биш ч би хаан дээр орно. Хэрэв би үхэх бол үхнэ” (Естер 4:16) хэмээн хүлээн зөвшөөрсөн юм.

Тэгээд Естер даруухнаар хаанд хандан “хөлд нь унан уйлж, . . . иудейчүүдийн эсрэг . . . хуйвалдааныг болиулахыг түүнээс гуйв.” Мөн тэрээр “Учир нь би миний ард түмэнд учрах аюулыг хэрхэн харж тэвчих билээ?” гэсэн байдаг (Естер 8:3, 5–6-г үзнэ үү). Хааны зүрх зөөлөрч, түүний гуйлтыг зөвшөөрсөн юм.³

2014 ОНЫ 4-Р САРЫН ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

Та 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулганы талаар тоймлон үзэхдээ амьд бошиглогч, төлөөлөгчдийн болон сүмийн бусад удирдагчийн саяхан заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд эдгээр хуудсыг (мөн дараагийн дугаарууд дахь Чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.

СУРГААЛЫН ЧУХАЛ ХЭСЭГ



Гэрлэлт ба ариун явдал

“[Саяхан] Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын чуулгаас дэлхий даяарх сүмийн удирдагчдад хандан, нэгэн захидал илгээсэн юм. Тэрхүү захидалд “Иргэний хуулийн өөрчлөлт нь Бурханы тогтоосон ёс суртахууны хуулийг өөрчлөхгүй, өөрчилж ч чадахгүй. Нийгмийн хандлагаас эсвэл үзэл бодлын ялгаанаас үл хамааран Бурханы зарлигуудыг сахиж, тууштай байхыг Бурхан биднээс хүсдэг. Түүний ариун явдлын хуулинд зөвхөн хуулийн дагуу албан ёсоор эхнэр, нөхөр болж гэрлэсэн эрэгтэй, эмэгтэй хүний хоорондох бэлгийн харилцаа л зөв зохистой юм” хэмээн тодорхойлжээ.

Дэлхий ертөнц Их Эзэний ариун явдлын хуулиас холдсон ч бид дагасан хэвээр байгаа билээ. . . .

Олон орны засгийн газар болон сайн санаат хувь хүмүүс гэрлэлтийг

олон удаа шинээр тодорхойлсон хэдий ч Их Эзэн тэгээгүй юм. Эхлэлд Бурхан гэрлэлтийг эрэгтэй, эмэгтэй хүний хооронд буюу Адам, Ева хоёрын хооронд байхаар санаачилсан. Тэрээр гэрлэлтийн зорилгуудыг насанд хүрэгчдийн хувийн сэтгэл ханамж, таашаалаас илүү, хамгийн чухал нь хүүхдүүд төрүүлж, өсгөж, хүмүүжүүлэх сайн орчинг бий болгох туйлын зорилгын улмаас урьдчилан төлөвлөсөн юм. Гэр бүлүүд бол тэнгэрийн эрдэнэс билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн, “Сүнслэг шуурганууд,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 19.

Ахлагч Андэрсэн хүнд хэцүү сэдвүүдийн талаарх асуултуудыг болон санаа зовних байдлыг хэрхэн зохицуулах талаар lds.org/go/andersen714 вэб хуудсанд тайлбарласан байгаа.

БОШИГЛОГДСОН АМЛАЛТ



зориг

“Бид зөв шийдвэр гаргахын тулд хэрэгтэй үед үгүй гэж, боломжтой үед тийм гэж хэлдэг байх нь зүйтэй учраас бидэнд зөв зүйл хийх зориг хэрэгтэй. . . .

Үүнээс гадна дотоод зориг гэдэг нь шоолуулах байсан тохиолдолд ч итгэлээ хамгаалж, найз нөхдийнхөө дунд юм уу нийгэм дэх байр сууриа алдахаар байсан үедээ ч итгэлдээ үнэнч байж, зөв зүйл хийхийг хэлдэг. . . .

Бид урагш тэмүүлж, амьдрах ёстой зарчмуудынхаа дагуу амьдрах гэж хичээснээр Их Эзэнээс тусламж хүлээн авч, Түүний үгсээс тайтгарлыг олж чадах нь гарцаагүй.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Хүчтэй бөгөөд зоригтой бай,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 66, 67, 69.

Ерөнхийлөгч Монсоны хэлсний дагуу хэрхэн зоригтой байх талаар lds.org/go/monson2714 вэбсайтаас суралцана уу.

Авралын ажлыг яаравчлуулах нь

Зарим маш чухал сэдэв Ерөнхий чуулган дээр нэг биш удаа давтан яригддаг. Энд гурван хүн авралын ажлыг яаравчлуулах талаар үг хэлсэн байна:

- Ахлагч М.Рассэлл Баллард: “Таны [номлолын] захиас хэчнээн сайн байлаа ч та түүнийхээ араас байнга, шаргуу хөөцөлдөж, эцсийн үр дүнг үзтэл явахгүй л бол түүнийгээ хүргэх боломж олдохгүй ч байж мэднэ”¹ гэжээ. Ахлагч Баллардын энэ урилгын талаар илүү ихийг суралцахыг хүсвэл lds.org/go/ballard714 вэбсайтад зочилно уу.
- Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Аризонагийн Гилбэрт ариун сүм нь . . . сүмийн үйл ажиллагаа явуулж буй 142 дахь ариун сүм юм. . . . Одоо зарлагдаад

байгаа ариун сүмүүд баригдаж дуусах үед бид дэлхий даяар, үйл ажиллагаа явуулж байгаа 170 ариун сүмтэй болно”² хэмээн хэлсэн юм. Илүү дэлгэрэнгүйг lds.org/go/monson714 вэбсайтаас үзнэ үү.


- Линда К.Бертон: “Бид ‘дэлхийн зүйлүүдийг хойш тавьж, . . . гэрээнүүдээ итгэлтэйгээр сахиж,’ [С ба Г 25:10, 13] мөн Христэд ирж, Түүнийг дагах ёстой. Энэ бол шавь нарын хийдэг зүйл билээ!” гэж хэлсэн³. Бертон эгчийн хэлсэн үгийг lds.org/go/burton714 вэбсайтаас үзнэ үү.

ЭШЛЭЛҮҮД

1. “Эцсийн үр дүнг үзэх хүртэл хамт явах” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 78.
2. “Чуулгандаа тавтай морилно уу,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 4.
3. “Ажлыг яаравчлуулах гар болон зүрх сэтгэлтэй хүмүүс хэрэгтэй байна,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 122.



Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг уншиж, үзэж, сонсох юм уу бусадтай хуваалцахын тулд conference.lds.org вэбсайтаар зочилно уу.



“УГИЙН БИЧГИЙН ЦУГЛААН”-ЫГ ХЭРХЭН ЯВУУЛАХ ВЭ

“Олон жил хүлээсний эцэст гэр бүлүүд авралын энэ агуу ажлыг хийж дуусгахад шаардагдах сургаал, ариун сүм болон дэвшилтэт техник технологи бүгд бидэнд байна. Би [гэр бүл бүрийг] “Угийн бичгийн цуглаан” хийхийг санал болгож байна. Цуглааныг байнга хийж байх хэрэгтэй.”

Ахлагч Квинтин Л.Кук, “Үндэс ба мөчрүүд,” *Лиахона*, 2014 оны 5-р сар, 47.

1. Гэр бүлээрээ цугларч, гэр бүлийн баримт бичиг, түүх, зургуудыг мөн үе дамжин хэрэглэж ирсэн эд зүйлсийнхээ талаар хуваалц.
2. Түүх, гэрэл зургуудыг Family Tree буюу Гэр бүлийн мод руу оруулж, эх баримтуудыг өвөг дээдэстэйгээ холбо.
3. Ариун сүмийн ямар ёслолууд хийх шаардлагатай болохыг тодорхойлж, гэр бүлийнхээ гишүүдэд ариун сүмийн ажил хийх үүрэг даалгавар өг.

Ахлагч Күкийн хэлснээр бид гэр бүлийн түүхийн ажлаар дамжуулан адислагдах болно. Энэ талаарх өөр эх сурвалжуудыг lds.org/go/cook714 вэбсайтаас авна уу.

БИД АРИУН СҮНСНИЙ ХҮЧЭЭР ЗААДАГ

Есүс Христийн сайн мэдээг Ариун Сүнсний хүчээр заах нь Бурханы авралын ажлын амин чухал хэсэг гэдэгт бид итгэдэг. Үр дүнтэй заах нь хүмүүст өөрсдийн итгэлийг болон сайн мэдээний дагуу амьдрах хүслээ нэмэгдүүлэхэд тусалдаг. Хичээл заах болон сүм дээр үг хэлэх гэх мэт олон янзын аргаар зааж болно. Бид түүнчлэн гэр бүлийнхээ гишүүнтэй судрын талаар хэлэлцэж байхдаа ч юм уу хөршдөө санваарын тухай тайлбарлаж байх үедээ ч мөн зааж байдаг.

“Мөн дахин, энэ сүмийн ахлагчид, санваартнууд хийгээд багш нар Библи хийгээд сайн мэдээний бүрэн байдал байгаа Мормоны Номон дахь, миний сайн мэдээний зарчмуудыг заах ёстой.

“Мөн тэд гэрээнүүд хийгээд сүмийн тунхгуудыг биелүүлэхийн тулд анхааралтайгаар дагах ёстой, мөн эдгээр нь тэд Сүнсээр чиглүүлэгдэх үед тэдний заадаг зүйлс байх ёстой.

“Мөн уг Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно; мөн хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй” (С ба Г 42: 12–14).

Үр дүнтэй заахын тулд дараах дөрвөн зарчмын талаар бодож үзээрэй:

- **Заадаг хүмүүсээ хайрла.** Тэднийг таньж мэд. Мөн заахаар бэлтгэх үедээ тэдний хэрэгцээний талаар залбиран, бодож үзнэ үү. Өөр өөр арга нь өөр өөр хүмүүст хүрч чаддаг тул олон янзын заах арга барил ашиглахыг хичээгээрэй (баруун гар тал дахь зарим санаануудыг хараарай).
- **Сүнсээр заа.** Нифай: “Хүн Ариун Сүнсний хүчээр ярихад Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрх сэтгэлд хүргэдэг” (2 Нифай 33:1) хэмээн заасан юм. Та заах үедээ гэрчлэлээ хуваалцаж, судруудыг болон хожмын үеийн бошиглогчдын заасан зүйлсийг ашигласнаар Ариун Сүнсний нөлөөг урьж чадна. Та заахаар бэлтгэх үедээ Ариун Сүнсний удирдамж хүлээн авахын төлөө залбир. Хэрхэн хамгийн сайн заахаа мэдэхэд тань тэр сүнслэгээр нөлөөлж чадна.
- **Сургаал заа.** Сүмээс зөвшөөрөгдсөн сургалтын материалууд болох судрууд, Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс ба гарын авлагууд нь

сургаалыг—Бурханаас ирсэн мөнхийн үнэнүүдийг агуулдаг.

- **Хичээнгүйлэн суралцахыг хүс.** Заах үедээ та сонсож буй хүмүүс өөрсдөө суралцах үүрэг хариуцлагатайг санаарай. Асуулт асууж, сэдэвтэй холбогдуулан бодол санаагаа хуваалцахад мөн сайн мэдээний зарчмуудаар хэрхэн амьдарч болохыг тунгаан бодоход тэднийг урамшуулан дэмжээрэй. Зарчмуудын дагуу амьдарснаар уг зарчмуудын талаарх тэдний гэрчлэл өсөх болно (Иохан 7:17-г үзнэ үү).

Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли (1910–2008) сайн заах нь хэчнээн чухал болох талаар: “Эрэгтэй, эмэгтэй хүмүүс амьдралаа өөрчилж, сахилга баттай болохуйц *тийм үр дүнтэй заалгасан* үед л мөнх амьдрал ирдэг. Тэд зөв шударга байдалд буюу тэнгэрт албадлагаар хүлээн авагдахгүй. Тэд удирдагдах ёстой бөгөөд энэ нь заах гэсэн үг юм” гэж хэлсэн билээ (Жэффри Р.Холланд, “A Teacher Come from God”-д эш татжээ *Ensign*, 1998 оны 5-р сар, 26). ■

Дэлгэрэнгүй мэдээллийг Сургаал ба Гэрээ 50:13–22; Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 5.5.4-өөс үзнэ үү.

Дараах заах аргууд нь өөр өөр байдлаар суралцдаг хүмүүст ойлгомжтой заахад тусалж чадна:



Ариун дуоллуудыг тогло эсвэл дуулна уу. Сүмийн дуулал болон Хүүхдийн хэсгийн дуунууд нь сургаалыг заахын хамт Их Эзэний Сүнсийг урьдаг.



Урам өгөх түүх болон жишээнүүдээс ялангуяа судрууд болон амьдралынхаа түүхүүдээс хуваалц.



Зааж буй хүмүүсээ тунгаан бодоход хүргэх мөн санаа бодол, мэдрэмжийнхээ талаар хуваалцахад урамшуулан дэмжих асуултууд тавь.



Зураг ба биет зүйлс үзүүлнэ үү. Сайн мэдээний зарчмуудыг үр, чулуу, ургамал, эдгээртэй төстэй бусад зүйлстэй адилтгаж болно.

Зааж буй сайн мэдээний зарчмуудынхаа талаар гэрчлэлээ хуваалц. Гэрчлэл нь үнэнийг батлагч Ариун Сүнсийг урьдаг.



АВРАГЧТАЙ АДИЛ УДИРДАХ НЬ

Рян Карр

Сүмийн сэтгүүлүүд

Дэлхийн хамгийн муу удирдагчид ба төгс удирдагч, дэлхийн Аврагчийн хооронд эрс тэс ялгаа байдаг. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) тайлбарлахдаа: “Хүн төрөлхтөнд хамгийн эмгэнэлт нөлөө үзүүлсэн түүхийн тэдгээр удирдагчдад Галилын Хүнд байсан чанаруудаас ямар нэг хэмжээгээр байгаагүй учраас л жинхэнэ эмгэнэлтэй байсан юм. Есүс амь биеэ үл хайрладаг байсан бол тэд амин хувиа хичээдэг байсан. Есүс эрх чөлөөг эрхэмлэдэг байсан бол тэд эрх мэдлийг хүсдэг байлаа. Есүс үйлчлэлийг эрхэмлэдэг байсан бол тэд байр суурийг шүтдэг байв. Есүс бусдын жинхэнэ хэрэгцээг хангадаг байсан бол тэд зөвхөн өөрсдийн хэрэгцээ болон хүсэл таашаалыг хангадаг байлаа. Есүс дагалдагчдынхаа өсөлт хөгжилд санаа тавьдаг байсан бол тэд мөнх бус хүмүүсийг атган захирахыг хүсдэг байв. Есүс шударгаар тунгааж дэнсэлсэн нинжин сэтгэлээр дүүрэн байсан бол тэд ихэвчлэн хахир хатуу зан авир болон шударга бус явдлаар дүүрэн байсан” гэжээ.¹

Бид Их Эзэний сүм дэх удирдагчдын хувьд амжилттай байхын тулд Түүний үлгэр жишээг дагах ёстой. Дараах санаанууд нь Христтэй илүү адил удирдагч болоход бидэнд тусалж чадна.

Христтэй адил удирдагчид Тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлэхээр эрэлхийлэн, “Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулан” (С ба Г 4:5) үйлчилдэг. Аврагч “Би Өөрийнхөө хүслийг хийхийн тулд бус, харин Намайг Илгээгчийн

хүслийг хийхийн тулд тэнгэрээс бууж ирсэн юм” (Иохан 6:38) гэжээ.

Христтэй адил удирдагчид “маханбодийн гарт” (2 Нифай 4:34) найдлага тавьдаггүй. Тэд Их Эзэнийг хүлээж; авьяас, чадвартаа тулгуурлахын оронд Түүний ажлыг Түүний цаг хугацаанд, Түүний арга замаар хийхийг эрэлхийлдэг.

Христтэй адил удирдагчид сүм албан тушаал эрэлхийлдэггүй. Тэд дуудлагат ажлуудыг тушаал дэвших бус харин үйлчлэх боломж гэж үздэг. Мөн тэд дуудлагаас чөлөөлөгдөхийг тушаал буурч байгаа мэт үздэггүй. Дуудлага бүрээс чөлөөлөгдөх нь хэвийн явдал юм.

Христтэй адил удирдагчид үйлчилдэг хүмүүстээ тусалж, зааж, урамшуулан дэмждэг. Тэд Аврагчтай адил: “Тэрээр энэ дэлхийн төлөө бус аваас ямар ч зүйлийг эс хийх авай” хэмээн бусдыг адислахыг эрэлхийлдэг юм (2 Нифай 26:24). Тэд өөрсдийгөө бусдад Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход нь туслахаар дуудагдсан Их Эзэний төлөөлөгчид гэж үздэг.

Христтэй адил удирдагчид бусдад өсч хөгжихөд нь туслахыг эрэлхийлдэг. Ерөнхийлөгч Кимбалл:

“Есүс дагалдагчидтайгаа өөрийн ажлыг хуваалцах хүртлээ тэдэнд хангалттай итгэдэг бөгөөд

“ГЭХДЭЭ НАДАД ЯМАР Ч УДИРДАХ ТУРШЛАГА БАЙХГҮЙ ШҮҮ ДЭЭ!”

Хэрэв танд арвин туршлага байхгүй бол бүү санаа зов. Та илчлэлтээр, Эрх мэдэл бүхий нэгнээр дуудагдсан билээ (Итгэлийн Тунхаг 1:5-ыг үзнэ үү). Их Эзэн таныг хэн болж чадахыг тань л хардаг. Таны хувьд удирдах дуудлага тань хүч чадлаа хөгжүүлж, сул талуудаа даван туулах боломж байж болно.

Бизнесийн болон бусад байгууллагын хувьд удирдагчийн боловсрол, туршлага хамгийн чухал шаардлагатай байх нь олонтоо тохиолддог. Харин Их Эзэний арга зам бол өөр юм. Ерөнхийлөгч Лорэнзо Снеү (1814–1901): “Бурханы дуудсан, Бурханы Хүү Есүсийн дуудсан төлөөлөгчид боловсролгүй байсан бөгөөд тэд шинжлэх ухааныг ойлгодоггүй мөн Иудейд өндөр албан тушаал хашдаггүй байсан. Тэд ядуу зүдүү, бичиг үсэгт тайлагдаагүй, эгэл даруухан амьдралтай байсан. . . . Тэгэхээр Их Эзэн бол өөр юм. Тэр Өөрийн дуудлагыг хүмүүний дуудлагаас өөрөөр өгдөг” хэмээн заажээ.¹ Аз болоход, Их Эзэн дуудсан хүмүүсээ тэнцэхүйц болгодог!²

ЭШЛЭЛҮҮД

1. *Teachings of Presidents of the Church: Lorenzo Snow* (2012), 151.

2. Томас С.Монсон, “Duty Calls,” *Liahona*, 1996 оны 7-р сар, 42-ыг үзнэ үү.



СҮМИЙН ГИШҮҮДДЭЭ ЗӨВЛӨГӨӨ ӨГДӨГ УДИРДАГЧДАД ЗОРИУЛАВ

Өөрийн тань тусламж хэрэгтэй байгаа сүмийн гишүүдтэй уулзах үед тэд асуудлаа танаар шийдвэрлүүлэхийг хүсэж болох юм. Гэвч ингэх нь тэдний хувийн өсөлт хөгжлийг үгүй болгож мэднэ. Тэд шийдлийг тэр даруй олно гэсэн хүлээлттэй ирж магадгүй. Гэвч ихэнх тохиолдолд тэд асуудлуудаа шийдвэрлэхийн тулд өөрсдөө удаан хугацаагаар ажиллах хэрэгтэй байдаг. Эдгээр нь нийтлэг бэрхшээлүүд юм. Санваарын удирдагчдын санал болгосон дараах асуултууд гишүүддээ зөвлөгөө өгөхөөр бэлтгэх үед танд тусалж чадна:

- Та гишүүддээ сорилт бэрхшээлийг даван туулах нь тэдний өөрсдийнх нь үүрэг хариуцлага гэдгийг ойлгуулах замаар зөвлөж, тусалдаг уу?
- Та гишүүдийг өөрсдөө хариултаа олоход нь удирдан чиглүүлдэг үү?
- Тэд хийхийг зөвшөөрсөн зүйлсээ хийж байгаа эсэхийг та эргэн шалгадаг уу?
- Та тэдэнд асуудлуудаа шийдэх нөөц боломжуудыг олоход нь тусалдаг уу?
- Та тэднийг Их Эзэнд хандан залбирахад урамшуулан дэмждэг үү?
- Таны зөвлөгөө гишүүдийг өсөж хөгжихөд урамшуулан дэмждэг үү?

Мэдээж, нөхцөл байдал бүр өөр байдаг учраас Сүнсний удирдамжийг дагах нь чухал юм. Хайр, тэвчээр, сүнслэг мэдрэмжээр үйлчлэх нь сайн үр дүн авчрах болно.

ингэснээр тэд өсч хөгжиж чаддаг. Энэ бол Түүний удирдах чадварын хамгийн агуу жишээнүүдийн нэг юм. Хэрэв бид ямар нэг ажлыг илүү хурдан, илүү үр дүнтэй хийхийн тулд үүнийг бусдын оролцоогүйгээр хийсэн тохиолдолд уг ажил сайн хийгдсэн ч бай, биднийг дагадаг хүмүүсийн өсөлт хөгжил түүнээс хавьгүй илүү чухал юм. . . .

“Есүс хүмүүст тэдний чадварт тохирсон шударга үнэнүүдийг болон ажил үүргийг өгдөг байсан. Тэрээр тэдний хийж чадахаас илүү зүйлийг өгдөггүй байсан ч бодгалийг нь

бүрэн ажиллуулах зүйлийг өгдөг байв” гэж заажээ.²

Бошиглогч Иосеф Смит хүмүүсийг хэрхэн удирддагаа: “Би тэдэнд зөв зарчмуудыг заадаг харин тэд өөрсдийгөө захирдаг” хэмээн маш сайхан дүрсэлсэн юм.³ Энэ бол Их Эзэний удирдах арга барилын амин чухал хэсэг мөн. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Спэнсэр В.Кимбалл, “Jesus: The Perfect Leader,” *Ensign*, 1979 оны 8-р сар, 7.
2. Спэнсэр В.Кимбалл, “Jesus: The Perfect Leader,” 6.
3. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: *Иосеф Смит* (2007), 284.

ЕЛИА

“Елиа бол хамгийн агуу бошиглогчдын нэг байсан бөгөөд Их Эзэн түүнд лацдах хүчийг өгсөн юм.”¹ —Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972)

Би Израилын хойд хаант улсад тохинуулдаг бошиглогч байсан.² Израилчуудын ёс бус байдлын улмаас би бороо оруулахгүй байхаар тэнгэрийг лацдаж, уг нутагт өлсгөлөн бий болгосон. Өлсгөлөнгийн үеэр би нэгэн горхины хөвөөнд амьдарч байсан бөгөөд хэрээнүүд надад хоол авчирдаг байлаа. Гэвч удалгүй горхи хатаж ширгэсэн юм.³

Их Эзэн надад Зарефатад амьдардаг нэгэн бэлэвсэн эмэгтэй рүү очихыг зарлигласан бөгөөд тэр намайг хооллох болно гэж хэлсэн. Тэр эмэгтэй өөртөө болон хүүдээ зориулан сүүлчийн хоолоо хийхээр түлээ түүж байхыг би олж харав. Хэрэв тэр намайг эхлээд хооллох юм бол “Эзэн энэ газрын гадарга уруу дахин бороо оруулж өгөх өдрийг хүртэл хул аяган дахь гурил ч дуусахгүй, тостой ваар ч хоосрохгүй” гэж би түүнд хэлсэн.⁴ Тэр итгэлтэй байсан бөгөөд Их Эзэн амлалтаа биелүүлсэн юм.

Намайг бэлэвсэн эмэгтэйн гэр

бүлтэй хамт амьдарч байхад хүү нь нас барав. Би тэгэхэд, “Миний Эзэн Бурхан, энэ хүүгийн амийг буцаан өгөөч гэж би Танаас гуйж байна” гэж хэлэв.⁵ Их Эзэн миний залбирлыг сонссоноор түүний хүү амилав.⁶

Дараа нь би Баалын тахилчдыг тэмцэнд дуудаж, Их Эзэний хүчийг Израилын ард түмэнд үзүүлсэн юм. Тахилчид тахил бэлтгэж, доош гал илгээхийг хүсэн, Баалыг бүтэн өдөр дуудсан боловч ямар ч гал үзэгдсэнгүй. Би Израилын 12 овгийг төлөөлсөн 12 чулуугаар тахилын ширээ босгож, ширээг тойруулан шуудуу ухав. Тэгээд би тахилын ширээ болон шатаалт тахил дээр 12 домбо ус асгахад ус модыг норгож, шуудууг дүүргэв. Намайг Их Эзэнийг дуудахад Тэрээр галыг доош буулгаж, шатаалт тахил болон тахилын ширээг шатааж, усыг ширгээв. Дараа нь би Их Эзэнд хандан залбирахад Тэрээр тэнгэрээс аадар бороо оруулав.⁷

Амьдралынхаа төгсгөлд би нас

бараагүй харин галт сүйхээр тэнгэрт одсон юм.⁸ Христийн мөнх бус тохинууллын үеэр би Хувиралтын уулан дээр үзэгдэж, Петр, Иаков, Иохан нарт санваарын түлхүүрүүдийг өгсөн.⁹

Хожмын өдрүүдэд би дахин үзэгдэж, “эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд уруу нь, мөн хүүхдүүдийнхийг эцгүүд уруу нь эргүүлэхээр” 1836 оны 4-р сарын 3-нд Көртлэндийн ариун сүмд ирж, лацдах хүчний түлхүүрүүдийг Иосеф Смит, Оливэр Каудери хоёрт сэргээж өгсөн билээ.¹⁰ ■

ЭШЛЭЛҮҮД

1. Жозеф Фийлдинг Смит *Answers to Gospel Questions*, эмхэтгэсэн Бага Иосеф Фийлдинг Смит, 5 боть.(1957–1966), 4:193.
2. Сударуудын удирдамж, “Елиа”; scriptures.lds.org-ийг үзнэ үү.
3. Хаадын дээд 17:1–7-г үзнэ үү.
4. Хаадын дээд 17:8–16-ийг үзнэ үү.
5. Хаадын дээд 17:21-ийг үзнэ үү.
6. Хаадын дээд 17:8–24-ийг үзнэ үү.
7. Хаадын дээд 18-ыг үзнэ үү.
8. Хаадын дээд 2:11-ийг үзнэ үү.
9. Матай 17:3; Сударуудын удирдамж, “Хувиралт”; scriptures.lds.org-ийг үзнэ үү.
10. Сургаал ба Гэрээ 110:13–16-г үзнэ үү.

ELIJAH RAISES THE WIDOW'S SON FROM DEATH. ROBERT TERRY. ELIJAH CONTENTS AGAINST THE PRIESTS OF BAAL. ЖЭРНИ ХАРСТОН; ELIJAH ASCENDING INTO HEAVEN. В. Х. МАРТЕСОН. СУМИЙН ТҮҮХИЙН МҮЗЕИ-ЗӨВШӨРТӨВӨР НИЙЛТЭВ; THE TRANSFIGURATION. КАРЛ ХЭНРИХ БЛОК. ДАЧИЙН ХИЛГЭДНИЙ ӨНДЭРСНИЙ ТҮҮХИЙН МҮЗЕИ-ЗӨВШӨРТӨВӨР НИЙЛТЭВ; ELIJAH APPEARING IN THE KIRTLAND TEMPLE. ДАНИЕЛ А. ЛОИС. ХЭРЭЭНИЙ ЗҮРГИЙГ КОЗНИСТОКСКИНСТОКС



АЖИЛ ХӨДӨЛМӨР БА БИЕ ДААХ ЧАДВАР

Өсвөр үеийнхэн болон хүүхдүүд шаргуу ажиллаж, бие дааж сурснаар тэд “амьдарч буй дэлхийдээ хувь нэмрээ оруулах”-аар бэлтгэж байгаа юм (*Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол* [2011], 40).

Энэ дугаарын 56–57-р хуудсанд Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Рандаал Л.Ридд аавтайгаа хамт барилгын ажил хийгээд сурсан зүйлийнхээ талаар хуваалцсан байгаа. Тэрээр шаргуу ажиллах, сайн хандлагатай байх болон Их Эзэний хаант улсыг байгуулахын ач холбогдлын тухай ярьж байна. Ридд ах бидэнд: “Тэгвэл хэн ажиллах хэрэгтэй вэ? Бид бүгд ажиллах хэрэгтэй! Ажил хөдөлмөр бол энэ амьдрал дахь бие даах чадварын болон амжилт бүтээл, баяр баясгалангийн эх ундарга мөн. Таныг ажлаа урам зоригтой, ханцуй шамлан хийхэд эргэн тойрны тань бүх хүн арвин ургац хурааж авах болно. Учир нь та үрийг нь суулгасан шүү дээ” гэж сануулжээ.

Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол* бидэнд “Өндөр зорилгууд тавьж, тэдгээрийг биелүүлэхийн төлөө шаргуу хөдөлмөрлөх хүсэлтэй бай” (40) гэж заадаг. Та өсвөр үеийнхэнд зориулсан мормон захиасууд доторх “Ажил

урагшилж байна” нэртэй видео бичлэгийг хүүхдүүдтэйгээ хамт үзэж болно (Гэрлэлт, гэр бүлтэй холбоотой бичлэгүүдийг mormonchannel.org/come-follow-me-аас үзнэ үү). Дараа нь хэд хэдэн зорилго тавьж, тэдгээрийг биелүүлэх төлөвлөгөө гаргахын тулд хамтран ажилла.

- Бид эерэг хандлагатай байх үед ажил хөдөлмөр хавьгүй амархан бүтдэг. Энэ дугаарын 58–59-р хуудсан дахь “Шавартай гуталтайгаа хоолой зөөсөн нь” нийтлэлийг уншиж, таны хандлага ажил хөдөлмөрт тань хэрхэн нөлөөлдөг талаар ярилц.
- “Залхуурлын нэг хэлбэр бол интернэт, видео тоглоом болон зурагт үзэх зэрэгт дэндүү олон цаг зарцуулж, цагийг үр бүтээлгүй өнгөрөөх явдал юм” (*For the Strength of Youth*, 40). Хүүхдүүдээсээ интернэт, видео тоглоом болон зурагтын ашиг тус болон хор хөнөөлийн талаар асуу. Эдгээр хэрэгсэл ямар үед анхаарал сарниулах зүйл боддог вэ? Үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрлөснөөс ямар адислалууд ирдэг вэ? Эдгээр адислалыг мэдрэхэд нь хүүхдүүдээ туслахын тулд бүх технологийг хэсэг хугацаанд хойш тавьж, ямар нэг төсөл дээр хамтран ажиллах талаар бодож үзээрэй.



ЭНЭ СЭДВИЙГ АГУУЛСАН СУДРУУД

Исаиа 55:2

2 Нифай 5:17, 27

Мозая 4:16–21

Сургаал ба Гэрээ 58:26–29

Иосеф Смит—Түүх 1:55

Хүүхдүүдэд заах зөвлөмж

- Номлогчийн ажил нь хүнд ажил бөгөөд бие дааж сурах нь хүүхдүүдийг энэхүү ажилд бэлтгэх болно. Номлогчдын хийж чаддаг байх ёстой гэрийн ажлуудын (жишээ нь, хувцас угаах, хоол хийх, цэвэрлэгээ хийх) жагсаалтыг хүүхдүүдтэйгээ хамт гарга. Дараа нь эдгээр ажлаас заримыг нь хамтдаа хий.
- Ридд ах өгүүлэлдээ “хамгийн чухал ажил бол Бурханы ажил” гэдгийг бидэнд сануулдаг. Танай гэр бүл Их Эзэний ажлыг хэрхэн урагшлуулж чадах вэ? Бусдыг Христэд илүү ойр авчрахын тулд хамтдаа хийж болох ямар нэг үйл ажиллагааг бодож олно уу.
- Бие даах чадварын нэг хэсэг бол мөнгөө хэрхэн зарцуулахыг сурах явдал юм. Төсөв хийх зарчмуудыг болон аравны нэгийг төсвийнхөө нэг хэсэг болгохын ач холбогдлыг хүүхдүүдэдээ заа. ■



Бразил

ДАХЬ СҮМ: ИРЭЭДҮЙ БИДНИЙ ҮЕД ИРЛЭЭ

Марк Л.Гровер

Бригам Янгийн Их Сургуулийн Латин Америк судлалын профессор асан

Бразил бол газар нутгийн хэмжээ, хүн амын тоогоороо дэлхийд тавд орох том улс юм. Гэвч 100 жилийн өмнө энэ улсын хүн ам нь таруу суурьшсан, цөөхөн хувь нь л халуун дулаан уур амьсгал, баялаг газар нутаг, асар их ашигт малтмал ба ус зэрэг байгалийн нөөцийн ашиг тусыг хүртдэг байлаа.

Макс Заф, Амали Заф хоёрт Бразил ихэд таалагдсан тул тэнд суурьшиж амьдрахаар шийджээ. Тэд 1908 онд Германд сүмд нэгдсэн бөгөөд 1913 оны 3-р сард Бразил руу цагаачилсан аж. Бразил дахь сүмийн анхны гишүүд болохынхоо хувьд тэд маш их ирээдүйтэй оронд амьдарч байгаадаа сэтгэл өндөр байв. Гэвч тэр үед сүм өмнөд Америкт зохион байгуулагдаагүй байсан учраас Макс, Амали хоёр сүмийн цуглаанд оролцож, сүмийн гишүүдтэй уулзах боломжгүйгээсээ ихэд гунигтай байгаагаа ойлгосон юм.¹

Макс Заф, Амали Заф хоёр Бразилд 10 жил амьдарсныхаа дараа Германаас Бразилын хойд муж Санта Катаринад дөрвөн хүүхэдтэйгээ болон сүмийн гишүүн бус нөхрийнхөө хамт 1923 онд цагаачилж ирсэн Аугуста Липпэлт гэгч сүмийн нэгэн итгэлтэй гишүүний талаар мэдэж авчээ. Зафын гэр бүлийнхэн Липпэлтийн гэр бүлтэй ойр байхын тулд Санта Катарина руу нүүсэн байна.

Хоёр жилийн дараа Аргентиний Буэнос-Айрэст Өмнөд Америкийн номлол нээгдэв. Номлолын хоёр дахь ерөнхийлөгч К. Б.Рэйнхолд Стүф герман гаралтай хүн байсан бөгөөд Бразилын өмнөд хэсэгт амьдардаг герман цагаачдын томоохон бүлгийн дунд сүм байгуулахаар сүнслэгээр нөлөөлөгджээ. 1928 онд тэрээр Виллям Фред Хайнз, Эмил А. Ж.Шиндлэр гэгч хоёр номлогчийг герман цагаачид олноор суурьшсан Жоинвилл хотод томилсон байна. 1930 онд Заф, Липпэлт хоёрын гэр бүлтэй ерөнхийлөгч Стүф очиж уулзсан ба сүмийн салбар байгуулснаар энэ хоёр гэр бүл хамтдаа сүмд очиж, ариун ёслолоос хүртэх боломжтой болсон ажээ.

100 жилд маш их зүйл өөрчлөгдсөн юм. 1913 онд Зафын гэр бүлийг ирэхээс өмнө Бразилд гишүүд ч, номлогчид ч мөн сүм ч байсангүй. Тэгвэл өнөөдөр Бразилд нэг сая гаруй гишүүн амьдардаг бөгөөд сүмийн хамгийн олон гишүүнтэй 3 дахь орон (Америкийн Нэгдсэн Улс, Мексик хоёрын дараа) болоод



Эдгээр номлогч 1930 оны сүүлчээр Рио де Жанейрод үйлчилсэн бөгөөд тэдний дотор Мормоны Номыг португал хэлээр орчуулахад тусалсан Даниел Шупэ байна.

улсаас гарч явах шаардлагатай болсон байна. Дайны дараа номлогчид эргэн ирж, ажил дахин эхэлсэн юм.

Кампинас хотод болон Сан Пауло мужид хэдэн залуу эрэгтэй, эмэгтэй сүмд нэгдэж, итгэлтэй хэвээр үлджээ. Тэдгээр анхны гишүүдийн нэг нь Антонио Карлос Камарго байлаа. Тэр 1947 онд өсвөр насандаа сүмд нэгдсэн ба сүмийн нэг гишүүнтэй болдог болж, улмаар түүнтэй гэрлэн, 1954 онд Бригам Янгийн их сургуульд, дараа нь Ютагийн их сургуульд суралцсан байна. 1963 онд тэрээр нэхмэлийн компанид ажилд орохоор эхнэртэйгээ Бразилд эргэж ирэхдээ сүмийн өсөж хөгжсөнийг хараад ихэд гайхжээ. 1954 онд тэднийг эх орноосоо явах үед энд америк номлогчдын удирдсан хэдэн жижиг салбар л байж. Гэтэл тэдний эзгүй байсан есөн жилийн

ТҮҮХЭН ҮЙЛ
ЯВДЛУУДЫН ОН
ДАРААЛАЛ

1928 он: Анхны номлогчид Жоинвилл дэх герман хэлтэй оршин суугчдын дунд үйлчлэхээр илгээгдэв

1930 он: Жоинвиллд анхны салбар байгуулагдав

▼ 1931 он: Жоинвиллд Өмнөд Америк дахь сүмийн эзэмшлийн анхны цуглааны байр онцгойлон адислагдав



► 1935 он: Сан Паулод төвтэй анхны номлол байгуулагдав



байна. Сүм одоо Бразилын бүх муж болон том хотуудад гишүүдтэй боллоо. Макс, Амали хоёрын үр удам ер бусын, сэтгэл догдлом түүхтэй, хүчирхэг бөгөөд эрч хүч оргилсон сүмийн ашиг тусыг хүртэж явна.

Царс мод хэрхэн ургадаг шиг өссөн нь

1926 онд Аргентинд Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Мэлвин Ж.Баллард (1873–1939) бошиглож хэлэхдээ энэ бүс нутагт сүм эхний үедээ аажим өсөх боловч хожмын нэгэн өдөр улам хүчирхэгжинэ гэжээ. Тэрээр: “Царс мод боргоцой байхаасаа удаан ургадаг шиг Их Эзэний ажил энд тун аажуухан өсөн нэмэгдэх болно. Энэ ажил тун хурдан ургаад үхдэг наран цэцэгтэй адилгүй байх болно” хэмээн бошигложээ.²

1935 онд нээгдсэн Бразилын номлолын эхний жилүүдэд цөөхөн хүн сүмд нэгджээ. Сүм голчлон герман хэлээр үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд 1940 онд энэ улсын албан ёсны хэл болох португал хэлэнд шилжсэн ажээ. Номлогчид улс орон даяар олон хотод үйлчилж байсан бөгөөд Дэлхийн II дайны улмаас тэд энэ

дотор бараг 16000 бразил хүн сүмд нэгдэж, тэдний дотор удирдах чадвар бүхий итгэлтэй залуу гэр бүл олон байв. “Тэд бол Сан Паулод Их Эзэний сонгосон агуу хийгээд нэр төртэй сүнснүүд байсан юм” хэмээн Антонио хэлсэн байдаг.³

1966 онд, Бразилын номлол нээгдсэнээс 31 жилийн дараа Өмнөд Америкийн анхны гадас Сан Паулод байгуулагдав. Тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүн байсан ахлагч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) гадсыг зохион байгуулж, Валтер Спатыг ерөнхийлөгчөөр, Антониог түүний хоёрдугаар зөвлөхөөр дуудсан байна.

Цөөхөн шинэ удирдагч л гадасны үйл ажиллагааг өмнө нь харсан байжээ. Гэвч Их Эзэн Антониог бэлдсэн байсан юм. Тэрээр Америкийн Нэгдсэн Улсад сүмийн үлэмж туршлага хуримтлуулсан байсан учраас гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд туслах боломжтой байв. Энэхүү анхны гадасны тойрог, салбаруудын удирдагчдаас дараа нь гадасны олон удирдагч төрөн гарсан билээ. Гадсуудыг зохион байгуулах ажил эрчимтэй явагдаж эхлэхэд тэдний нөлөө орон даяар тархсан юм.


Өсөлтийн эрин үе

Бразил дахь сүмийг улам бүр өсч хөгжихөд нөлөөлсөн нэгэн гэнэтийн мэдэгдэл нь ариун сүм барих мэдээ байлаа. Гишүүд ариун сүм чухал гэдгийг мэддэг байсан ч ихэнх нь үүнийг зөвхөн гэрэл зургаас л харсан байв. Хамгийн ойр орших ариун сүм АНУ-д хэдэн мянган бээр хол байжээ. Ерөнхийлөгч Кимбалл 1975 оны 3-р сард Бразилд айлчилж, бүсийн нэгэн чуулган дээр Сан Паулод ариун сүм барих тухай зарлажээ. Агуу их хүлээлт болон санхүүгийн золиослолоор ариун сүм 1978 онд баригдаж дууссан юм. Гишүүд хандив өргөснөөр ариун сүм барих зардалд тусалсан ажээ. Олон гишүүн хандивлах мөнгө олохын тулд автомашин, үнэт эдлэл мөн газраа зарсан байна.

бразилчууд болов. Эдгээр эргэж ирсэн номлогч хожим нь сүмийн орон нутгийн удирдагчид болсон ажээ.

Гэвч сүмийн өсөлт өөр нэгэн бэрхшээл үүсгэсэн нь сүмийн гишүүдийн туршлага нимгэнээс үүдэлтэй байлаа. Гэсэн хэдий ч энэ бэрхшээл гишүүдээс илүү их итгэл, илүү сүнслэг удирдамж шаардаж байсан тул эерэг үр дүн авчирсан билээ. Тухайлбал, зохион байгуулагдсан сүмийн бусад гадаснуудаас алс хол, Бразилын баруун хэсэг дэх Уругвайанад 1992 оны 11-р сард нэгэн гадас байгуулагджээ. Хосе Кандидо Феррэйра дос Сантос хэмээх итгэлтэй бөгөөд олон жил болж буй сүмийн гишүүн шинээр байгуулагдсан гадасны патриархаар дуудагдсандаа санаа нь ихэд зовж байжээ. Тэрээр ерөнхий эрх мэдэлтэнд хандан: “Би патриарх

► 1939 он:
Мормоны
Ном португал хэлээр хэвлэгдлээ



1954 он: Сүмийн ерөнхийлөгч Дэвид О. Макжэй анх удаа айлчлав

1959 он: Хоёр дахь номлол байгуулагдав

1966 он: Өмнөд Америкийн анхны гадас болох Сан Пауло гадас байгуулагдлаа

► 1978 он:
Өмнөд Америкийн анхны ариун сүм Сан Паулод онцгойлон адислагдлаа



1978 оны 10, 11-р сард ариун сүмийг онцгойлон адисалсан үйл явдал нь тэр оныхоо 6-р сард санваарын талаар өгөгдсөн илчлэлтийн дараа болсон юм (Албан Тунхаг 2-ыг үзнэ үү). Энэхүү илчлэлтийн ачаар Бразил дахь зохистой бүх гишүүн ариун сүмийн онцгойлон адислалт болон бусад адислалд оролцох боломжтой болсон ажээ.

Санваарын тухай илчлэлт болон ариун сүмийг онцгойлон адисалсан нь сүмийн түүхэн дэх номлолын хамгийн агуу амжилтуудын нэгд хүргэх хурдасгуур болсон байна. Хорин жилийн дотор 700000 гаруй бразил хүн сүмд нэгджээ.

Бусад үйл явдал энэхүү өсөлтийг түргэсгэж байв. Тус улсад хийгдсэн улс төр, нийгмийн чухал өөрчлөлтүүд ч бас энэхүү өсөлтөд түлхэц болж өгсөн юм. Олон бразил хүн хот суурин газрууд руу нүүж, шинэ шашнуудад илүү нээлттэй болж байлаа. Үүний зэрэгцээ ерөнхийлөгч Кимбалл Бразилаас номлолд үйлчлэх залуучуудын тоог нэмэгдүүлэх зорилго тавихыг Бразилын гадасны удирдагчдаас хүссэн байна. Удалгүй Бразилд үйлчилж буй номлогчдын талаас илүү хувь нь

болж чадахгүй ээ. Энэ талаар надад ямар ч ойлголт байхгүй. Би хэзээ ч патриарх хүнтэй уулзаж байгаагүй бас өөрөө ч патриархын адислалаа аваагүй байгаа шүү дээ” хэмээн тайлбарлажээ. Ерөнхий эрх мэдэлтэн түүнд нэг шийдэл санал болгосон байна. Зэргэлдээх хот Алегретэд Руи Антонио Давила гэдэг шинэ патриарх дуудагдаад удаагүй байлаа. Тэр мөн л түүнтэй адил байдалтай байв. Ингээд энэ хоёр патриарх бие биедээ патриархын адислал өгөх хэрэгтэй болсон юм.

Сантос ах Давила ахаас адислал авч байхдаа өнгөрсөн амьдрал, хувийн хүсэлтэй нь холбоотой патриархын адислалуудыг сонсоод ихэд гайхжээ. Сантос ах Давила ахын тэргүүн дээр адислал хэлэх үед ч мөн адил зүйл тохиолдож, Давила ахын нүднээс нулимс урсав. Дараа нь энэ хоёр ах болж өнгөрсөн зүйлийг гүнээ ойлгож, бие биенээ тэвэрчээ.⁴ Анхны патриархын адислалаа өгөхөд нь Сүнс тэдэнд нөлөөлсний адил зуу зуун адислал өгөхөд нь ч бас тэдэнд нөлөөлсөн билээ. Сүмийн хязгаарлагдмал туршлагатай оронд Их Эзэн ийм сүнслэг адислал олныг өгч байлаа.



Тасралтгүй Боловсролын Сан

Гишүүдийн боловсрол нимгэн байсан нь бас нэгэн бэрхшээл болж байв. Номлогчид гэртээ эргэж ирэхдээ сүнслэг байдлын хувьд бэлтгэгдсэн байдаг ч сайн ажилтай болоход боловсрол дутдаг байв. Сан Пауло дахь гадасны ерөнхийлөгч Рэиналдо Баррето: “ажил олох нь томоохон бэрхшээл байлаа. Олон номлогч өсөж хөгжих найдвараа, бүр цаашлаад номлолдоо олж авсан сүнслэг хүч чадлаа алдаж байв” гэж тайлбарласан юм. Олон тохиолдолд энэ бэрхшээлийг даван туулах түлхүүр нь боловсрол байв.

шийдвэр төгс байдалд оршдог юм. Жишээлбэл, нисэхийн компанийн удирдах ажилтан агсан Гэлсон Пиззириани Бразилд нисэхийн шинэ компани байгуулахад туслах чадвар сорьсон, өндөр цалинтай ажлын санал хүлээн авчээ. Мөн энэ үед тэрээр эхнэр Мириамынхаа хамт Бразилын Брасилиа номлолыг тэргүүлэхээр дуудагдсан байв. Яах ийх талаар эргэлзэх ч хэрэг байсангүй. Тэд өсвөр насандаа баптисм хүртсэнээсээ хойш амьдралаа сүмд зориулсан юм. Пиззириани ах гэрлэхээсээ өмнө салбарын ерөнхийлөгч байв. Тэрээр 25-тайдаа гадасны ерөнхийлөгчөөр



◀ 1985 он: Ахлагч Хэлио Р.Камарго Бразилаас дуудагдсан анхны ерөнхий эрх мэдэлтэн болов


1986 он: Бразил улс 50-иас дээш гадасны дөрөв дэх орон боллоо

1987 он: Бразилын бүс байгуулагдав

1993 он: Бразил улс 100 гадастай гурав дахь орон боллоо



◀ 1997 он: Сүмийн номлогчийг бэлтгэх хоёр дахь том төв Сан Паулд баригдав



2001 онд ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Тасралтгүй Боловсролын Санг үндэслэн байгуулснаар Бразилын мянга мянган эргэж ирсэн номлогчийг адисалсан юм. Уг сан тэдэнд сурч боловсрох, улмаар илүү сайн ажил олох боломж олгосон юм. Гишүүд гэр бүлээ дэмжиж, боловсролоо дээшлүүлэх илүү өндөр чадвартай болсон. Бразил дахь ТБС-ийн удирдагч болсон ерөнхийлөгч Баррето: “Залуу гишүүд боловсрол эзэмшиж, сайн ажилд орохыг харах нь адислал бөгөөд тэдний өөртөө итгэх итгэл нэмэгдэж буйг харах нь ч бас энэхүү хөтөлбөрийн жинхэнэ амжилт юм. Тэдэнд илүү их найдвар байгаа” гэж хэлжээ.⁵

Үнэнч гишүүд

Бразил дахь сүмийн хүч чадал нь зөвхөн гишүүдийн тоонд бус харин тэдний сайн мэдээнд бүхнээ зориулах

1999 оноос хойш мянга мянган бразил гишүүн Мормон тусч гараар дамжуулан амьдардаг газартаа үйлчилсэн байна.



БРАЗИЛ ДАХЬ СҮМИЙН ӨСӨЛТ

1935	1938	1948	1958	1968	1978	1988	1998	2008	2013
148	216	536	1454	31635	54410	265286	703210	1060556	1239166

БРАЗИЛ ДАХЬ СҮМ*

Гишүүн: 1239166

Гадас: 242

Номлол: 32

Ариун сүм: үйл ажиллагаа явуулж буй 6, баригдаж буй 2



* 2013 оны 11-р сарын байдлаар

дуудагдсан бөгөөд Бүсийн дал гэх мэт өөр олон дуудлага хүлээн авч үйлчилж байжээ. Пиззириани эгч гадасны болон тойргийн Халамжийн Нийгэмлэг, Залуу эмэгтэйчүүдийн бүлэг болон Хүүхдийн хэсгийн дуудлагуудад үйлчилж байсан юм. Тэрээр: “Би зарлигуудыг дагахыг хичээсэн учраас миний амьдрал бүрэн дүүрэн адислагдсаар ирсэн. Дуулгавартай дагасан зарлиг бүрийнхээ төлөө би адислал хүлээж авдаг” гэж сайн мэдээний адислалуудын талаарх мэдрэмжээ илэрхийлсэн байдаг.⁶

Тэд Брасилиа дахь номлолынхоо дараа Бразилын Кампинас номлолын ерөнхийлөгчөөр түр хугацаагаар үйлчлэхээр дуудагдсанаар гэртээ хэсэг зуур төвхнөн суух төлөвлөгөө нь өөрчлөгдөж байв. Түүнчлэн хэдэн



▲ 2000 он: Бразилын Рэсифэ, Порто Алэгрэ ариун сүмүүд онцгойлон адислагдлаа

2002 он: Кампинас ариун сүм онцгойлон адислагдав

2002 он: Мормон тусчгар Бразилын хамгийн чухал сайн дурын байгууллага болж, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдлөө



◀ 2008 он: Куритиба ариун сүм онцгойлон адислагдав



▲ 2012 он: Манаус ариун сүм онцгойлон адислагдлаа

сар амарсныхаа дараа тэд Бразилын Рэсифэ ариун сүмийн ерөнхийлөгчөөр үйлчлэх дуудлага хүлээн авч байжээ. Пиззириани ахад баптисм хүртээсэн номлогчдын нэг нь саяхан эхнэртэйгээ Рэсифэ ариун сүмд дуудагдаж; тийнхүү номлогч, хөрвөгч хоёр хамтдаа үйлчлэхээр болсон юм.

Их Эзэнд үйлчлэхийн тулд мэргэжлийнхээ ажлын саналаас татгалзсан Пиззирианигийн гэр бүлийн жишээ гүнзний сэтгэгдэл төрүүлэм явдал боловч Бразилын итгэлтэй гишүүдийн дунд энэ нь тийм ч ховор зүйл биш билээ.

Зафын гэр бүлийг Бразилд ирснээс хойших 100 жилд маш олон эерэг өөрчлөлт гарсан ч зарим хүндрэл бэрхшээл бас байсан юм. Гэсэн хэдий ч айлчилж очсон бошиглогчид энэ улсын ирээдүйд итгэлтэй байгаагаа илэрхийлэхдээ хэзээ ч эргэлзэж байгаагүй юм. Бразил улс эдийн засгийн өсөлт хөгжилтөөрөө дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд дээрх бошиглолууд биелэгдэж байна. Зафынхны үр удам болон сайн мэдээний дагуу тэдний араас замнасан хүмүүс сайн мэдээний үрийг тарихын тулд анхны гэгээнтнүүдийн шаргуу хөдөлмөр

ба хүчин чармайлтын үр дүнг хүртэж байна. Ахлагч Мэлвин Ж.Баллардын: “Мянга мянган хүн энд сүмд нэгдэх болно. Энд нэгээс илүү номлол бий болох бөгөөд сүм дэх хамгийн хүчирхэг номлолуудын нэг байх болно” хэмээн 1926 онд хэлсэн бошиглолын хоёр дахь хэсэг ийнхүү биелж байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Сибила Хак Нунэс (Макс, Амали Заф нарын ач охин), Майкл Ландоны хийсэн ярилцлага, Бразил, Куритиба, 2004 оны 7-р сарын 30, Сүмийн түүхийн номын сан.
2. Мэлвин Ж.Баллард, Браинт С.Хинкли, *Sermons and Missionary Services of Melvin Joseph Ballard* (1949), 100.
3. Антонио Карлос Камарго, Марк А.Гровэрын хийсэн ярилцлага, Сан Пауло, Бразил, 2006 оны 6-р сарын 27, Харолд Б.Лийгийн номын сан, х. 22.
4. Хосэ Кандидо Фэррейра дос Сантос, Марк А.Гровэрын хийсэн ярилцлага, Бразил, 2010 оны 5-р сарын 4, Харолд Б.Лийгийн номын сан; Руи Антонио Давила, Марк А.Гровэртой хийсэн ярилцлага, Рио Грандэ до Сул, Бразил, 2010 оны 5-р сарын 5, Харолд Б.Лийгийн номын сан.
5. Реиналдо дэ Сауза Баррето, Марк А.Гровэрын хийсэн ярилцлага, Сан Пауло, Бразил, 2006 оны 6-р сарын 16, Харолд Б.Лийгийн номын сан, х. 14.
6. Мириам да Силвиа Сулэ Пиззириани, Марк А.Гровэрын хийсэн ярилцлага, Бразил, Сан Пауло, 1982 оны 3-р сарын 21, Харолд Б.Лийгийн номын сан, х. 7.



Ахлагч
Рассэлл М.Нэлсон
Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын

Мормоны Ном, Израилын цугларалт ба Хоёр дахь ирэлт

Мормоны Ном ирсэн нь Их Эзэн Израилыг цуглуулж эхэлснийг болон Абрахам, Исаак, Иаков нарт өгсөн амлалтаа биелүүлж байгаагаа дэлхий дахинд нотлон харуулж буй бодит тэмдэг юм.

Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж номын 5-р бүлэг бүхэлдээ Мормоны Номонд зориулагдсан байдаг. Энэ бүлэгт Мормоны Номын талаар дараах зүйлүүдийг заадаг. Мормоны Ном нь:

- Манай шашны тулгуур чулуу.
- Есүс Христийг гэрчилдэг.
- Библийг дэмждэг.
- Бидний санаа бодлын гүн дэх зүрх сэтгэлийн асуултуудад хариулдаг.
- Хүмүүсийг Бурханд илүү ойртуулдаг.



Эдгээр мэдэгдэл нь туйлын үнэн боловч бүгд мөнх бус хүмүүс бидний үзэл бодлоос үүдэлтэй юм. Тэнгэр дэх Эцэг, Түүний Хайртай Хүү Есүс Христ хоёр Мормоны Номын талаар ямар үзэл баримтлалтай юм бол?

Тэдний үзэл баримтлалд эрт дээр үед бүх хүн төрөлхтөнд өгсөн хоёр амлалт нөлөөлсөн нь дамжиггүй. Хоорондоо холбоотой, баримт нотолгоотой, хүчин төгөлдөр хэвээр байгаа энэхүү хоёр амлалт хожмын нэгэн өдөр гүйцэлдэх болно. Эхнийх нь тараагдсан Израилыг цуглуулах Тэдний эртний амлалт билээ. Хоёр дахь нь Тэдний удаан хүлээж буй амлалт болох Их Эзэний Хоёр дахь ирэлт юм.

Абрахамын гэрээ ба Израилын угсаа

Абрахамын эрин үед Бурхан Абрахамын үр удамар дамжуулан бүх үндэстэн адислагдах болно гэсэн гэрээг Абрахам эцэгтэй хийсэн билээ. Энэхүү амлалтын

бусад чухал бүрэлдэхүүн хэсгүүд мөн өгөгдсөн юм. Анх Абрахамд өгөгдсөн эдгээр амлалт хожим нь Исаак, Иаков хоёрт мөн дахин баталгаажсан билээ:

- Тоо томшгүй үр удам.¹
- Тодорхой нутгийг өвлөх амлалт.²
- Абрахамын үр удам санваарыг бүх үндэстэнд хүргэснээр бүх хүн Абрахамын удам угсаагаар дамжуулан адислагдаж болно.³
- Абрахамын шууд удам биш боловч сайн мэдээг хүлээн авсан хүмүүс үрчлэлтээр дамжуулан Абрахамын үр удам болдог.⁴
- Дэлхийн Аврагч Абрахамын үр удамар дамжин ирнэ.⁵

Эртний Израилын овгууд болох Абрахамын үр удамынхнаас олон нь аажимдаа Их Эзэний заасан зүйлсийг эсэргүүцэж, бошиглогчдыг хөнөөсөн юм. Арван овог



Ассирт боолчлолд аваачигдсан билээ. Тэр цагаас хойш тэд хүн төрөлхтний цэдгүүдээс алдагдсан ч Их Эзэний хувьд алдагдаагүй юм. Хоёр овог богино хугацаагаар оршин тогтнож байсан ч эсэргүүцлийнхээ улмаас Вавилонд боолчлолд аваачигдсан билээ. Тэд эргэж ирэх үедээ Их Эзэний ивээлд байсан ч Түүнийг дахин эсэргүүцсэн юм!

Израилын тараагдалт ба цугларалт

Хайраар дүүрэн хэдий ч харамсан гашуудсан Эцэг Израилыг газар сайгүй тараасан ч нэгэн цагт тараагдсан Израил сүрэгтээ буцаан цуглуулагдах болно хэмээн амласан юм. Энэхүү амлалт нь Израилыг тараах амлалттай адил тов тодорхой байлаа.⁶ Жишээ нь, Их Эзэн хожмын өдрүүдэд энэхүү “тараагдсан мөн гөжүүд” хүмүүс рүү “шуурхай элч нарыг” (Исаиа 18:2, 7) илгээх болно гэдгийг Исаиа угтан харсан юм.

Бошиглогдсоны дагуу *бүх* зүйл энэ эрин үед сэргээгдэх ёстой байлаа. Тиймээс, тараагдсан Израилын удаан хүлээгдсэн цугларалт нь сэргээлтийн нэг хэсэг болж ирэх ёстой.⁷ Израилын цугларалт нь хоёр дахь амлалттай харилцан холбоотой юм. Учир нь цугларалт бол Их Эзэний Хоёр дахь ирэлтийн өмнөх зайлшгүй шаардлагатай удиртгал мөн.⁸ Тэнгэрлэг үзэл баримтлал ямагт тодорхой байдаг нь ахин харагдаж байна.

Цугларалттай холбоотой энэхүү үзэл баримтлал нь Есүс



Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн заадаг хамгийн чухал зүйлсийн нэг мөн. Их Эзэн “би та нарт нэгэн тэмдэг өгье-үүнд би өөрийн хүмүүсийг, Ай Израилын угсааг удаан хугацааны тараагдалтаас нь дотогш цуглуулах болно, мөн тэдний дунд өөрийн Сионыг дахин байгуулах болно” (3 Нифай 21:1) хэмээн тунхаглажээ.

Мормоны Ном ирсэн нь Их Эзэн Израилыг цуглуулж эхэлснийг болон Абрахам, Исаак, Иаков нарт өгсөн амлалтаа биелүүлж байгааг дэлхий дахинд нотлон харуулж буй бодит тэмдэг мөн.⁹ Бид энэхүү үзэл баримтлалыг заагаад зогсохгүй бас үүнд оролцдог билээ! Бид Их Эзэний сонгомол хүмүүсийг хөшигний хоёр талаас цуглуулахад туслах замаар үүнийг хийдэг.

“Христэд ирэх” (Иаков 1:7)¹⁰ урилга нь сайн мэдээний мэдлэггүйгээр нас барсан хүмүүст ч боломжтой гэдэг нь үнэхээр нигүүлсэнгүй хэрэг юм.¹¹ Хөшигний нөгөө талд буй хүмүүсийн өмнөөс хийгдэх бэлтгэлийн нэг хэсэг нь хөшигний наана амьдардаг хүмүүсийн зүгээс хүчин чармайлт шаарддаг. Бид угийн бичгээ хөтлөн цуглуулж, гэр бүлийн хуудсуудаа бэлтгэн, нас барагсдын өмнөөс ариун сүмийн ажил хийснээр хувь хүмүүсийг Их Эзэнд болон гэр бүлүүдэд нь цуглуулдаг.¹²

Цаг хугацааны бүрэн байдлын энэ эрин үе нь тэнгэр, газрын аль алинд нь цуглуулах цаг үе байх болно гэдгийг Бурхан угтан харсан юм. Төлөөлөгч Петр хэсэг хугацааны урвалтын дараа сэргээлт ирнэ гэдгийг мэдэж байжээ. Тэрээр:

“Иймээс гэмшицгээ. Нүглүүдээсээ салахын тулд эргэцгээ. Тэгвэл сэргээх цаг Эзэний оршихуйгаас ирэх бөгөөд; . . .

“Бурхан Өөрийнхөө ариун эш үзүүлэгчдийн амаар эрт цагаас айлдсанчлан бүхнийг сэргээх үе хүртэл Түүнийг тэнгэр хүлээн авах ёстой юм” хэмээн тунхаглажээ (Үйлс 3:19, 21).

Бидний үед Петр, Иаков, Иохан нарт “[Түүний] хаант улсын түлхүүрүүдийг, мөн эцсийн үеүдэд зориулсан сайн мэдээний эрин үеийг . . . цаг хугацааны бүрэн байдлын тулд” Их Эзэнээр илгээгдсэн бөгөөд үүнд Тэрээр “тэнгэр дэх, мөн дэлхий дээрх аль алиныг . . . цуглуулах . . . юм” (С ба Г 27:13).¹³

Абрахамын гэрээний олон хэсэг аль хэдийн гүйцэгдсэн юм. Дэлхийн Аврагч үнэхээр Абрахамын үр удам болох Иаковын хүү Иудагаар дамжин ирсэн билээ. Өвлөх нутаг урт хугацааны өмнө хуваарилагдсан ажээ. Библийн ХҮГ хувилбарын газрын зураг дээр овгуудын өвлөж авсан нутаг нь Реубен, Симеон, Иуда, Иссахар,



Зебулун, Дан, Нафтали, Гад, Ашер, Бениамин ба Иосефын (түүний хөвгүүд болох Ефраим ба Манассегийн хооронд хуваагдсан) үр удмуудын дунд хэрхэн хуваагдсаныг харуулдаг.¹⁴ Ариун нутаг дахь Иосефын өвийн нутгаас гадна Америк тив нь Иосефын үлдэгдэлд зориулан хадгалагдсан нутаг гэдгийг бид Мормоны Номоос мэддэг билээ.¹⁵

Абрахам, Исаак, Иаковын үр удмаар дамжуулан бүх үндэстэн адислагдах агуу амлалт хожмын нэгэн цагт биелэгдэх болно. Гэхдээ Израилыг тараах бошиглол баттай байсантай адил бүх сударт гардаг цугларалтын тухай амлалт мөн биелэх болно.¹⁶

Цугларалт Хоёр дахь ирэлтийн урьдал болох нь

Энэхүү цуглуулах амлалт яагаад туйлын чухал вэ? Учир нь Израилын цугларалт дэлхийг Хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд шаардлагатай юм! Мормоны Ном бол эдгээр бурханлаг зорилгыг *хоёуманг* гүйцэлдүүлэхэд шаардлагатай Бурханы зэмсэг юм.¹⁷

Мормоны Ном бол бүх дэлхийд өгч буй Бурханы бэлэг мөн. Энэ нь Их Эзэний үнэн хэмээн гэрчилсэн цорын ганц ном билээ.¹⁸

Энэ нь Нифай, Иаков, Мормон, Моронай нараас болон сүнслэгээр нөлөөлөгдөж мөн өгүүтгэгдсэн орчуулагч, бошиглогч Иосеф Смитээс ирсэн бэлэг мөн. Мормоны Ном Израилын угсааны үлдэгдэл рүү зориуд хандсан байдаг.¹⁹

Хоёр дахь ирэлтийн тухайд бид энэ нь “эдүгээ тэдгээр нь ойрхон байна, мөн ирэх цагт” (С ба Г 63:53) гэдгийг мэддэг. Аврагч дахин ирэхэд энэ нь нууц биш байх болно.²⁰ Энэ хооронд Израилыг цуглуулж, дэлхийг алдар суут Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд хийгдэх ёстой ажил их байна.

Энэ эрин үе дэх Израилын цугларалт

Бид Мормоны Номын ачаар цугларалтын энэхүү амлалт хэзээ тохиохыг мэддэг: “Иймийн тул, бидний эцэг зөвхөн бидний үр удмын тухай бус, харин *эцсийн өдрүүдэд* биелэгдэх ёстой гэрээг дурдан, бүх Израилын угсааны тухай түүнчлэн ярьсан бөлгөө; Их Эзэнээс бидний эцэг Абрахамтай хийсэн, чиний үр удмаар газар дэлхийн бүх үндэстэн адислагдах болно хэмээн өгүүлэх тэрхүү гэрээ буюу” (1 Нифай 15:18; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Есүсийг Бетлехемд мэндлэхээс зургаан

Газар бүрийн гэгээнтнүүд Их Эзэний адислалуудыг хүртэх адил тэгш эрхтэй юм. Сүнслэг аюулгүй байдал нь бидний хаана амьдарч байгаагаас биш харин хэрхэн амьдарч байгаагаас шалтгаалдаг.



Бид ариун сүмд Абрахам, Исаак, Иаков нарын үр садад амлагдсан хамгийн агуу, хамгийн дээд адислалуудаа хүлээн авдаг.

зуун жилийн өмнө бошиглогчид Израилын цугларалт “хожмын өдрүүдэд” тохиох болно гэдгийг мэдэж байсан юм.

Абрахам хэмээх хүндтэй нэр нь хожмын үеийн гэгээнтнүүдэд чухал юм. Сүмийн гишүүн бүр Абрахамтай холбогдог.²¹ Их Эзэн өнөө үед бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Абрахамын гэрээг дахин баталгаажуулсан билээ.²² Бид ариун сүмд Абрахам, Исаак, Иаковын үр садад амлагдсан хамгийн агуу, хамгийн дээд адислалуудыг хүлээн авдаг.²³

Бид энэхүү тэнгэрлэг үзэл баримтлалыг олж авах хэрэгтэй. Бид Абрахамын гэрээний тухай мэдэж, Израилын амлагдсан цугларалтыг тохиолгон авчрахад туслах үүрэг хариуцлагаа ойлгох хэрэгтэй. *Яагаад* бид патриархын адислал хүлээн авах онцгой боломжтой байдгаа мөн эртний патриархуудтай юуны учир холбоотой байдгаа мэдэх хэрэгтэй. Реубенийг өв залгамжлах эрхээ алдсаны дараа Иаковын хүү Иосеф өв залгамжлагч болсныг бид мэддэг байх хэрэгтэй.²⁴ Иосеф болон түүний 2 хүү Ефраим, Манассе нар Израилын цугларалтад удирдах үүрэг бүхий үр удам нь болсон юм.²⁵ Харин бусад овог тэднийг дагах болсон билээ.

Их Эзэний сэргээгдсэн сүмд үнэ цэнэтэй санваарын түлхүүрүүдийг авчирсан тэнгэрлэг элчүүдийн тухай бодоод үз дээ. 1836 оны 4-р сарын 3-нд Их Эзэн Көртландийн ариун сүмийг хүлээн авсны дараа Мосе ирж, “Израилыг цуглуулах түлхүүрүүдийг” сэргээсэн юм (С ба Г 110:11). Дараа нь “Елиас хүрч ирэн, мөн бид болон бидний дараах бидний бүх үр удам адислагдах болно гэдгийг хэлэн Абрахамын сайн мэдээний эрин үеийг даатгав” (С ба Г 110:12). Ийнхүү Абрахамын гэрээ сэргээлтийн нэг хэсэг болж, дахин шинэчлэгдсэн билээ! Дараа нь Елиа Малахийн бошиглосон лацдах эрх мэдлийн түлхүүрүүдийг сэргээсэн.²⁶ Эдгээр түлхүүр нь цугларсан Израилын гэр бүлүүдийг лацдан холбосон бөгөөд тэд бүх адислалаас хамгийн агуу нь болох мөнх амьдралыг хүлээн авахад зайлшгүй шаардлагатай юм.

Эцэг, Хүү хоёрын Мормоны Номын талаарх үзэл баримтлал юу вэ? Тэд үүнийг Иосеф Смитийн бошиглолын суу билгээр ирсэн дуудлагын нотолгоо хэмээн үздэг. Мөн Тэд үүнийг хүмүүс Есүс Христийн тухай илүү ихийг мэдэж, Түүний сайн мэдээнд итгэн, Түүний сүмд нэгдэхэд туслах зэмсэг хэмээн үздэг. Тэд үүнийг Библи дэх Израилын угсааг болон бидний

хоорондын холбоог тодруулж өгдөг бичээс хэмээн үздэг. Мормоны Ном цугларалтын эхлэлийг тунхагладаг²⁷ бөгөөд энэхүү цугларалтыг тохиолгон авчрах Бурханы зэмсэг мөн. Мормоны Номгүйгээр Израилын цугларалт тохиохгүй байх байсан.²⁸

Мормоны Ном сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг. Мормоны Ном байхгүй байсан бол бид Есүс Христийн Цагаатгалын талаар маш бага зүйл мэдэж авах байсан.²⁹ Мормоны Ном Цагаатгалын тухай заадаг учраас энэ нь бидэнд наманчлах, ариун нандин гэрээнүүд хийх болон тэдгээрийг сахихад мөн авралын болон өргөмжлөлийн ёслолуудын ач тусыг хүртэхэд тусалдаг. Энэ ном мөнх амьдралд тэнцэх боломжийг бидэнд олгож, ариун сүм рүү хөтлөн удирддаг.

Бид дэлхий дээр хийдэг бүх зүйлдээ энэхүү тэнгэрлэг үзэл баримтлалтай байж чадна. Энэхүү үзэл баримтлалыг ойлгосноор бид номлогчийн ажил нь Израилын цугларалтад нэн чухал үүрэг гүйцэтгэдгийг олж мэддэг. Манай номлогчид олон үндэстний дотроос тараагдсан Израилын хүмүүсийг эрж хайдаг.

Зөв шударга гэгээнтнүүд цугларсан газар бүрд Сион оршиж байдаг.³⁰ Газар нутгийн байршлаас үл хамааран хэвлэл материал, харилцаа холбоо, цуглаанууд нь сүмийн бараг бүх гишүүнд сургаал, түлхүүр, ёслолууд ба сайн мэдээний адислалуудыг хүлээн авах боломж олгодог.³¹

Газар бүрийн гэгээнтнүүд Их Эзэний адислалуудыг хүртэх адил тэгш эрхтэй. Сүнслэг аюулгүй байдал нь бидний *хаана* амьдарч байгаагаас биш харин *хэрхэн* амьдарч байгаагаас шалтгаалдаг.

Израилын цугларалт нь төгсгөл *биш* юм. Энэ бол эхлэл. Бидний тэвчиж хүрэх ёстой төгсгөл нь ариун сүмийн хишиг болон лацдан холбох ёслолуудыг багтаадаг. Энэ нь бид удам угсаагаараа эсвэл үрчлүүлэх замаар Бурхантай гэрээний харилцаанд орж, Түүнтэй болон гэр бүлийнхэнтэйгээ үүрд мөнхөд хамт байх алхмыг багтаадаг. Энэ бол Бурханы алдар суу—Түүний хүүхдүүдийн мөнх амьдрал мөн.³²

Хайраар дүүрэн бидний Тэнгэр дэх Эцэг хүүхдүүдээ албадлагаар бус харин хувийн сонголт болон хувийн бэлтгэлээр дамжуулан Өөртөө эргэж ирээсэй хэмээн чин сэтгэлээсээ хүсдэг. Мөн Тэрээр тэднийг мөнхийн гэр бүлүүд болж, лацдан холбогдоосой хэмээн хүсдэг.

Энэ бол бидний Тэнгэрлэг Эцэгийн үзэл баримтлал. Энэ бол Хайртай Хүүгийн үзэл бодол. Энэ нь мөн бидний үзэл баримтлал байж чадна. ■

2013 оны 6-р сарын 26-нд Провогийн Номлогчийг бэлтгэх төвд болсон номлолын шинэ ерөнхийлөгчдөд зориулсан сургалт дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Эхлэл 13:16; 22:17; Абрахам 3:14-ийг үзнэ үү.
2. Эхлэл 12:1, 7; Абрахам 2:6-г үзнэ үү.
3. Абрахам 2:9, 11-ийг үзнэ үү.
4. Галаат 3:26–29; Абрахам 2:10-ыг үзнэ үү.
5. Эхлэл 49:10, 24-ийг үзнэ үү.
6. Исаиа 11:12; 22:16–18; 3 Нифай 15:20–22; Абрахам 2:10–11-ийг үзнэ үү.
7. 1 Нифай 15:18; мөн Мормоны Номын удиртгал хуудсыг үзнэ үү.
8. Сургаал ба Гэрээ 133:8–17-г үзнэ үү.
9. Эхлэл 12:2–3; 26:3–4; 35:11–12; мөн 3 Нифай 21 ба 29-ийн бүлгийн тоймыг үзнэ үү.
10. Түүнчлэн Омнай 1:26; Моронай 10:30, 32; Сургаал ба Гэрээ 20:59-ийг үзнэ үү.
11. Сургаал ба Гэрээ 137:5–8-ыг үзнэ үү.
12. 1 Коринт 15:29; 1 Петр 4:6-г үзнэ үү.
13. Паул түүнчлэн бидний цаг үеийн талаар: “Энэ нь цагийн дүүрнийг гүйцэлдүүлэхийн тулд [Их Эзэн] тэнгэр дэх юмс болон газар дээрх бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ” хэмээн бошиглосон юм (Ефес 1:10).
14. Эхлэл 35:23–26; 41:50–52-ыг үзнэ үү. Леви овог нь хүмүүсийг тахилчдаар хангадаг байсан бөгөөд овог хэмээн тоологддоггүй мөн овогт оногдох өвийн нутаг хүлээн аваагүй ажээ. Иосефын хоёр хүү Манассе, Ефраим хоёрт өвийн нутаг өгөгдсөн бөгөөд тэд эцгийнхээ оронд овгуудын дунд тоологдох болсон байна. Ийнхүү арванхоёр овгийн тоо хадгалагдан үлдсэн юм.
15. Ифер 15:8; мөн Эхлэл 49:22-ыг үзнэ үү.
16. Левит 26:44; Дэд хууль 4:27–31; 28; 29; 30:1–10; Нехемиа 1:9; Исаиа 11:11–12; Иеремиа 31:7–12; Езекиел 37:21–22; Амос 9:14–15; Матай 24:31; Иаков 6:2-ыг үзнэ үү. Рассэлл М.Нэссон, “The Exodus Repeated,” *Ensign*, 1999 оны 7-р сар, 6–13-ыг мөн үзнэ үү. Израилын цугларалтыг Исаиа 49–51 ба Иаков 5-д тодорхой зөгнөн бичсэн байдаг.
17. Матай 24:14; Сургаал ба Гэрээ 133:17-г үзнэ үү.
18. Сургаал ба Гэрээ 17:6-г үзнэ үү.
19. Мормон 7:10; 9:37; Моронай 10:31–34-ийг үзнэ үү.
20. Исаиа 40:5-ыг үзнэ үү.
21. Уг гэрээг үрчлэлтээр дамжуулан хүлээн авч болно (Матай 3:9; Лук 3:8; Галаат 4:5–7-г үзнэ үү).
22. Сургаал ба Гэрээ 124:58; 132:31–32-ыг үзнэ үү.
23. Сургаал ба Гэрээ 84:33–40; 132:19; Абрахам 2:11-ийг үзнэ үү.
24. Шастирын дээд 5:1-ийг үзнэ үү.
25. Ефраимд сэргээлтийн захиасыг бүх үндэстэнд хүргэж, тараагдсан Израилыг цуглуулах ажлыг удирдах Израил дахь өв залгамжлах эрх өгөгджээ (Иеремиа 31:7–9; Сургаал ба Гэрээ 64:36; 133:32–34-ийг үзнэ үү).
26. Сургаал ба Гэрээ 110:13–16; түүнчлэн Малахи 4:5–6-г үзнэ үү.
27. Израилын угсааг тараах, цуглуулахтай холбоотой сургаал нь Мормоны Номонд заадаг хамгийн эртний хичээлүүдийн нэг юм (1 Нифай 10:14)-ийг үзнэ үү.
28. Брүс Р.Макконки, *A New Witness for the Articles of Faith* (1985), 554.
29. *Цагаатгал* гэдэг үгийн олон хэлбэрээс нэг нь л Хаан Жеймсийн Библийн Шинэ Гэрээний ганцхан шүдлэгт дурдагддаг (Ром 5:11-ийг үзнэ үү) бол энэ үг Мормоны Номонд 24 удаа гардаг.
30. Сургаал ба Гэрээ 97:21-ийг үзнэ үү.
31. 2014 оны 5-р сарын байдлаар.
32. Мосе 1:39-ийг үзнэ үү.



АММОН ШИГ БАЙ

*Мормоны Номын энэ баатар номлолын ажлын талаар
болон идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх талаар
өнөөдөр бидэнд олон зүйлийг зааж чадна.*

Аммон бол зоригт үйлчлэлээрээ, түүний дотор леменчүүдийн хаан Лемонайн сүргийг хамгаалснаараа танигдсан Мормоны Номын баатарлаг хүн юм (Алма 17:25–39; 18:1–10)-ыг үзнэ үү). Аммоны түүх нь Мормоны Номон дахь судрын бусад олон түүхтэй адил боломжуудыг хэрхэн бүрэн дүүрэн ашиглах тухай, өнөөдөр бидэнд тулгарч байгаа сорилтуудыг хэрхэн даван туулах тухай ихийг заадаг.

Үр дүнтэй номлол

АНУ-ын Нью Жерси Миллвиллийн Сюзанн Э.Тарасевич нөхөр Адольфын хамт бүрэн цагийн номлолд үйлчилж байхдаа Аммоноос зарим зүйлийг сурчээ.

“Бидний номлолын дуудлагыг агуулсан том цагаан дугтуй манай шуудангийн хайрцагт ирэхэд нөхөр бид хоёр сэтгэл догдлон, үнэхээр их баярлаж билээ. Бид дуудлагынхаа талаар мацаг барьж, залбирсан юм. Бид *хаана* томилогдох тухайд санаа зовсонгүй харин дуудлагаа үр дүнтэй биелүүлэх чадвараа батлахыг л чин сэтгэлээсээ хүсч байлаа.

“Бид тэр орой хүүхдүүд, ач зээ нараа цуглуулан, дугтуйг задалж, биднийг Польшийн Варшавын номлолд дуудсаныг уншлаа. Бид ийнхүү дуудлагаа уншихдаа энэ дуудлага бидний хувьд хэчнээн чухал болохыг ойлгож, зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдэрсэн юм. Бид хоёрын сэтгэл догдлон, хөл газарт хүрэхгүй баярлаж билээ” гэж тэр ярьжээ.

Гэвч Тарасевич эгч номлолд ирснийхээ дараа энэ ажилд чухам ямар хувь нэмэр

оруулж чадахаа тодорхой ойлгоход хэцүү санагджээ. “Нөхөрт маань өсч хөгжихөд туслах, сорилт бүхий удирдлагын үүргийг тэр даруй өгсөн. Бид хоёрын хэн хэн нь польшоор ярьдаггүй байсан ч хэлний бэрхшээлээс үл хамааран түүний үйлчлэл үр ашигтай байх шиг санагдаг байлаа” гэж тэр хэлэв. Гэтэл үүний эсрэгээр, “би өөрийгөө энэ ажилд тус нэмэр болж чадахгүй, ямар ч үр ашиггүй байна гэж үе үе бодох болж, номлолынхоо ажлын утга учирт эргэлзэх болсон” гэж тэр ярьжээ.

Хүчирхэг номлогчид

Тарасевич эгч Мормоны Номон дахь агуу номлогчдын тухай боддог болов. “Би Хүүхдийн хэсгийн багшаар олон жил ажиллахдаа хүүхдүүдэд номлолын ажлын тухай заахын тулд Алма болон Мозаягийн хөвгүүдийн сүнслэг нөлөө ихтэй, хүсэл эрмэлзлийг өдөөгч түүхүүдийг олонтоо ашигладаг байлаа. Намайг номлогчдын тухай бодох бүрд сүнслэг байдлын хувьд хүчирхэг бөгөөд хүч чадал ихтэй Аммоны дүр зураг санаанд минь орж ирдэг байв. Тиймээс би номлолынхоо эрч хүчтэй залуу номлогчдыг өнөө үеийн Мозаягийн хөвгүүд хэмээн төсөөлөн боддог болсон юм. Гэвч над шиг буурал үстэй эмээ ажил үүрэгтэй дайчин идэвхтэй байхыг хүсэх нь даруу зан дутагдаж байгаа хэрэг бус уу гэж би бодож билээ.”

Дотоод сэтгэл дэх дуу хоолой надаас асуултуудыг шивнэн асууж эхэлсэн юм хэмээн тэр бодлогошрох зуураа хэлэв.



АЛДАГДСАН НЭГНИЙГ ОЛ

“Алдагдсан байх нь ямар санагддаг мөн 99 хонио орхиод төөрсөн нэг хонио хайж олохын тулд явдаг ‘сүнслэг’ хоньчин байх гэдэг нь юу гэсэн утгатай болохыг бид бүгд тунгаан бодох нь чухал юм. Ийм хоньчдод хайж олон, аврах багийн мэдлэг туршлага, тусламж, дэмжлэг хэрэгтэй байж болно, тэгвэл тэд туслахад ямагт бэлэн байдаг бөгөөд Бурханы мэлмийд хэмжээлшгүй үнэ цэнэтэй хүмүүсийг аврахын тулд тэдний дэргэд тэр дороо хүрч очдог. Учир нь тэд Түүний хүүхдүүд шүү дээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Л. Том Пэрри, “Бодгалиудыг надад авчир,” *Лиакона*, 2009 оны тавдугаар сар, 112.

“Аммоны анхны ажил үүрэг юу байсан бэ?”

“Үйлчлэгч байх, сүргийг хамгаалах, тарсан хонийг цуглуулах” гэж тэр хариуллаа.

“Тэгвэл та Аммон шиг байх хэрэгтэй.”

ҮЙЛЧЛЭХЭД БЭЛТГЭСЭН НЬ

Эдгээр бодол Тарасэвич эгчид тодорхой зүйлийг ойлгуулсан ажээ. “Миний ажил үүргийн мөн чанар юу байх ёстойг би гэнэт маш тодорхой ойлгосон” гэж тэр хэлэв. “Би номлол хийхэд хэрэгтэй хэлний чадварыг амжилттай эзэмшээгүй ч Халамжийн Нийгэмлэгт олон жил үйлчилсэн туршлага маань өөрийгөө мартагдсан, хэн ч тоохоо байсан гэж боддог хүмүүсийг эрж олон, хайрлаж, тэдэнд үйлчлэхэд намайг бэлтгэснийг ойлгосон.”

Тэр номлолын ажлаа өөр өнцгөөс харж болжээ. “Христэд төвлөрсөн зарчмууд хэлний хангалтгүй мэдлэгийг даван туулж болно гэдгийг би олон арга замаар мэдсэн”

гэж тэр ярих. “Би сүрэгт анхаарал тавьж, тарсан хоньдыг цуглуулахын тулд юу хийснээ хардаг болж эхэллээ.”

Ингээд тэрээр “Сайн мэдээ нь үүнийг хүлээн авсан хүмүүсийн амьдралыг өөрчилж, баялаг агуулгатай болгодгийг харах онцгой боломж бидэнд байдаг болохоор ахмад номлогчийн амьдрал нь бидэнд суралцах болон үйлчлэх гайхамшигтай цаг үе болсон юм” гэж ярилаа. Аммоны дуулал хэмээн өөрийн нэрлэсэн: “Болгоогтун, миний баясал дүүрч, тийм ээ, зүрх сэтгэл минь баяслаар халгинам, мөн би Бурхандаа баярлах болно” хэмээх шүлэг түүнд өөрөө дуулж байгаа юм шиг л байнга санагддаг ажээ (Алма 26:11).

Хоньдыг аврах нь

АНУ-ын Юта мужийн Өмнөд Вэбэрийн Пэгги Воллис Полл гадасны санваарын болон туслах бүлгүүдийн удирдагчдын сургалтын хурал дээр сүнслэг байдлын

Хүн бүрийг хайраар тэтгэх нь Аммоны үлгэр жишээг дагах агуу арга зам мөн.



хувьд аврах болон идэвх султай гишүүдийг идэвхжүүлэх тухай заах даалгавар авсан үедээ Аммонос шинэ ойлголт, санаа хүлээн авсан ажээ.

“Би Аммоны тухай бүхний мэдэх түүхийг уншаад нэг шинэ зүйлийг анзаарсан юм. Аммон леменчүүдийн дунд номлолд үйлчилж байсныг санагтун. Түүнд хааны сүргийг хариулах үүрэг өгсөн байлаа. Хонин сүргийг услахаар Сэбасын усанд аваачсан өөр зарц нар түүнтэй хамт байхад дээрэмчид сүргийг тараажээ. Энэ нь бусад зарц нарыг хирдхийн цочоосон аймшигт явдал байлаа. Хонин сүргийг тараах боломж олгосон бусад зарц нарыг үхэлд хүргэсэн болохоор одоо тэднийг мөн тийм хувь тавилан хүлээж байгаа нь тодорхой байсан бололтой” гэж тэр хэлжээ. (Алма 17:25–30-ийг үзнэ үү.)

“Харин Аммон үүнийг боломж гэж үзсэн юм” гээд Полл эгч цааш нь яриу. “Түүнд нэг төлөвлөгөө байсан учир бусад зарц нарт зоригтой бай гэжээ. Алма 17:31–33-ыг унш, тэгвэл та уг төлөвлөгөөг тодорхой харах болно:

1. Хонин сүрэг алдагдаж байгааг аль болох эрт ажигла.
2. ‘Аль болох хурдан, яаран [яв].’
3. Хоньдыг хураан цуглуул.
4. Хонин сүргийг хороонд нь эсэн мэнд буцааж авчир.
5. Сүргийг тойрон хүрээлж, аюулгүй байлган, тэднийг хайраар тэжээ.”

Энэ түүх идэвх султай гишүүдийг идэвхжүүлэхтэй хэрхэн холбогдох талаар түүнд онцгой сэтгэгдэл төрсөн хэмээн Полл эгч хэлээд: “Аммоны түүхийг тараагдсан гишүүдээ аварч байгаа өнөө үеийн сүмийн удирдагчдын бэлгэдэл болгон харж болно. Гишүүдийг сайн мэдээний сайн үгээс холдуулан зайцуулж мэдэх дээрэмчидтэй адил олон муу нөлөө дэлхийд байдаг. Түүний үнэт бодгалиудаас хэн нэгэн нь сүргээс тасран алга болсон үед бид идэвхтэй бөгөөд шуурхай хөдлөх ёстой” гэв.

Тэгээд Полл эгч ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) хэлсэн “Бид бүгд . . . тусламж хэрэгтэй байгаа болон яаралтай шийдвэл зохих хүнд нөхцөлд байгаа хүмүүсийг эрж олон, тэдэнд хайраар хандаж, сүмд эргэж ирэхэд урамшуулан дэмжиж мөн сайхан сэтгэлт, хайр энэрлээр дүүрэн гишүүд тэдний сэтгэлийг бүлээцүүлж, тайтгаруулан, дэмжин тусалж, аз жаргалтай, үр бүтээлтэй амьдралын замд оруулна гэдэгт би найддаг, үүний төлөө би залбирч байх болно” гэсэн үгийг эш татсан юм.¹ ■

ЭШЛЭЛ

1. Гордон Б.Хинкли, “Reach with a Rescuing Hand,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 86.



АМЮЛЕК БАС БИДЭНД ЗААЖ ЧАДНА

Амюлек бол Мормоны Номын өөр нэг агуу баатар юм. Хүмүүс зөв шударга амьдралын зам руу эргэж ирснээр ямар болдгийг тэр харуулдаг.

Баян чинээлэг, олонд танигдсан Амюлек Бурханы хүч болон нууцуудыг мэддэг байсан атлаа зүрх сэтгэлээ хатууруулснаа хүлээн зөвшөөрсөн юм. “Би олон удаа дуудагдсан боловч, сонсохоос татгалзсан; тиймийн тул би эдгээр зүйлүүдийн талаар мэдэж байсан боловч мэдэхийг хүссэнгүй” (Алма 10:6; мөн 4–5-р шүлгүүдийг үзнэ үү) гэж тэр хэлжээ.

Гэвч Их Эзэн бошиглогч Алмаг гэртээ хүлээн ав гэж Амюлект хэлүүлэхээр нэгэн тэнгэр элчийг илгээсэн ажээ. Амюлек Алмаг хооллосонд Алма, Амюлекийг гэр бүлийнх нь хамт адисалж, тэдэнд заажээ. Тэгээд Амюлек Алматай үйлчлэлд нэгдэж, сайн мэдээний үнэнүүдийн хоёр дахь хүчирхэг гэрчлэгч болжээ. (Алма 10:7–12-ыг үзнэ үү.)

Амюлек хүмүүсийг наманчлалд дуудахад Алмагийн хамтрагч болж, сайн мэдээг хүмүүс амаа ангайн гайхтал тийм их хүч ба эрх мэдэлтэйгээр номлосон ажээ (Алма 11:46-г үзнэ үү). Шоронд хоригдсон Алма, Амюлек хоёр гайхамшигтайгаар суллагдаж, Сайдомд сүм байгуулан, уг нутаг даяар сайн мэдээг заав (Алма 14; 15; 31-ийг үзнэ үү).

Өнөөдөр яг Амюлектэй адил сүмд эргэж ирэн, идэвхтэй болсноор Их Эзэн тэднийг адисалж, тэд үнэний хүчирхэг гэрчүүд болсон хүмүүс олон байдаг.

Залуучуудын эцэг эхэд зориулсан АРВАН ЗӨВЛӨГӨӨ

Вэнди Улрич

Мэргэжлийн сэтгэл судлаач

Нөхөр бид хоёр хүүхдүүдээ коллежийн дотуур байранд суухад эсвэл номлогчийг бэлтгэх төвд ороход нь туслах үедээ хөнгөн гуниглаж, тэд одоо биеэ даасан болохоор бидний ажил дуусаж чөлөөлөгдсөн мэт мэдрэмж төрдөг байлаа. Хэдийгээр хүүхдүүд маань шинэ чадвар болон эрх чөлөөг олж авдаг ч гэсэн тэдэнд өөр бэрхшээлүүд тулгардагийг бид удалгүй олж мэдсэн юм. Бид тэдний амьдралыг хянах боломжгүй болсон ч гэсэн өөр төрлийн дэмжлэг авах тэдний хэрэгцээ шаардлага өссөн байлаа.



ӨНӨӨГИЙН БЭРХШЭЭЛҮҮД

Өнөөгийн дэлхийд залуучуудад тулгардаг зарим бэрхшээлийн жишээнүүд болон тэдгээрээс үүсдэг, эцэг эхчүүдтэй холбоотой асуултаудыг дор дурдлаа.



УРТ УДААН ҮРГЭЛЖИЛ- ДЭГ ГАНЦ БИЕ АМЬДРАЛ.

Нийгэмд дэлгэрч буй гэр бүлийн амьдралаа хожуу эхлэх чиг хандлага нь зарим залуу насанд хүрэгчдийг насанд хүрэгчийн амьдрал нь төгсгөлгүй юм шиг бодоход хүргэдэг. Зарим нь гэрлэх эсвэл хүүхэдтэй болох тал дээр эргэлздэг. Эцэг эхчүүд бид уг асуудлыг үүрд мөнхийн талаас нь харахад хэрхэн тэдэнд хамгийн сайнаараа тусалж чадах вэ?

САНХҮҮГИЙН ТОДОР- ХОЙГҮЙ БАЙДАЛ.

Өнөөгийн залуучуудын олон нь эдийн засгийн хувьд эцэг, эхтэйгээ адил тэнцүү байж чадахгүй байж болно. Тэдний хувьд их сургуулийн дипломтой ч гэсэн ажил олох эсвэл гэр бүлээ тэжээх нь хэцүү байж болно. Эцэг, эхчүүд бид эдийн засгийн тал дээр тэдэнд туслах ёстой юу эсвэл хүүхдүүд маань өөрсдөө санхүүгээ зохицуулснаар өсөж чадна гэж найдах ёстой юу?





ТОО ТОМШГҮЙ ОЛОН СОНГОЛТ. Өнөөгийн залуучууд ажил мэргэжлийн тал дээр илүү олон сонголттой байж болно. Гэвч эдгээр бүх сонголт нь заримдаа хэт олон юм шиг санагдаж болох юм. Эцэг эхчүүд сонголтуудыг судлахад болон сэтгэл ханамж өгөх ажил мэргэжил сонгоход нь насанд хүрсэн хүүхэддээ хэрхэн тусалж чадах вэ?

ЭЦЭГ ЭХТЭЙГЭЭ ХАМТ

АМЬДРАХ НЬ. Гэрлэлтийн байдлаас үл хамааран, эцэг эхтэйгээ хамт амьдардаг 18-34 насны залуучуудын тоо нэмэгдсээр байна. Насанд хүрсэн хүүхдүүд эцэг, эхтэйгээ хамт амьдарч байгаа үед эцэг, эхчүүд хэн нь хүнсний зүйлээ худалдаж авах, ач, зээ нараа хэрхэн хүмүүжүүлэх зэрэг асуудлыг хэрхэн зохицуулах ёстой вэ?



Дэлхийн өнөөгийн бэрхшээлүүд байсаар байгаа ч эцэг эхчүүд зөв шударга дэмжлэг болон удирдамж өгөх замаар насанд хүрсэн хүүхдүүдээ үргэлжлүүлэн адисалж чадна.



ШАШИН ШҮТЛЭГ. Өнөөдөр, бүх шашны залуучууд өнгөрсөн үетэй харьцуулахад ямар нэгэн сүмд явах хандлага нь багасч байна. Эцэг, эхчүүд бид насанд хүрсэн хүүхдүүдээ сүмд идэвхтэй хэвээр байхад нь хэрхэн урамшуулан дэмжиж чадах вэ? Тэд сүмийн үйл ажиллагаанд оролцохгүй байсан ч гэсэн бид тэднийг хэрхэн сүнслэгээр дэмжиж чадах вэ?

ЭЦЭГ, ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ

Насанд хүрсэн хүүхдүүд маань зарим чадвар эсвэл амжилтаараа биднээс илүү гарсан ч амьдрал нь амжилттай байхын тулд тэдэнд эцэг, эхийн дэмжлэг хэрэгтэй бөгөөд тэд ийм дэмжлэг авах эрхтэй юм. Дараах 10 удирдамжийн талаар бодож үзээрэй.

1. ХҮҮХДҮҮД ЧИНЬ ЮУ ХҮСДЭГ МӨН ЮУНД ДУРТАЙГ ОЛЖ МЭД.

Хүүхдүүдээ хэрэгтэй гэж бодсон зүйлээ хий гэж хэлэхийн оронд *тэдний* эрхэмлэдэг зан чанарууд, зорилго болон мөрөөдлийнх нь талаар асуу. Тэд зорьсондоо хүрэх замыг тодорхойлохдоо танаас тусламж хүсч болно. Хэрэв тэд тусламж хүсвэл *тэдний* мөрөөдөл таны яриаг удирдах ёстой гэдгийг санаарай. Аливаа үйлдлийн эерэг, сөрөг үр дагавруудын талаар хэлэлцэж, удирдамжийн төлөө залбираад үргэлжлүүлэн ярилц. Хэрэв тэд юу хүсч байгаагаа мэдэхгүй байвал тэднийг удирдамж өгөх зөвлөгчтэй уулзах, ажил мэргэжлийн сонирхол тогтоох сорил өгөхөд эсвэл ажил хөдөлмөр болон сайн дурын ажлаар дамжуулан илүү туршлага олж авахад нь урамшуулан дэмж.

2. ЗАЛБИРЧ СУДАЛ: СУРГААЛ БА ГЭРЭЭ

121:34-46-Г СУДАЛНА УУ. Эдгээр шүлэг эцэг, эхчүүдтэй гайхалтайгаар холбогддог бөгөөд насанд хүрсэн хүүхдүүдээ хэрхэн зөв шударга удирдамжаар хангах талаар зөв зарчмуудыг бидэнд заадаг.

3. ОЛОН ЗАЛУУТАЙ САЙН ХАРИЛЦАА ХОЛ- БОО ТОГТОО.

Бусад хүний хүүхдүүд өөрийн тань 20, 30 настай байх үеийн тухай мэдэх сонирхолтой

байдгийг та олж мэдэж болно. Ахмад хүмүүсийн эн тэргүүнд тавих зүйлсээ хэрхэн тэнцвэртэй байлгаж, ажил мэргэжлээ хэрхэн сонгосон эсвэл амьдралын ханиа олсноо яаж мэдсэн гэх мэт зүйлүүдийг залуучууд сонирхдог. Та залуучуудтай ярилцах үедээ тэдний үеийнхэнд тулгарч буй бэрхшээлүүдийг илүү сайн ойлгох болно.

4. ӨӨРТ БҮЙ БЭЛГЭЭ ОЙЛГОХОД НЬ ТЭДЭНД ТУСАЛ.

Залуучуудад авьяас, сонирхлоо олж нээхэд нь тусалснаар сэтгэл хангалуун ирээдүйгээ төсөөлөн бодоход нь ч мөн тусалж чадна. Хүмүүс хангалттай хүч чармайлт гаргаж байж, аливаа зүйлд чадвартай болдгийг тайлбарла. Төрөлхийн



олон авьяастай хүмүүс ч гэсэн амжилтад хүрэхийн тулд авьяасаа хөгжүүлэх цаг гаргах ёстой байдаг.

5. ТЭДНИЙ ГАРГАСАН ШИЙДВЭРТ ИТГЭ. Энэ нь тэд үргэлж төгс сонголт хийнэ гэдэгт итгэх ёстой гэсэн үг биш. Энэ нь тэд алдаагаа засч чадна гэдэгт, Бурхан уучилдаг гэдэгт мөн амьдралд бүтэлгүйтлийг даван туулах эсвэл сорилт бэрхшээлүүдийг тэвчих явдал байдаг ч гэсэн амьдрал гүн утга учиртай байж чадна гэдэгт итгэх итгэл юм. Бага насны хүүхдүүд сэтгэл санааны цочролд өртөж магадгүй байдаг бол харин *залуучууд* саад бэрхшээлээс зайлсхийхийн оронд түүнийг даван туулснаар өсч хөгждөг. Тэдэнд сэтгэл санааны хувьд болон бодитой дэмжлэг тусалцаа үзүүлж, бухимдлаас завсарлага авахад урамшуулан дэмж мөн тэдэнтэй хамт тэдний төлөө залбирч, бага ч болов хошин шог өнгө аяс оруулж бай.



6. ХУЧИН ЧАРМАЙЛТЫНХ НЬ ТӨЛӨӨ

ТЭДНИЙГ МАГТ. Залуучуудын шаргуу ажил, тэвчээрийг магтах нь тэдэнд аливаа зүйлд тууштай байж, илүү өндөр зорилго тавин, хийж буй зүйлээсээ илүү их сэтгэл ханамж авахад нь тусалдаг. Ерөнхийлөгч Томас С.Монсоны эш татсан нэгэн сургаалд “Хоосон хүсэл биш харин ажил хөдөлмөр л амжилт авчирдаг” гэсэн байдаг.¹

7. СҮНСЛЭГ УДИРДАМЖИЙГ ЭРЭЛХИЙЛ.

Бидний залбирал болон итгэл нь зүрх сэтгэлээ нээж, Бурханд биднийг өөрчлөх боломж олгоход тусалдаг. Миний таньдаг нэг эмэгтэй насанд хүрсэн хүүхдүүдийнхээ хүүхдүүддээ үзүүлдэг телевизийн нэвтрүүлгийн талаар санаа зовнидог байсан юм. Уг нэвтрүүлэг хүүхдүүдийн насанд тохирч байсан ч үл хүндэтгэх зан, хэрүүл маргааныг сурталчилж байна гэж тэр боджээ. Тэрээр хөндлөнгөөс оролцохыг хүсээгүй боловч юу хийх эсвэл юу хэлэх талаараа олон удаа залбирч, мацаг барьсан аж. Нэг өглөө бэр нь түүнээс хүүхдүүдийнхээ дунд байгаа үл хүндлэх занг болон хэрүүл маргааныг хэрхэн арилгах тухай зөвлөгөө хүссэн байна. Манай тэр найз телевизийн нэвтрүүлгийн талаарх бодлоо бэртэйгээ хуваалцсан бөгөөд бэр нь энэ нөлөөг ерөөсөө анзаардаггүй байсан ажээ. Ингээд залуу эцэг, эх хоёр хүүхдүүдийнхээ асуудлыг шийдвэрлэж чадсан байна. Өөрчлөлтүүд санал нэгтгэй хийгдэж, гэр бүл дэх уур амьсгал сайжирчээ.



8. МӨНГӨНИЙ ТАЛААР ЯРИЛЦ.

Өөрийнхөө санхүүгийн байдлыг болон хүүхэд бүрийнхээ насны ялгааг харгалзан, хэрэв шаардлагатай бол хүүхдүүддээ санхүүгийн ямар тусламж үзүүлэхээ залбирч шийд. Магадгүй тэдэнд зөвхөн төсөв гаргахад л таны тусламж хэрэгтэй байж болно. Хэрэв та тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлбэл та мөнгөө эргүүлэн авах эсэх эсвэл мөнгийг зөвхөн тодорхой нэг зүйлд л зарцуулах гэх мэт зүйлсийг эхнээсээ тодорхой байлгаарай. Дараа нь тэдэнд өөрсдийнхөө төсвийг өөрсдөө удирдан зарцуулж,



алдаанаасаа суралцан, өнөөдөр хэтрүүлэн зарцуулсан бол маргааш зарцуулахгүй байх үүрэг хариуцлагыг урамтай өг.

9. ДАРУУ БАЙ. Та эцэг, эхийн хувьд гаргасан алдааныхаа төлөө өөрийгөө зэмлэхийг хүсч байгаа бол гутрахын оронд даруу байдлаа гүнзгийрүүлэхийг хичээ. Уучлал гуйхдаа эелдэг бөгөөд хүндэтгэлтэй байж, сайжрахын тулд юу хийхийг нь хэлж өгч, тэгээд өөртөө итгэлтэй урагш тэмүүл. Хүүхдүүд тань таныг хараад алдаагаа засч болно гэдгийг, уучлал гуйх нь сул доройн шинж биш гэдгийг мөн өрөөл бусдыг болон өөрийгөө уучлах нь амар амгаланг авчирдгийг анзаарч ойлгог.

10. ЖИНХЭНЭ АМЖИЛТЫГ ХЭМЖ. Бид хүүхдүүдийнхээ хийдэг сонголтуудын (сайн эсвэл муу аль аль нь) талаар бусад хүмүүс биднийг хэрхэн шүүмжлэх бол гэдэг дээр анхаарлаа хэт төвлөрүүлбэл бодит байдлаас хөндийрч, Сүнснийг олонтоо алддаг. Эцэг, эхчүүдийн хувьд бидний амжилт хүүхдүүд маань бидний зарчмуудын дагуу хэрхэн амьдарч байгаагаар бус харин *бид* зарчмын дагуу хэр зэрэг тууштай, амин хувиа бодолгүй амьдарч байгаагаар хэмжигддэгийг санаарай.

Бид насанд хүрсэн хүүхэд бүрийнхээ хэрэгцээ шаардлага, зан чанаруудын талаар залбирч эргэцүүлэн бодсоноор Сүнс бидэнд тэднийг шүүмжлэхгүйгээр удирдан чиглүүлж, туслах ёстой хэмжээ хязгаараас хэтрүүлэлгүй мөн тэднээс нүүр буруулалгүй бие даах боломж олгоход тусалж чадна. Бид үүнийг хийснээр насанд хүрсэн хүүхдүүд маань Их Эзэн болон бидний аль алиныг өөрсдийнх нь талд байгаад итгэх болно. ■
Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Great Expectations” (Сүмийн Боловсролын Системийн залуучуудад зориулсан галын дэргэдэх цугларалт, 2009 оны 1-р сарын 11), 6; speeches.byu.edu.

НИФАЙ МИНИЙ АСУУЛТАД ХАРИУЛСАН

Би сүмд төрсөн ч намайг өсөж торних үед манай гэрийнхэн сүмд ховорхон очдог байв. Ганцаараа байсан ч би сүмд очих арга замаа үргэлж олдог байлаа. 1970 оны эхээр би АНУ-ын Канзас мужийн Питтсбургт семинарын багшаар үйлчилж байлаа. Бид Мормоны Номыг судалж байсан бөгөөд би өөрийгөө болон ангийнхныгаа уг номыг бүтнээр нь уншихад уриалсан юм. Би нэг өдөр Мормоны Номыг уншиж байгаад энэ бол үнэн гэсэн хүчирхэг гэрчлэл хүлээн авч билээ.

Хэдэн жилийн дараа аав, ээж хоёр маань манайд зочилж ирэв. Тэр үед аав маань бид хоёрын санал зөрөлдсөнөөс болоод

ярилцахыг хүсэхгүй байсан сэдвийг минь хөндөж ярьсан юм. Аав энэ сэдвээс нойтон хамуу шиг салахгүй байсанд миний тэвчээр барагдах дөхөж билээ. Би түр гараад унтлагын өрөөндөө орж, өвдөг сөгдөн, Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, аавтайгаа зөв харьцахад минь туслаач гэж гуйлаа. Хариулт нь Нифай ба хугарсан нумны тухай түүхийг унш гэсэн бодол хэлбэрээр ирсэн юм.

Би 1 Нифай 16-р бүлэг дэх түүхийг уншлаа. Их Эзэний эсрэг бувт-насан эцэгтээ хандан, хоол олохын тулд хаашаа явахыг асуухуйц хангалттай даруухан байсан Нифайн тухай би бодсон юм (23-р шүлэг). Энэ бодлынхоо ачаар би аав руугаа очиж, түүнээс удирдамж болон

санваарын адислал өгөхийг хүсэхээр өдөөгдсөн билээ.

Би зочны өрөөнд эргэн ирж, ааваасаа адислал өгөхийг хүсэхэд аавын минь сэтгэл хөдөлж, уйлж эхлэв. Аав “би үүнийг бодож үзье” гэж хэллээ.

Дараагийн хэдэн өдөр аав мацаг барьж, залбирав. Тэгээд аав ээжтэй минь хамт буцахаасаа өмнө надад гайхалтай адислал өгч билээ.

Энэ явдлын дараа аав минь амьдралаа бүрмөсөн өөрчилсөн юм. Аав, ээж хоёр Канзас дахь гэртээ харих замдаа АНУ-ын Миссури мужид орших Адам-ондай-Аманы хөндийг очиж үзсэн бөгөөд тэнд байхад нь аавд нэгэн хүчирхэг сүнслэг явдал тохиолдсон юм.


Удалгүй аав, ээж хоёр минь идэвхтэй бөгөөд тууштай хожмын үеийн гэгээнтнүүд болсон. Үүнээс хойш хэдхэн жилийн дотор тэд хоёр номлолд—Германд болон Солт Лэйк хотын ариун сүмийн талбайд үйлчилсэн юм. 1987 онд аав минь өөд болохдоо гадасны патриархаар үйлчилж байлаа.

Миний аав сайн хүн гэдгийг Их Эзэн мэдэж байсан. Би Мормоны Номоор дамжуулан хариултаа авч, өдөөлтийн дагуу үйлдсэнээр аав минь гэр бүлийнхээ удирдагч байх ёстой гэдгээ ойлгосон юм. Энэ туршлага бидний бүх зүйлийг өөрчилсөн билээ.

Мормоны Ном нь үнэхээр Есүс Христийн бас нэгэн гэрээ бөгөөд бидний үед зориулан бичигдсэнийг би мэдсэн. Би сэтгэлээр унах ч юм уу өөр ямар ч нөхцөлд байсан энэ номоос тусламж авч болно гэдгийг мэднэ. Хариултууд энэ номонд байдаг.

Чухамдаа “Христийн үгс [бидний] хийвэл зохих бүх зүйлийг [бидэнд] хэлэх болно” (2 Нифай 32:3). ■
АНУ, Канзас, Жүди М. Смит,

Би Нифай ба хугарсан нумны түүхийг уншаад аав руугаа очиж, түүнээс удирдамж болон санваарын адислал өгөхийг хүсэхээр өдөөгдсөн юм.



ЭЭЖЭЭС ИРСЭН ХОЁР ЗАХИДАЛ

1996 онд эхнэр бид хоёр дөрөв ба долоон насны хоёр хүүтэй байлаа. Бид завгүй байдаг ердийн нэг залуу гэр бүл байсан. Нэгэн орой эхнэр маань цаг гарган, Финляндад номлолд үйлчилж байсан миний зээ дүү Гленд захидал бичсэн юм.

Яагаад ч юм, эхнэрт минь гэр бүлийн гишүүн бүрийн хийж байгаа зүйл, сүнслэг байдал, өөрсдийн сүмийн дуудлагууд болон өөрийн хөрвөлтийн түүх мөн номлогчийн ажлын талаарх өөрийн мэдрэмж ба сайн мэдээний тухай гэрчлэл гэх мэт олон зүйлийг нарийвчлан тоочсон урт захиа бичих хэрэгтэй гэсэн мэдрэмж төржээ.

Энэ нь гайхамшигтай сайхан захиа байсан ч зээ дүүд минь ийм их мэдээлэл хэрэгтэй эсэх дээр би эргэлзэж байлаа. Дараа нь эхнэр маань түүнд дахин захидал бичсэн юм.

Зургаан жилийн дараа намайг бишопоор үйлчилж байхад, хөвгүүд маань 10, 13 настай байхад миний амьдрал орвонгоороо өөрчлөгдсөн юм. 2002 оны 1-р сарын 2-нд дөнгөж 42 настайдаа эхнэр минь зүрхний шигдээсээр нас барлаа.

Би “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн зарчмуудыг гэртээ үргэлжлүүлэн дагахыг хичээсэн юм.¹ Би гэр бүлээ тэргүүлж, шаардлагатай зүйлсээр нь хангаж чадаж байсан ч хөвгүүдээ хэрэгтэй хайр халамжийг өгч чадахгүй байлаа. Гэсэн хэдий ч бид чадах бүхнээ хийсээр байсан.

2012 оны 6-р сард Колорадогийн Денверт бүрэн цагийн номлолд үйлчилж байсан миний бага хүү Сэм над руу э-мэйл явуулсан юм. Тэр: “Энэ долоо хоногт маш сайхан зүйл тохиолдлоо. Би ээжээс хоёр захиа авсан” гэж бичсэн байв.

Тэр үеэл Гленээс илгээмж хүлээн авсан бөгөөд түүнийг Финляндад

байхад ээжийнх нь бичсэн захидлуудыг хийж явуулсныг тайлбарласан юм.

“Түүнийг номлолд байхад бичсэн ээжийн энэ хоёр захиа бол намайг номлолд байхад надад хандан бичсэн болохыг тэр надад хэлсэн. Тэгээд захидлуудыг надад илгээсэн юм. Захидлууд үнэхээр гайхалтай байсан шүү!” гэж Сэм бичжээ.

Ээжийнхээ хөрвөлт, гэрчлэлээс мөн номлогчийн ажлын талаарх мэдрэмжүүдээс суралцах нь “энэ цаг үед агуу ёс суртахууны дэмжлэг” болж байсан гэж Сэм бичсэн байв. Тэр захидлуудыг хувилаад эх хувийг нь гэр рүүтээ явуулахаар төлөвлөж байгаагаа хэлсэн юм.

“Би таныг ахлагчдын чуулгын ерөнхийлөгч эсвэл тойргийн номлолын удирдагчаар үйлчилж байсныг огт мэдээгүй” гэж Сэм бичсэн байв. Тэр дөрвөн настай байхдаа “залбирсныхаа дараа орон дээрээ үсэрч, ‘би номлогч болмоор байна’ гэж хашгирдаг байснаа мөн олж мэдсэн гэнэ.

1996 онд бичсэн эдгээр захидлын үгс хувь хүнд хандсан бөгөөд хүч нөлөө ихтэй мөн тун чамбай бичигдэж, үнэ цэнэ нь олон жилийн дараа улам өссөн байлаа.

Дараа нь тэр ээжийнхээ талаар мэдсэн зүйлээ бичсэн байв: “Ээж намайг бөх болно гэдгийг мэдэж байсан учраас намайг мэргэжлийн бөхийг ч давж чадна гэж хэлж байжээ.”

Сэм захидлуудыг яаж хүлээж авсныг мэдээд нулимс минь өөрийн эрхгүй асгарч билээ. Хэдэн долоо хоногийн дараа тэрээр захидлуудыг гэр рүүтээ илгээв. 1996 онд бичсэн эдгээр захидлын үгс хүч нөлөө ихтэй бөгөөд хувь хүнд хандсан мөн тун чамбай бичигдэж, үнэ цэнэ нь олон жилийн дараа улам өссөн байсан юм.

Эхнэрийн минь захидлууд зээ дүүг минь хүчирхэгжүүлсэн бөгөөд “талхыг усны гадаргуу дээр хая” (Номлогчийн үгс 11:1-ийг үзнэ үү) гэсний адилаар тэдгээр нь олон жилийн дараа түүний номлогч хүү, бэлэвсэн нөхөр хоёрыг адислахаар эргэн ирсэн юм. ■

АНУ, Калифорн, Кэн Пиннегар,

ЭШЛЭЛ

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” Лиухона, 2010 оны 11-р сар, 129-ийг үзнэ үү.



БИ ЭЭЖИЙН ЧИНЬ ЦАРАЙГ ХАРСАН

2002 оны зуны нэгэн ням гарагт би саяхан өөд болсон ээжийгээ бодож сэрлээ. Би АНУ-ын Калифорни мужийн Пасифик Палисэйдст байдаг хуучин тойрогтоо очив. Ээж минь тэр сүмд бараг 50 жил явсан юм.

Би ээжийгээ ямар их санаж байгаагаа Их Эзэнд хэлээд тэр өдөр сүнслэг туршлага өгөөч хэмээн гуйж залбирахаар өвдөг сөгдөв.

Тэр өдрийн үдээс хойш би Иллинойн Наувугийн ариун сүмийг дахин онцгойлон адислах шууд нэвтрүүлгийг Калифорнийн Санта Моникагийн гадасны байранд үзэхээр төлөвлөсөн байсан юм. Харамсалтай нь би хуралдаанд хоцорч

очсон учраас орж чадсангүй. Би машиндаа буцаж суугаад хурдны зам руу хөдөллөө.

Би явж байх үедээ “Ранди, Мэритэй очиж уулз!” гэж нэгэн дуу хоолой хэлэхийг сонслоо. Мэри бол манай гэр бүлийн сайн найз бөгөөд өөр сүмийн итгэлтэй гишүүн. Тэрээр охин Наташатайгаа хамт манай авга Рубигийн хажууд 25 гаруй жил амьдарсан юм. Хамаатнууд нь ойр байдаггүй учраас тэд манай гэр бүлийн нэг хэсэг болсон байлаа. 1984 онд миний авга Рубиг нас барсны дараа ээж минь Мэри дээр ойр ойрхон зочилж ирдэг байсан бөгөөд ямар нэг жижиг бэлэг юм уу өөрийнхөө хийсэн хоолыг

түүнд үргэлж авчирч өгдөгсөн.

Эхлээд би энэ өдөөлтийг тоосонгүй. Би хэлэлгүй шууд яваад очиж чадахгүй, түүнтэй ярья гэхэд гар утас маань ч байсангүй. Гэнэт нөгөө дуу хоолой дахин сонсдож, энэ удаад илүү чангаар: “Ранди, Мэритэй очиж уулз!” гэх нь тэр. Хурдны замаас гарч амжих хангалттай хугацаа байсан болохоор би энэ удаад уг зөвлөгөөг дагалаа.

Намайг Мэригийн гэрт ирэхэд тэр надтай мэндэлсэн ч бие нь тааруу байгаа харагдлаа. Түүний уйлж байсныг би харангуутаа л мэдсэн. Би түүнээс юу болоо вэ гэж асуув. Тэр хүзүүний бэртлээс болж өвдсөндөө шаналж байснаа хэллээ. Бас түүнд идэх юм бараг юу ч үгүй болсон байлаа. Тэр эмийн сан руу эсвэл дэлгүүр рүү явж чадахгүй болтлоо хүнд өвчилснөө хэлсэн юм.


Би түүнээс манай гэр бүлийнхний хэн нэгнийг яагаад дуудаагүйг асуухад “Би Тэнгэрлэг Эцэгт залбирч, надад туслах хэн нэгнийг илгээхийг гуйсан” гэж хэлэв.

Тэнгэрлэг Эцэг түүний залбирлыг сонсож, намайг илгээсэн гэж би түүнд хэлэв. Биднийг тэврэлдэхэд тэр надад “Чамайг манай хаалганы гадаа ирэх үед би чиний царайг биш харин ээжийн чинь царайг харсан” хэмээн хэзээ ч мартагдахааргүй нэг зүйлийг хэлж билээ.

Би ээжийн минь сүнс надтай ойр байгааг тэр даруй мэдэрч, ээжийнхээ үзүүлэх байсан үйлчлэлийг үзүүлэхээр өдөөгдсөнөө мэдэрсэн. Ээжийн минь амьдрал бусдын төлөө хийсэн үйлчлэлээр дүүрэн байсан юм.

Би Сүнсний дуу хоолойг анхааран сонсох нь хэчнээн чухал болохыг бас ээжийнхээ бусдад үйлчлэх үлгэр жишээг хэзээ ч мартаггүй гэж найддаг. ■

Ранди Рэинолдс Аллен, АНУ, Калифорни

An illustration of a woman with short brown hair, wearing a blue and white long-sleeved shirt, standing in profile and looking out a window. The window has a decorative, multi-paned design. The background is a soft, greenish glow.

Намайг Мэригийн гэрт ирэхэд тэр надтай мэндэлсэн ч бие нь тааруу байгаа харагдлаа. Түүний уйлж байсныг би харангуутаа л мэдсэн.

ТА МИНИЙ ГЭРЛЭЛТИЙГ АВАРСАН

Би 1979-1986 онд Оманд барилгын ажил хийж байхдаа Батлан Хамгаалах Яаманд ажилладаг байлаа. Хүрч очиход хамгийн хэцүү газарт байршилтай төслүүдийг Яам өгдөг байсан бөгөөд ихэнх тохиолдолд төслүүдийг би ганцаараа хариуцдаг байв. Би бас яамандаа цорын ганц сүмийн гишүүн байлаа.

Нэг өдөр би компанийхаа төв байранд өмнө нь сүмийн талаар сөрөг зүйл хэлж байсан нэгэн цахилгааны инженертэй тааралдлаа. Би өөр төсөл дээр ажиллахаар явахасаа өмнө төв албанд богино хугацаагаар ажилладаг байсан болохоор түүний хэлсэн үгийг тэвчин өнгөрүүлсэн юм.

Удалгүй энэ залуу Оманы Йементэй залгаа хилийн ойролцоо баригдаж байсан төслүүдийн цахилгааны ажлыг шалгахад томилогдсон байв. Түүнийг төв алба руу буцахаас өмнө бид хоёр нэг цагийг хамт өнгөрөөх хуваарьтай байлаа.

Тэр ирээд ажил шалгахад бүх зүйл санаанд нь нийцэв. Би түүнтэй хамт байхдаа ярианы сэдвээ ажил руугаа чиглүүлэхийг хичээж байсан бөгөөд түүнийг явах болоход нислэгийн зурвас руу машинаараа хүргэж өглөө.

Энэ үе борооны улирал байсан бөгөөд Энэтхэгийн далайгаас 6000 тохой (1830 метр) өндөрт орших уулын өндөрлөг хэсэгт байрлах нислэгийн зурвас үүлээр бүрхэгдсэн байв. Хамт ажилладаг хүний маань нислэг хойшлогдлоо.

Би энэ хүнтэй нислэг хүлээж, машин дотор хамт байхаас аргагүй болсноо мэдэх үед зүрх хүчтэй цохилж байлаа. Чимээгүй залбирсныхаа дараа би энэ залуугийн гэр бүл, ялангуяа эхнэрийнх нь талаар асууя гэсэн бодол санаанд орж ирэв.

Намайг асуухад эхнэр маань надаас салах бодолтой байгаа гэсэн гэж хэлээд инженер залуу гэнэт уйлж эхлэв. *Хайр* гэдэг үг тэр даруй миний санаанд орж ирсэн бөгөөд хоёр цагийн турш бид бусдыг хайрлах хайрын тухай болон бид бүгдийг хайрладаг Их Эзэн Есүс Христийн хайрын талаар ярилцлаа. Бид нэг л мэдэхэд найзууд болчихсон байв. Биднийг ярьж дуусахад үүл арилж, инженер онгоцондоо суусан юм. Удалгүй тэрээр албан тушаалаасаа чөлөөлөгдөж, гэртээ буцсан тухай би сонсч билээ.

Хэдэн жилийн дараа би Аароны санваартан залуу эрэгтэйчүүдтэй хамт Английн өмнөд эргийн хот Плаймаутад зугаалж явахдаа нэг эрэгтэй хүн миний өөдөөс ирж явахыг анзаарлаа. Тэр над руу ойртон

ирээд “Би чамайг байна гэж бодсон шүү, Нийл ээ” гэв.

Энэ хүн бол Оманаас ирсэн нөгөөх цахилгааны инженер байлаа. Түүний: “Тэр өдөр уулан дээр надтай хайрын талаар ярилцсанд баярласан шүү. Та миний гэрлэлтийг аварсны төлөө би үргэлж талархаж явах болно” гэж хэлсэн үг миний зүрх сэтгэлд хоногшин үлдсэн юм.

Бид хэдэн үг сольсны дараа тэр яваад өгсөн. Түүнээс хойш би түүнтэй уулзаагүй.

Би Оманд хүлээн авсан тэрхүү сүнслэг удирдамжинд үргэлж талархаж явах болно. Энэ нь инженер залууг адисалж, гэрээсээ хол, ганцаараа байх үедээ сүмийн заадаг зүйлүүдийг дагах хүч чадлыг надад өгсөн билээ. ■

Англи, Йоркшир, Нийл С.Роу

Сүмийн талаар сөрөг зүйлс хэлсэн хүнтэй нислэг хүлээж, машин дотор хамт байхаас аргагүй болсноо мэдсэн үед зүрх хүчтэй цохилж байлаа.





Ахлагч
Гэррит В.Гонг
Дал

Христээр

ТӨГӨЛДӨРЖИХ НЬ

Бид хүүхдүүдтэйгээ хамт “Би Аврагчийн надад үнэгүй өгдөг хайрыг мэдэрдэг” гэж дуулдаг.¹

Үнэгүй өгөгддөг Түүний цагаатгагч хайр нь “мөнгөгүйгээр мөн төлбөргүйгээр, сүү болон бал худалдаж” авахтай адил юм (2 Нифай 26:25). Хэмжээлшгүй хийгээд мөнхийн (Алма 34:10-ыг үзнэ үү) Цагаатгал нь биднийг “Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн” хэмээн урьдаг (Моронай 10:32).

Аврагчийн үнэгүй өгдөг цагаатгагч хайрыг ойлгох нь төгс төгөлдөр байдал гэж юу болох талаар бидний өөртөө оногдуулсан, буруу бөгөөд бодит бус хүлээлтээс чөлөөлж чадна. Ийм ойлголт нь бид төгс биш, бид алдаа гаргадаг, бид хангалттай сайн биш, бид бусдын хажууд бүтэлгүй, бид Түүний хайрыг хүртэхээр зохистой биш гэсэн—айдсуудаасаа салах боломжийг бидэнд олгодог.

Аврагчийн үнэгүй өгдөг цагаатгагч хайр нь бидэнд илүү өршөөнгүй байхад мөн бусдыг болон өөрсдийгөө улам бага шүүмжилдэг болоход тусалдаг. Энэхүү хайр нь бидний харилцааг эдгээж; хайрлах,

Аврагчийн үнэгүй өгдөг цагаатгагч хайрыг ойлгох нь төгс төгөлдөр байдал гэж юу болох талаар бидний өөртөө оногдуулсан, буруу бөгөөд бодит бус хүлээлтээс чөлөөлж чадна.

ойлгох болон Аврагчтай адил үйлчлэх боломжийг бидэнд олгодог.

Түүний цагаатгагч хайр төгс төгөлдөр байдлын талаарх бидний үзэл бодлыг өөрчилдөг. Бид Түүнд найдлага тавьж, Түүний зарлигуудыг хичээнгүйлэн сахиж, итгэлд үргэлжлүүлэн (Мозая 4:6-г үзнэ үү) мөн илүү их даруу байдал, талархал, Түүний сайн үйлс, нигүүлсэл, ач ивээлд найдах мэдрэмжийг мэдэрч чадна (2 Нифай 2:8-ыг үзнэ үү).

Илүү өргөн утгаар нь авч үзвэл Христэд ирж, Түүгээр төгөлдөржих нь төгс төгөлдөр байдлыг бидний

сүнсний болон бие махбодын эсвэл бидний бодгалийн мөнхийн аяллын замд тавьдаг (С ба Г 88:15-ыг үзнэ үү). Төгс төгөлдөр болох нь бидний энэ амьдралын мөн үхэл ба амилуулалтын, бүх зүйл “өөрсдийн зохих мөн төгс хэлбэртээ” (Алма 40:23) сэргээгдэх аялалын үр дүн юм. Энэ нь бидний зүрх сэтгэл болон хүсэлд “хүчирхэг өөрчлөлт” (Мозая 5:2) авчирдаг сүнслэг төрөлтийг багтаадаг. Энэ нь бид Христийнхтэй адил үйлчлэл хийснээр мөн Аврагчийн зарлигуудыг болон гэрээнүүдээ дуулгавартай сахиснаар ирдэг насан туршдаа хийх сайжралтыг харуулдаг. Мөн энэ нь амьд болон нас барсан хүмүүсийн хоорондын харилцааг төгөлдөржүүлэх явдлыг хүлээн зөвшөөрдөг билээ (С ба Г 128:18-ыг үзнэ үү).

Төгс төгөлдөр байдал гэдэг үг нь заримдаа хэзээ ч алдаа гаргахгүй байх явдал хэмээн буруу ойлгогддог. Магадгүй та эсвэл таны мэддэг хэн нэгэн төгс байхын тулд энэ арга замаар маш их хичээж байж болох юм. Ийм төгс төгөлдөр байдал нь бидний хэрээс хэтэрсэн мэт санагдаж, хамгийн сайн хүчин



чармайлтууд маань биднийг сэтгэл түгшин, санаагаар унасан байдалтай юм уу тэнхээ тамиргүй болгож мэднэ. Бид нөхцөл байдлаа болон эргэн тойрныхоо хүмүүсийг хянах гэж хичээдэг нь амжилтгүй болдог. Сул дорой чанар болон алдаануудаа бид цухалддаг. Чухамдаа бид илүү их хичээх тусам эрэлхийлж буй төгс төгөлдөр байдлаасаа улам бүр холдож байгаа мэт мэдрэмж төрдөг.

Би хэлэх гэж буй зүйлсээрээ дамжуулан Есүс Христийн Цагаатгалын сургаал болон Аврагчийн үнэгүй өгдөг хайр ба нигүүлсэлд талархах талархлаа гүнзгийрүүлэхийг хүсч байна. Өөрсдөдөө, бусад хүнд, тухайлбал номлогч, оюутан, ганц бие залуучуудад болон эцэг, эх, ганц бие өрхийн тэргүүнүүдэд мөн төгс төгөлдөр байдлыг олох гэж юм уу төгс байх гэсэн хүнд дарамтыг мэдэрч байж болох хүмүүст туслахын тулд Цагаатгалын сургаалын тухай мэдлэгээ ашиглаасай гэж та нараас хүсч байна.

Есүс Христийн Цагаатгал

Дэлхийн үүслээс бэлтгэгдсэн (Мозая 4:6–7-г үзнэ үү) Аврагчийн маань Цагаатгал бидэнд сурах, наманчлах мөн өөрсдийн туршлага болон сонголтуудаар дамжуулан өсөж хөгжих боломж олгодог.

Энэхүү мөнх бус сорилтын үед “шат шатаар” (С ба Г 98:12) ирдэг сүнсэлэг өсөлт болон бүрэн өөрчлөгдөх зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлт” (Алма 5:12, 13; Мозая 5:2) гэсэн сүнсэлэг туршлагаудын аль аль нь Христэд ирж, Түүгээр төгөлдөржихөд бидэнд тусалдаг. “Эцсээ хүртэл тэвчих” гэсэн бидний мэддэг хэллэг мөнхийн өсөлт нь цаг хугацаа ба үйл явцаас олонтоо хамаардгийг бидэнд сануулдаг.

Мормоны Номын төгсгөлийн бүлэгт агуу бошиглогч Моронай хэрхэн



Христэд ирж, Түүгээр төгөлдөржихийг бидэнд заадаг. Бид “бурханлаг бусаас [өөрсдөө] татгалздаг.” Бид “Бурханыг [өөрсдийн] бүх хүч, оюун, мөн чадлаар хайрладаг.” Тэгээд Түүний ач ивээл бидэнд хангалттай байж, “түүний ач ивээлээр [бид] Христээр төгс байж болно.” Хэрэв бид Бурханы хүчийг “эс үгүйсгэх аваас” бид “Бурханы ач ивээлээр . . . өөрсдийг [маань] нүглийн ангижралд хүргэх, Эцэгийн гэрээн дэх Христийн цусны урсалтаар ариусгагдсан” байж, ингэснээр бид “ариун, толбогүй болно” (Моронай 10:32, 33).

Эцсийн дүнд, Аврагчийн “агуу их болоод эцсийн золиослол” нь “шударга ёсыг давамгайлах тэр, мөн хүмүүнд, тэд наманчлалд итгэлтэй байх тэр замыг авчрах нигүүлслийн зүрх сэтгэлийг” (Алма 34:14, 15) авчирдаг билээ. Чухамдаа бидний “наманчлалд хүргэх итгэл” нь бидний хувьд Христэд ирж, Түүгээр төгөлдөржиж, “агуу их хийгээд гэтэлгэлийн мөнхийн төлөвлөгөө”-ний (Алма 34:16) адислалуудыг хүртэхэд маань амин чухал юм.

Зөвхөн бидний Аврагч л төгс амьдралаар амьдарсан бөгөөд Тэр ч гэсэн мөнх бус амьдралд суралцаж, өссөн юм.

Аврагчийн Цагаатгалыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөх нь бидний итгэлийг өсгөж мөн бид төгс байх эсвэл бүх зүйлийг төгс хийх ёстой гэсэн дарамттай хүлээлтүүдээс салах зоригийг бидэнд өгдөг. Эсрэг тэсрэг эргэцүүлэл нь нэг бол бүх зүйл төгс төгөлдөр эсвэл ямар ч найдваргүй буруу гэж үздэг. Гэхдээ Бурханы хөвгүүд, охидын хувьд хэдийгээр бид бүрэн дуусаагүй бүтээл ч гэлээ Түүний хамгийн агуу бүтээл гэдгийг баяртайгаар хүлээн зөвшөөрч чадна (Дуулал 8:3–6; Еврей 2:7-г үзнэ үү).

Бид Аврагчийн үнэгүй өгдөг цагаатгагч хайрыг ойлгосноор Түүнийг хахир хатуу, өө сэв хайсан шүүгч байх гэдгээс айхаа больдог. Үүний оронд бид “Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ” (Иохан 3:17) гэсэн баталгааг мэдэрдэг. Мөн бид цаг хугацаа болон үйл явц нь өсөж хөгжихөд шаардлагатайг ойлгодог (Моисе 7:21-ийг үзнэ үү).

Бидний төгс үлгэр жишээ

Зөвхөн бидний Аврагч л төгс амьдралаар амьдарсан бөгөөд Тэр ч гэсэн мөнх бус амьдралд суралцаж, өссөн юм. Чухамдаа “тэрээр эхлээд бүрэн байдлыг хүлээн авсан нь үгүй, харин тэрээр бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ач ивээлээс ач ивээлд үргэлжлүүлж байлаа” (С ба Г 93:13).

Тэрээр “бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ [бидний] сул дорой чанаруудыг авах”-аар (Алма 7:12) мөнх бус амьдралын туршлагаар дамжуулан суралцсан юм. Тэрээр уруу таталт, нүглүүдэд эсвэл өдөр тутмын дарамтуудад бууж өгөөгүй боловч мөнх бус амьдралын бүх

бэрхшээл, зовлонгуудад доош бууж ирсэн юм (С ба Г 122:8-ыг үзнэ үү).

Уулан дээрх номлолд Аврагч бидэнд: “Тиймээс та нар төгс бай” (Матай 5:48) хэмээн зарлигласан билээ. Грек хэлний *төгс төгөлдөр* гэдэг үг нь “бүрэн, дууссан, бүрэн хөгжсөн” гэж орчуулагдаж болно (Матай 5:48, зүүлт тайлбар б). Аврагч маань биднээс бүрэн, дууссан мөн бүрэн хөгжсөн буюу Түүний болон Тэнгэр дэх Эцэгийн үлгэр жишээ үзүүлдэг ариун журам ба зан чанараар төгс болгохыг хүсдэг.²

Цагаатгалын сургаалыг ашиглах нь төгс төгөлдөр байдлыг олох гэж юм уу төгс байх хэрэгтэй гэж бодож яваа хүмүүст хэрхэн тусалж болохыг харцгаая.

Перфекционизм буюу төгс байх үзэл

Төгс байх гэдэг нь юу гэсэн утгатай болохыг буруу ойлгох нь *перфекционизм буюу төгс байх үзэл* хэмээх зүйлд хүргэж болно. Энэ нь сайн байхыг хичээсэн биширмээр хандлага эсвэл зан авирыг *яг одоо* төгс байх ёстой гэсэн бодит бус хүлээлт болгон хувиргадаг. Перфекционизм буюу төгс байх үзэл нь заримдаа зөвхөн төгс хүмүүс л хайрлуулах эрхтэй эсвэл бид төгс биш л бол хайрлуулах эрхгүй гэсэн мэдрэмжээс үүдэлтэй юм.

Перфекционизм буюу төгс байх үзэл нь нойргүйдэх, сэтгэл зовних, хойш тавьж назгайрах мөн сэтгэлээр унах, өөрийгөө зөвтгөх болон сэтгэл санааны хямралд орох зэрэг асуудлыг үүсгэж болно. Эдгээр мэдрэмж нь амар амгалан, баяр баясгаланг болон бидэнд байгаасай хэмээн Аврагчийн хүсдэг баталгааг холдуулдаг.

Яг одоо төгс байхыг хүсдэг номлогчид номлолын хэл сурах, хүмүүсийг баптисм хүртэхийг харах эсвэл

номлолын удирдагч болох боломж хурдан ирэхгүй болохоор зовниж эсвэл сэтгэлээр унаж болно. Ололт амжилтад дассан чадварлаг залуу хүмүүсийн хувьд номлол нь амьдралын анхны том сорилт ч байж болно. Гэвч номлогчид төгс байж чадахгүй харин яг таг дуулгавартай байж чадна. Тэд өөрсдийн амжилтыг хувь хүмүүст болон гэр бүлүүдэд “Ариун Сүнсний оршихуйг эдэлдэг итгэлтэй сүмийн гишүүд болоход нь” туслах хичээл зүтгэлээрээ голчлон хэмжиж болно.³

Хичээлийн шинэ жил нь эхэлж байгаа оюутнууд, ялангуяа гэрээ орхин их сургуульд явж байгаа хүмүүс сэтгэл хөдлөл болон санаа зовнилтой тулгарах болно. Мэддэгтэй уран бүтээлч бөгөөд тамирчин байсан оюутан “жигж цөөрөм дэх том загас” байснаа танил бус давалгаатай, урьдаас тааж мэдэх аргагүй урсгалтай далайн жараахай болсон мэт өөрийгөө мэдэрдэг. Перфекционизм буюу төгс байх үзэлтэй оюутнуудын хувьд үүнийг мэдрэх нь амархан байдаг. Тэд хэчнээн их хичээсэн ч бүх зүйлийн эхэнд байж чадахгүй бол өөрсдийгөө бүтэл нь хазайсан гэж үздэг.

Амьдралд олон шаардлага байдаг учраас оюутнууд чадах бүхнээ хийснийхээ дараа ч үргэлж хамгийн шилдэг нь байх боломжгүй бөгөөд энэ нь байдаг л хэвийн зүйл гэдгийг сурч чадна.

Бид түүнчлэн төгс төгөлдөр байдлын хүлээлтүүдийг гэр орондоо бий болгодог. Нэгэн аав эсвэл ээж төгс хань, төгс эцэг эх, төгс гэрийн эзэгтэй, төгс гэр бүлээ тэжээгч эсвэл яг одоо төгс хожмын үеийн гэгээнтэн гэр бүлийн нэг хэсэг байхаар албадуулж байна хэмээн бодож болно.

Перфекционизм буюу төгс байх хандлагатайгаа тэмцэлдэж байгаа хүмүүст юу тусалдаг вэ? Нээлттэй,

урам өгсөн асуултууд нь сайшаал болон хайрыг ойлгуулахад. Ийм асуултууд бусдыг эерэг зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлэхэд урьдаг. Тэдгээр нь бидэнд сайн гэж мэдэрч буй зүйлээ тодорхойлох боломжийг олгодог. Гэр бүлийнхэн болон найзууд өрсөлдөөн дээр суурилсан харьцуулалт хийхээс зайлсхийж, үүний оронд чин сэтгэлийн урам хайрлаж болно.

Перфекционизм буюу төгс байх гэсэн үзлийн өөр нэг ноцтой хэмжүүр нь бусдад өөрсдийнхөө бодит бус, шүүмжлэмтгий эсвэл энэрэнгүй бус жишгүүдээ тулгах явдал юм. Ийм зан авир нь бидний болон бусдын амьдралд Аврагчийн Цагаатгалыг үгүйсгэж эсвэл хязгаарлаж болно. Жишээлбэл, ганц бие залуучууд ирээдүйн эхнэр эсвэл нөхөрт нь байгаасай гэж хүсдэг чанаруудыг жагсаан бичлээ ч төгс хамтрагч олох бодит бус хүлээлтээсээ болоод гэрлэх боломжгүй болж мэднэ.

Тийнхүү хэн нэгэн эгч сайн бүжиглэдэггүй, хөрөнгөтэй болохыг боддоггүй, номлолд үйлчлээгүй эсвэл порнографтай холбоотой өнгөрсөн үеийн асуудлаа хүлээн зөвшөөрч, наманчлал болон зөвлөгөөгөөр дамжуулан үүнийгээ шийдсэн ч байж магадгүй нэгэн зөв зохистой, гайхамшигтай ахтай төгс байх жагсаалтад нь тэнцэхээргүй гэж үзэн болзох бодолгүй ч байж болно.

Үүнтэй адил, нэгэн ах өөрийнх нь бодит бус жагсаалтад тэнцэхээргүй зөв зохистой эгчтэй болзох бодолгүй байж болно. Тэр эмэгтэй спортод тийм ч дуртай биш, Халамжийн Нийгэмлэгийн ерөнхийлөгч ч биш, царайлаг биш, сайн төсөв зохиодоггүй эсвэл тэр мэргэн ухааны үгийн асуудалтай байснаа одоо шийдвэрлэсэн гэж хэлсэн байж ч болох юм.

Мэдээж, бид өөрсдөдөө болон ирээдүйн ханьдаа байгаасай гэж хүсдэг чанаруудыг бодож үзэх ёстой. Бид хамгийн дээд найдвар болон жишгүүдээ хадгалах ёстой. Гэвч хэрэв бид даруу байвал хүсэн хүлээгээгүй газраас биднийг гайхахад хүргэх сайн сайхан зүйл гарч ирэх болно. Мөн бидэнд өөрсөдтэйгээ адил төгс биш хэн нэгэнтэй ойр дотно болох боломж ч гарч ирж магадгүй.

Итгэл нь наманчлал ба Цагаатгалын хүчээр сул дорой байдал хүчирхэгжиж, наманчилсан нүгэл үнэхээр уучлагддаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Аз жаргалтай гэрлэлт нь хоёр төгс хүн тангараг өргөснөөр бий болдоггүй. Харин төгс бус хоёр хүн хамтдаа барьж босгон, талархаж мөн тусалж, дэмжин, уучилснаар бүхнээ зориулсан байдал, хайр хоёр өсдөг. Орчин цагийн нэгэн бошиглогчийн эхнэрээс бошиглогчтой гэрлэх нь ямар байдаг тухай асуужээ. Тэрээр: би бошиглогчтой гэрлээгүй, харин ямар ч дуудлага хүлээн авсан сүмд бүхнээ зориулсан эрэгтэйтэй гэрлэсэн гэж ухаалгаар хариулсан байна.⁴ Өөрөөр хэлбэл, цагийн аясаар нөхөр, эхнэр хоёр хувь хувьдаа болон хосын хувьд хамтдаа өсдөг.

Төгс гэргий, төгс боловсрол, төгс ажил эсвэл төгс байшинг хүлээх нь урт удаан, ганцаардмал байдалд хүргэх болно. Бид амьдралынхаа чухал шийдвэрүүдэд Сүнснийг дагадаг, төгс байх үзлээс үүдэлтэй эргэлзээнд бидний өсөлтийг зогсоохыг үл зөвшөөрдөг мэргэн байх ёстой.

Ачаа дарамт юм уу санаа зовнилыг үе үе мэдэрдэг хүмүүст хандаж хэлэхэд: “Би төгс төгөлдөр байдал ба амжилтыг Аврагчийн цагаатгагч хайрын сургаалаар тодорхойлдог уу эсвэл дэлхийн жишгээр

тодорхойлдог уу? Би амжилт эсвэл бүтэлгүйтлийг Ариун Сүнс миний зөв шударга хүслүүдийг батлах баталгаагаар хэмждэг үү эсвэл дэлхийн ямар нэг жишгээр хэмждэг үү?” гэж өөрөөсөө чин сэтгэлээсээ асуу.

Бие махбодын хувьд эсвэл сэтгэл санааны хувьд ядарч туйлдсан хүмүүс тогтмол унтаж, хэвтэх болон хооллож, амрах цаг гаргаж бай. Завгүй байх нь зохистой байхтай адил зүйл биш гэдгийг, зохистой байх нь төгс төгөлдөр байхыг шаарддаггүй гэдгийг ойлго.⁵

Сул тал буюу дутагдлаа олж харамтгай хүмүүст хандаж хэлэхэд том ч бай, жижиг ч бай өөрсдийнхөө сайн хийдэг зүйлсэд талархалтай ханд.

Бүтэлгүйтэхээс айдаг мөн үүнийг хойшлуулдаг, заримдаа үүнд хэт их бэлддэг хүмүүст хандаж хэлэхэд агуу өсөлт авчрах, хүч чадал сорьсон үйл ажиллагаануудаас ухрах хэрэггүй гэдэгт итгээрэй.

Шаардлагатай болон тохиромжтой цаг үед амарч, амьдралаа эерэгээр бодож зохион байгуулан, өөрийгөө ялагдалд хүргэдэг зан авируудаа багасгаж, талархлыг илүү их мэдрэхийн хамт талархлаа илэрхийлэхэд тань туслах сүнслэг зөвлөгөөг юм уу чанартай сайн эмчилгээг эрэлхийлээрэй.⁶

Тэвчээргүй байдал итгэлд саад болдог. Номлогчдыг шинэ хэл, шинэ соёлыг ойлгоход, оюутнуудыг шинэ хичээл судалж эзэмшихэд мөн ганц бие залуучуудыг бүх зүйл төгс болохыг хүлээхийн оронд харилцаа холбоо үүсгэхэд нь итгэл болон тэвчээр туслах болно. Мөн итгэл болон тэвчээр нь ариун сүмийн лацдан холболт хийлгэх зөвшөөрлийг эсвэл санваарын адислалуудын сэргээлтийг хүлээж буй хүмүүст ч бас тус болно.



Сул талаа буюу дутагдлаа харамтгай хүмүүст хандаж хэлэхэд том ч бай, жижиг ч бай өөрсдийнхөө сайн хийдэг зүйлсэд талархалтай ханд.

Бид өөрсөд дээрээ үйлдүүлэхгүй байж, өөрсдөө үйлдсэнээр (2 Нифай 2:14-ийг үзнэ үү) ариун журамтай бөгөөд тэнцвэртэй амьдралаар амьдарч, их өсөлтөд хүрч чадна. Энэ нь “нэгд нийлэн” бас “сөрөг тал” (2 Нифай 2:11) болон илэрч болно.

Жишээлбэл, бид залхуу байхаа больж чадна (С ба Г 88:124-ийг үзнэ үү). Үүнийг бид өөрт буй хүчнээс илүү хурдан гүйхгүйгээр хийж чадна (Мозая 4:27-г үзнэ үү).

Бид “сайн зарчимд санаа сэтгэлээ зориулж,” (С ба Г 58:27) үе үе амсхийж, “хөдөлгөөнгүй байж мөн би бол Бурхан гэдгийг” мэдэж чадна (Дуулал 46:10; түүнчлэн С ба Г 101:16-г үзнэ үү).

Бид Аврагчийн төлөө амиа алдсанаар үүнийгээ олж авч чадна (Матай 10:39; 16:25-ыг үзнэ үү).

Бид “сайныг үйлдэхэд шантрамтгай бүү” байж, (С ба Г 64:33; түүнчлэн Галат 6:9-ийг үзнэ үү) мөн сүнслэг байдал болон бие махбодын хувьд сэргэх хангалттай цаг гаргаж болно.

Бид хөнгөн хуумгай биш, хөгжилтэй зүрх сэтгэлтэй байж чадна.

Бид их зан гаргалгүй, чин сэтгэлээсээ инээж чадна.

Бидний Аврагч болон Түүний Цагаатгал биднийг “Христэд ирж мөн Түүгээр төгөлдөржигтүн” гэж урьдаг. Бид үүнийг хийхэд Тэрээр Түүний “ач ивээл та нарт хангалттайгаас . . . та нар Христээр төгс байж болно” (Моронай 10:32) хэмээн амладаг.

Төгс төгөлдөр байдалд хүрэх ёстой эсвэл одоо төгс байх ёстой гэсэн дарамттай яваа хүмүүст бидний Аврагчийн үнэгүй өгсөн цагаатгагч хайр:

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая.

“ . . . Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн” гэж амладаг билээ (Матай 11:28, 30).⁷ ■

ЭШЛЭЛҮҮД

1. “I Feel My Savior's Love,” *Children's Songbook*, 75.
2. Рассэлл М.Нэлсон, “Perfection Pending,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 86–88-ыг түүнчлэн үзнэ үү.
3. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* (2004), 10.
4. Лавина Фийлдинг, “Camilla Kimball: Lady of Constant Learning,” *Ensign*, 1975 оны 10-р сар, 62.
5. Жишээ болгож, Дийтр Ф.Угдорф, “Дөрвөн нэр,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 58–61-ийг үзнэ үү. Ерөнхийлөгч Угдорф түүнчлэн “Зарим хүн өөрсдийнх нь үнэ цэнэ тэдний хийх ёстой зүйлсийн жагсаалт хэр урт байхаас хамаарна гэж боддог байж магадгүй” хэмээн анхааруулжээ (“Of Things That Matter Most,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 20).
6. Энэ санааг Хонконгод томилогдсон Азийн бүсийн сэтгэл зүйн эрүүл мэндийн зөвлөхүүд болох Карлос Ф.Аланэ Каи Ваткинс нараас авсан. Энэ өгүүлэл дэх бусад санааг Сюзан Гонг, Ларри Я., Линда Вилсон, Ранди Д., Андреа Фанк, Жанет С.Шарман болон Индонезийн Жакарта номлолын номлогчдоос авсан юм.
7. Түүнчлэн Сэил О.Самуэлсон, “What Does It Mean to Be Perfect?,” *New Era*, 2006 оны 1-р сар, 10–13; Жанет С.Шарман, “Seeking Perfection without Being a Perfectionist,” *Virtue and the Abundant Life: Talks from the BYU Religious Education and Wheatley Institution Symposium*, Ллойд Д.Ньюэл болон бусад хүмүүс хянасан (2012), 280–302.

БУРХАНЛАГ ГЭРЭЭНҮҮД

ХРИСТЭД ТУУШТАЙ ИТГЭГЧДИЙГ ТӨРҮҮЛДЭГ

*Бидэнд хүч өгдөг гэрээнүүдийг Бурхантай хийж,
сахина гэдэг нь юу гэсэн үг вэ?*



**Ахлагч Д. Тодд
Кристоффэрсон**

Арванхоёр
Төлөөлөгчийн чуулга

Перу улс 2007 оны 8-р сарын 15-нд болсон хүчтэй газар хөдлөлтөөр асар их хохирол амссан бөгөөд далайн эргийн Писко, Чинча хотууд бүрэн сүйрчээ. Чинча дахь сүмийн Балсонсито салбарын ерөнхийлөгч Вэнчеслао Конде орон гэрээ алдсан хүмүүст туслах ажлыг сүмийн олон гишүүн, удирдагчтай адил яаравчлан эхлүүлжээ.

Газар хөдлөлтөөс хойш дөрөв хоногийн дараа Далын ахлагч Маркус Б.Наш тэндхийн аюулд нэрвэгдэгсдэд туслах ажлыг зохицуулахаар Чинчад очиж, ерөнхийлөгч Кондетэй уулзжээ. Тэд сүйрлийн цар хүрээний талаар болон хохирогчдод туслахын тулд хийсэн ажлуудынхаа талаар ярилцаж байтал ерөнхийлөгч Кондегийн эхнэр Памела бяцхан хүүгээ тэвэрсээр орж ирлээ. Ахлагч Наш Конде эгчээс хүүхдүүд нь ямар байгааг асуув. Тэрээр инээмсэглэн, “Бурханы авралаар тэд бүгд эсэн мэнд байгаа” гэж хариулжээ. Гэр орон нь хэр их сүйдсэнийг тэр асуув.

Памела энгийнээр “байшин байхгүй болсон” гэлээ.

“Эд хогшил чинь яасан бэ?” гэж асуухад “Хамаг юм байшингийн нурангид даврагдсан” хэмээн Конде эгч хариулав.

“Ийм явдал болсон ч бидэнтэй

ярилцахдаа та инээмсэглэсээр байх юм” гэж ахлагч Нашиг хэлэхэд

“Тийм ээ, би залбирсан тэгээд амар амгалан байна. Бидэнд хэрэгтэй юм бүхэн байна. Бид ч, хүүхдүүд маань ч эсэн мэнд байна. Бид ариун сүмд лацдан холбогдсон, бидэнд гайхамшигтай сүм болон Их Эзэн байна. Их Эзэний тусламжтайгаар бид дахин байшин барьж чадна” гэв.

Гэрээнүүдийн хүч

Ийм ёс суртахууны болон сүнслэг хүчний эх сурвалж юу вэ? Бид энэхүү хүчийг хэрхэн олж авдаг вэ? Үүний эх сурвалж бол Бурхан юм. Бид Түүнтэй хийсэн гэрээнүүдээр дамжуулан энэхүү хүчийг олж авч чадна. Гэрээ гэдэг нь Бурханы тогтоосон нөхцөлүүдээр Бурхан, хүн хоёрын хооронд хийгддэг тохиролцоо юм. Эдгээр бурханлаг гэрээнд Түүний зарлигуудыг сахиж, Түүнд үйлчлэхээр амласны хариуд Бурхан биднийг дэмжиж, ариусган мөн өргөмжлөх үүргийг хүлээдэг.

Бэрхшээл тохиолдсон үед санаа сэтгэлээр өөдрөг байх, гай зовлонг агуу ялаалт болгон хувиргах, “сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, . . . туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах” (С ба Г 58:27) хүчийг бидэнд өгдөг гэрээнүүдийг Бурхантай хийж, сахина гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бэлэг ба адислалуудаар хүчирхэгжих нь

Нэгдүгээрт, бид Есүс Христийн сайн мэдээний зарчим болон зарлигуудад дуулгавартай амьдарснаар Түүнтэй хийсэн гэрээгээр дамжин ирдэг Бурханы амласан байнгын адислалуудыг хүртдэг. Эдгээр адислал нь амьдралын туршид өөрсөд дээрээ үйлдүүлэхийн оронд өөрсдөө үйлдэхэд шаардлагатай эх сурвалжуудаар биднийг хангадаг. Жишээ нь, бие махбоддоо анхаарал халамж тавих тухай Мэргэн ухааны үгэн дэх Их Эзэний зарлигууд нь биднийг хамгийн эхэнд болон юуны түрүүнд “мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сангаар” адисалдаг (С ба Г 89:19). Түүнээс гадна эдгээр зарлиг биднийг илүү эрүүл саруул амьдрал руу хөтөлж, сүйрүүлэгч донтолтуудаас ангид байлгадаг. Дуулгавартай байдал нь бидэнд амьдралаа хянах, өсч хөгжих, ажиллах болон хийж бүтээх илүү өндөр чадавхыг өгдөг.

Хэдийгээр нас өтлөх, осол аварт орох, өвчин эмгэг тусах зэрэг зүйлс бидэнд тохиолдож болох боловч сайн мэдээний энэхүү хуулинд дуулгавартай байснаар эдгээр бэрхшээлийг даван туулах чадвар маань өсөн нэмэгддэг билээ.

Бид гэрээний дагуу амьдарснаар олон бэлэг болон тусламжаар байнга адислагддаг. “Энэрэл хэзээ ч дуусдаггүй” (1 Коринт 13:8; Моронай 7:46), хайр нь хайрыг, нинжин сэтгэл нь нинжин сэтгэлийг, ариун журам нь ариун журмыг, амалт нь үнэнч шударга байдлыг, үйлчлэл нь баяр баяслыг бий болгодог. Бид бол гэрээт хүмүүс, бие биедээ урам хайрлан, дэмжиж, тусалдаг гэгээнтнүүдийн хамт олон юм. Нифайн хэлснээр “хүмүүний үрс Бурханы зарлигуудыг дагавал тэрээр тэднийг асран мөн тэднийг хүчирхэгжүүлнэ” (1 Нифай 17:3).



Өсөн нэмэгдэж буй итгэлээр хүчирхэгжих нь

Энэхүү хоёр дахь арга зам болох гэрээнүүд нь биднийг хүч чадлаар тэтгэдэг. Гэрээнүүд нь цөхрөлтгүй байхад болон Их Эзэний хувьд чухал болох бүх зүйлийг хийхэд шаардлагатай итгэлийг бий болгодог. Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, Түүний зарлигуудыг сахих нь итгэлийг шаарддаг ч бид гэрээнүүддээ үнэнч байвал энэхүү итгэл өсөн нэмэгддэг билээ. Нэгдүгээрт, дуулгавартай байдлын амлагдсан үр жимс бидний итгэлийг нотлох баталгаа болдог. Хоёрдугаарт, Ариун Сүнс нь Бурханы тааллыг бидэнд дамжуулж, бид Түүний цаашид өгөх адислал болон тусламжийг авснаар сэтгэл санаа маань амар амгалан болдог. Гуравдугаарт, амьдралд юу ч тохиолдсон бай Бурханы хүн бүрд нэр нэрээр нь өгсөн адислал байдаг бөгөөд Тэр худал хэлж чадахгүйг мэддэг учраас бид амьдралыг найдвар тээн, тэвчээртэй туулж чадна (Инос 1:6; Ифер 3:12).

Энэ эрин үеийн сүмийн анхны удирдагчид гэрээгээ чандлан сахих нь зовлон бэрхшээлийн үед биднийг хэрэгтэй баталгаагаар хангадгийг нотлон харуулсан юм: “Энэ бол [тэдний баримталж буй амьдралын замнал нь Бурханы тааллын дагуу байгаа гэсэн мэдлэг] эртний гэгээнтнүүдэд зовлон бэрхшээл, хавчлага дарамтуудыг тэвчиж, эд хөрөнгө нь сүйтгэгдэж, устгагдах үед ч баяртай байж мөн үхлийн хамгийн аймшигтай хэлбэрийг тэвчих чадвартай болгосон ба тэд газар дээрх өөрсдийнх нь энэхүү орон гэр алга болох үед тэдэнд хүний гараар баригдаагүй Бурханы мөнхийн өргөө тэнгэрт байгаа гэдгийг мэддэг (зөвхөн итгэх төдий бус) байжээ. (2 Коринт 5:1).”²

Мөн Бурхан биднээс ямар ч золиослолыг шаардсан бай бидний амьдралын замнал Бурханы таалалд нийцэж байгаа гэсэн Сүнсний гэрчийг бид олж авдаг.³ Бурхан зохих цагт зовлон шаналал бүрийг бидэнд ашиг тустай зүйл болгон хувиргах болно гэсэн баталгаагаар бидний итгэл хязгааргүй болдог. (С ба Г 97:8–9-ийг үзнэ үү.)

“Бурханлаг чанарын хүчээр” хүчирхэгжих нь

Бид нэгдүгээрт, хүч чадал олгох адислалуудын талаар; хоёрдугаарт,

Бурхантай хийсэн гэрээнүүдээ сахидаг хүмүүст Түүний олгодог итгэлийн бэлгийн талаар авч үзлээ. Гэрээнүүдээр дамжин ирэх хүч чадлын сүүлчийн хэсэг буюу миний дурдах зүйл бол тэнгэрлэг хүчний бэлэг юм. Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн гэрээгээ сахих амлалт нь Өөрийнхөө бурханлаг нөлөө, “бурханлаг чанарын хүч”-ээр (С ба Г 84:20) бидний амьдралыг элбэг дэлбэг адислах боломжийг Түүнд олгодог. Бид санваарын ёслолуудад оролцож, өөрсдийн сонголтыг ашиглан, энэхүү хүчийг хүлээн авах сонголт хийдэг учраас Тэр үүнийг хийж чадна. Бид санваарын ёслолуудад оролцсоноор өсөн нэмэгдэх гэрэл ба сүнслэг хүч чадлыг дагалдан ирдэг нэмэлт үүрэг хариуцлагыг хүлээн авахад бэлэн байгаагаа харуулдаг.

Бид бүх ёслолд, ялангуяа ариун сүмийн ёслолуудад дээрээс ирэх хүчээр хишиг хүртдэг (С ба Г 109:22-ыг үзнэ үү). Энэхүү “бурханлаг чанарын хүч” нь хүнд Ариун Сүнсний нөлөөгөөр ирдэг. Ариун Сүнсний бэлэг нь шинэ ба үүрдийн гэрээний нэг хэсэг юм. Энэ нь бидний баптисмын амин чухал хэсэг болох Сүнсний баптисм мөн. Энэ бол ач ивээлийн элч бөгөөд үүгээр дамжин Есүс Христийн цус бидний нүглийг арилгаж, биднийг ариусгадаг (2 Нифай 31:17-г үзнэ үү). Энэхүү бэлгээр дамжуулан Адам “доторх хүндээ амьдруулагдсан” (Моце 6:65) юм. Эртний төлөөлөгчид Ариун Сүнсээр дамжуулан, туулсан бүхнээ тэвчиж, санваарын түлхүүрүүдээрээ дамжуулан амьдарч байх хугацаандаа сайн мэдээг дэлхийд түгээсэн билээ.

Бид бурханлаг гэрээнүүдэд орсон үед Ариун Сүнс бидний тайвшруулагч, чиглүүлэгч, хамтрагч болдог. Ариун Сүнсний үр жимс нь “үхэшгүй алдар суугийн амар амгалангийн зүйлүүд; бүх зүйлд амьдралыг өгдөг, бүх зүйлийг амьдруулдаг тэр зүйл; бүх зүйлийг мэддэг мөн мэргэн ухаан, нигүүлсэл, үнэн, шударга ёс, мөн шүүлтийн дагуу бүх хүч байдаг тэр зүйл буюу” (Моце 6:61). Ариун Сүнсний бэлгүүдээс гэрчлэл, итгэл, мэдлэг, мэргэн ухаан, илчлэлт, гайхамшгууд, эдгээлт, энэрэл гэх мэтчилэн цөөнийг нь тоочлоо (С ба Г 46:13–26-г үзнэ үү).

Таныг зааж мөн гэрчлэх үед Ариун Сүнс таны үгсийг гэрчилдэг юм. Энэ





бол дайсагнасан таагүй нөхцөлд ярих үед хэлэх ёстой зүйлийг зүрх сэтгэлд тань өгүүлснээр “та нар хүмүүсийн өмнө мадлагдах нь үгүй” (С ба Г 100:5) гэсэн Их Эзэний амлалтыг биелүүлдэг. Ариун Сүнс нь давшгүй мэт санагдах саад бэрхшээлийг хэрхэн даван туулахыг илчилдэг. Ариун Сүнсээр дамжуулан бусад хүн таны дотор буй Христийн цэвэр хайрыг мэдэрч, урагш тэмүүлэх хүчийг олж авдаг. Мөн Ариун Сүнс нь Өөрийн амлалтын Ариун Сүнсний үүргийнхээ дагуу таны гэрээнүүдийн хүчин төгөлдөр хийгээд үнэ цэнэтэй байдлыг баталдаг бөгөөд Бурханы амлалтуудыг таны дээр лацаддаг юм (С ба Г 88:4–5; 109:14–15-ыг үзнэ үү).

Тэнгэрлэг Эцэг тантай хамт байх болно

Бурханлаг гэрээнүүд Христэд тууштай итгэх итгэгчдийг төрүүлдэг. Хүн бүр хүлээн авах боломжтой

санваарын бүх ёслолд тэнцэхээр зохистой байж, эдгээр ёслолыг хүлээж аван, гэрээгээр хүлээсэн амлалтуудаа итгэлтэйгээр сахихыг би та бүхнээс хичээнгүйлэн хүсч байна. Зовлон зүдгүүр тохиолдсон үед гэрээнүүдээ юунаас ч илүү эрхэмлэж, шууд дуулгавартай дагаж бай. Тэгээд та өөртөө хэрэгтэй байгаа зүйлийг өчүүхэн ч эргэлзэлгүй, итгэлээр гуйж чадах бөгөөд Бурхан хариулах болно. Тэр та нарыг хичээл зүтгэл гаргах үед тань дэмжин туслах болно. Тэр Өөрийнхөө цагт, мутраа урагш сунган, “Би энд байна” хэмээн хэлнэ. ■

2009 оны дөрөвдүгээр сарын Ерөнхий чуулган дээрх “Гэрээнүүдийн хүч” хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Судруудын удирдамж, “Гэрээ”; scriptures.lds.org-ийг үзнэ үү.
2. *Lectures on Faith* (1985), 67.
3. *Lectures on Faith*, 69–71-ийг үзнэ үү.



НЯМ ГАРГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Энэ сарын сэдэв:
Ёслолууд ба гэрээнүүд

ТАНД ЮУ ХАРАГДАЖ БАЙНА?

Бид сайн мэдээний ёслолууд дахь бэлгэдлүүдийг судалж, тэдгээрийн талаар тунгаан бодсоноор бидний бодол Есүс Христ дээр төвлөрдөг

Дэвид А. Эдвардс

Сүмийн сэтгүүлүүд

Бэлгэдлүүд бидний эргэн тойронд байдаг учраас бид ихэнхдээ тэдгээрийн талаар нэг их боддоггүй. Гэвч сайн мэдээний бэлгэдлүүдэд анхаарлаа сайн хандуулах нь илүү их ойлгох түлхүүр болж чадна.

Сударууд бидний бодлуудыг өөр зүйлд хандуулах зорилготой зүйлийг дүрслэхийн тулд *хэв маяг, сүүдэр, бэлгэдэл, таних тэмдэг, тэмдэг, зүйрлэл, дурсамж, гэрч* эсвэл *гэрчлэл* зэрэг үгсийг ашигладаг (Мосе 6:63-ыг үзнэ үү). Жишээлбэл, Есүс сүүлчийн зоог дээр ариун ёслолыг

танилцуулах үедээ дагалдагчдадаа тэдний идэх ёстой талхыг өгөөд “Энэ бол та нарын төлөө өгөх миний бие мөн: Намайг дурсаж үүнийг үйлд” (Лук 22:19) хэмээн хэлсэн. Талх шууд утгаараа Түүний бие биш байсан нь мэдээж. Түүний хэлсэнчлэн энэ нь бидэнд Түүний биеийг—*сануулах* зорилготой бөгөөд *өөр олон зүйлийг* сануулдаг. Ийм учраас л бэлэг тэмдгүүд нь маш хүчтэй байдаг ба тэдгээр нь үггүйгээр санааг илэрхийлж мөн хоорондоо холбоотой хэд хэдэн бодлыг нэг дор үүсгэж, гүн гүнзгий утга нэмдэг.

Ёслолууд нь зүгээр бэлэг тэмдэг төдий зүйл биш бөгөөд тэдгээр нь санваарын эрх мэдлээр дамжуулан адислах бодит хүчийг агуулдаг нь мэдээж юм. Гэвч тэдгээр нь бидэнд Аврагчийн тухай болон гэрээнүүдийн маань талаар заадаг бэлэг тэмдгүүдийг бас агуулдаг. Санваарын ёслолуудыг хүлээн авч байгаа нь аливаа хүний итгэл болон даруу байдлыг харуулдаг. Баптисм, гишүүний баталгаа ба ариун ёслол зэрэг ёслолуудтай холбоотой бэлгэдлүүд болон эдгээртэй холбогдох зарим нэмэлт санаануудыг дор дурдлаа. ■



БАПТИСМ

Ус: угааж, цэвэрлэн, нүглээс ариусгах

Цагаан хувцас: цэвэр ариун байдал (“учир нь өмсгөлүүд нь цагаан болгож угаагдахаас бусгаар нэгээхэн ч хүмүүн аврагдаж чадахгүй... [Христийн] цусаар... цэвэршигдэх... ёстой” [Алма 5:21]); тэгш байдал (ядуу эсвэл баян аль нь ч бай бүгд баптисм дээрхтэй адил хувцас өмсдөг, учир нь “Бурханд бүгд адил” [2 Нифай 26:33])

Өргөсөн баруун гар: тэнгэр рүү чиглэж, тэнгэрт гэрчлэх мөн тангараг өргөж буй нэг хэлбэр (Эхлэл 14:22; Даниел 12:7-г үзнэ үү)

Усанд умбуулалт: Христийн үхэл, оршуулга болон амилалт (Ром 6:3-4-ийг үзнэ үү); Христ готорх бигний сүнслэг дахин төрөлт (“уснаас төрөх” [Иохан 3:5])

ГИШҮҮНИЙ БАТАЛГАА

Гар тавилт: Бурханыг төлөөлдөг хүмүүс гараа тавьж, Бурханы адислалуудыг бусдаг дамжуулдаг

Ариун Сүнсний бэлэг хүлээн авах нь: “галан баптисм” хэмээн нэрлэгддэг (2 Нифай 31:13-ыг үзнэ үү); цэвэршүүлэлт болон Христээр дахин төрөх төрөлт



АРИУН ЁСЛОЛ

Талхыг идэх нь: Есүс Христийн бие махбодыг дурсан санах (Матай 26:26-29-ийг үзнэ үү), амийн талх (“Наг уруу ирдэг хүн өлсөхгүй” [Иохан 6:35], “энэ талхыг идсэн хүн мөнхөд амьдарна” [Иохан 6:58])

Өвдөг сөгдөн залбирах нь: гаруу байдал, Бурханы хүсэлд захирагдах үүргийн гэрээний тэмдэг (С ба Г 88:131-ийг үзнэ үү)

Талхыг үйрүүлэх нь: Бидний төлөө Христийн амссан биеийн зовлон, Түүний бие махбодын үжэл, бидэнд дахин амьдрах боломж олгодог Түүний амилалт

Талх болон усыг цугларагсдын өмнө байрлуулах нь: цус урсгалтаар төгсгөл болсон Христийн золиослолын бэлгэдэл (Алма 34:13-14-ийг үзнэ үү); бид “Их Эзэн Бурхандаа... харууссан зүрх мөн гэмисэн сэтгэлтэйгээр золиослол өргөх ёстой” (С ба Г 59:8)

Ус уух нь (анх гарс байсан): Христийн цус (Гетсеманид цэргүүдийн гарт зовж байхад болон загалмай дээр урссан), энэ нь “биднийг бүх нүглээс цэвэрлэдэг” (1 Иохан 1:7) мөн “[биднийг] нүглийн ангижралд хүргэх, Эцгийн гэрээн дэх” (Моронай 10:33); цус нь “амьдралын үндэс буюу бүх маханбодын амин чухал эрч хүч” (Сугруудын удирдамж, “Цус”; scriptures.lds.org) мөн золиослолоор гамжуулан нүглийг цагаатгадаг зүйл (Левит 17:11-ийг үзнэ үү); амийн ус (Иохан 4:14-ийг үзнэ үү)



ЦАГААТГАЛ ДЭЭР ТӨВЛӨРӨХ НЬ

“Сайн мэдээний ёслол бүр нь ямар нэг байдлаар Их Эзэн Есүс Христийн Цагаатгал дээр төвлөрдөг билээ. Иймээс [ариун ёслолын] энэхүү онцгой зан үйл нь ямар учраас өөрийн бүхий л бэлгэдэл болон дүрслэлүүдийнхээ хамт амьдрал дахь өөр ямар ч зүйлээс илүү бидэнд ойр дотно байж, илүү олон удаа давтагддаг нь ойлгомжтой юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “This Do in Remembrance of Me,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 67.

ХАМТДАА ЯРИЛЦ

НЯМ ГАРАГТ ТУНГААН БОДОХ ЗҮЙЛС

- Баптисм, гишүүний баталгаа болон ариун ёслолын бэлгэдлүүд нь Христийг болон гэрээнүүдээ санахад танд хэрхэн тусалдаг вэ?
- Долоо хоног бүр болдог ариун ёслолын турш танд юу бодогддог вэ?

ТАНЫ ХИЙЖ БОЛОХ ЗҮЙЛС

- Ариун ёслолын турш бодсон эсвэл мэдэрсэн ямар нэг зүйлээ тэмдэглэлдээ бич.
- Ариун ёслолын бэлгэдлийн тухай болон энэ нь танд Аврагчийг дурсан санахад хэрхэн тусалдаг талаар сүм дээр үг хэл.

БИДНИЙ ОРОН ЗАЙ

ӨВӨӨГИЙНХӨӨ ТӨЛӨӨ ХИЙСЭН БАПТИСМ

Өсвөр үеийнхний удирдагчид маань ариун сүмд очихоор төлөвлөсөнд би талархалтай байна. Бид Самоагийн Апиа руу явах аялалдаа бэлдэж байхдаа энэ ховор боломжийн төлөө баяртай байсан. Сүнсний дэлхийд байгаа нас барагсдынхаа өмнөөс баптисм хүртэхээр бид ариун сүм рүү баяр хөөртэй явцгаасан. Тэд биднийг гэр бүлийн түүхээ олж мэдэн, тэдний өмнөөс ариун сүмийн ажлыг хийгээсэй гэж хүлээж байсан юм.

Баптисмын үеэр манай бүлгийн нэг залуу эргэ-тэй миний өвөө Фаатага Агавалэгийн өмнөөс баптисм хүртэхийг би харсан. Нүдэнд минь баярын нулимс цийлэгнэж, түүний сүнс тэнд байгаа гэдгийг би мэдэрч байлаа. Бид ариун сүмд түүний өмнөөс ажил хийх боломжтой байсандаа би маш их баярласан.

Самао, Саини Агавалэ



НАЙЗААС МИНЬ ИРСЭН ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Өсвөр насандаа би сүмд явах дургүй байсан учраас Библи эсвэл Бурханы талаар ихийг мэддэггүй байсан бөгөөд мэдэхийг ч хүсээгүй юм. Намайг 17 настай байхад нэг найз маань өөрийгөө Мормон гэж надад хэлсэн. Мормон гэж юу байдаг талаар ямар ч ойлголт надад тэр үед байгаагүй. Би найздаа “Хэрэв би тэр сүмийн талаар ямар нэг зүйл мэдэхийг хүсвэл өөрөө олоод авчихна” гэж хэлсэн юм.

Намайг шашны талаар тийм ч их анхаарал хандуулахгүй байгааг хараад тэр надад Мормоны Ном өгч, үүнийг уншаад энэ талаар залбирахыг хүслээ. Тэр намайг хүчлээгүй. Орой нь би уг номыг нээгээд урд талд нь бичсэн түүний гэрчлэлийг олж харлаа. Түүний гэрчлэлийг унштал Мормоны Номын талаар би илүү ихийг мэдэх ёстой гэсэн мэдрэмж надад төрсөн юм. Тэгээд би 1 Нифайг уншиж эхлэв. Би номыг гараасаа ч салгаж чадахгүй уншлаа. Би илүү ихийг мэдэх хэрэгтэй байв.

Нэг гэр бүлийн үдэш дээр түүний гэр бүл надад Есүс Христийн сайн мэдээний талаар заасан юм. Бүх зүйл ойлгомжтой байлаа. Удалгүй би номлогчдоор заалгаж, баптисм хүртэн, Их Эзэний үнэн сүмийн гишүүнээр батлагдсан. Сайн мэдээ надад өөрийгөө хэн болохыг, хаанаас ирснийг мөн би итгэлтэй байж чадвал хаана очиж болохыг мэдэхэд тусалсан.

Би энэ бүхнийг эргэж хараад Ариун Сүнс надад илүү ихийг мэдэхээр хүсэхэд тусалсан гэдгийг ойлгодог. Би илүү ихийг сурах тусам сүм болон Бурханы талаарх миний хандлага өөрчлөгдсөн. Амьдралдаа анх удаа би Түүний намайг хийгээсэй гэж хүссэн зүйлийг хийхийг хүссэн.

Мормоны Ном миний амьдралыг өөрчилсөн ба үүнийг надтай хуваалцсан найздаа би талархаж байна. Жинхэнэ найз л иймэрхүү чухал мэдээллийг хуваалцдаг билээ.

АНУ, Огайо, Майкл П.



Рандалл Л.Ридд

Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

АЖИЛ ХӨДӨЛМӨР ХЭНД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Ажил нь үргэлж сонирхолтой биш байж болно, гэвч энэ нь та нарыг ямар их аз жаргалтай, сайн сайхан мэдрэмжтэй болгогчийг мэдээд та нар гайхаж магадгүй.

Би өсвөр насандаа бусдын адил тоглож, хөгжилдөх дуртай байсан. 16 нас хүрсэн үедээ би гадуур болзоонд явж, найзуудтайгаа цагийг өнгөрөөх дуртай байлаа. Эдгээр үйл ажиллагаа надад ажлаас илүү таалагддаг байв.

Гэхдээ та нарын олонхтой адил би ажилтай байсан. Аав минь барилгын салбарт ажиллаж, байшин барьдаг байсан ба гурван ахыг минь болон намайг байнга ажиллуулдаг байсан юм. Энэ ажил их халуун бөгөөд бас их хүч шаарддаг байв. Заримдаа би үнэхээр ажиллах хүсэлгүй болдог байсан. Гэвч бидэнд ажлын хуваарь болон дуусгах ёстой төслүүд байсан учраас бид өдөр бүр ажлаа дуусгах хүртлээ шаргуу ажилладаг байв. Би тухайн үедээ анзаараагүй боловч гэр бүлийнхэнтэйгээ хамт ажилласнаар надад нэлээн их зүйл зааж сургасан байв.

Сайн хийсэн ажлаас сэтгэл хангалуун болдог

Байшин барих нь маш их цаг, хүч чармайлт, нарийн тооцоо шаарддаг. Байшингийн суурь ухах ажлыг би тийм их нарийвчлалтай хийх ёстой гэж боддоггүй байлаа. Харин аав минь үүнд өөрөөр хандаг байсан юм.

Байшингийн суурийг тавихын тулд эхлээд газраа ухах, дараа нь цемент цутгах ёстой. Суурь нь зузаан цемент байдаг бөгөөд байшингаас өргөн байдаг. Сууриа цутгасны дараа үүнийхээ дээр дахин суурь хийдэг. Тэгээд үүнийгээ дахин шороогоор булна.

Суурийг заавал дөрвөлжин тавих ёстой эсэх дээр би олонтоо эргэлздэг байсан. Үүнийг шороогоор булсан учраас хэн ч үүнийг харахгүй бөгөөд энэ нь байшингийн бат бөх байдлыг сулруулахгүй гэж би боддог байв. Гэвч аав минь энэ суурийг дөрвөлжин, тэгшхэн байлгахыг

хүсэж, хэмжээг маш анхааралтай, зөв авдаг байсан бөгөөд байшин барих болгондоо ингэж нарийн хэмжилт хийдэг байсан юм.

Эргээд бодоход аав минь хийж буй бүх зүйлдээ, тэр ч байтугай байшингийн эзний хэзээ ч анзаарахгүй зүйлд ч мөн ийм байдлаар ханддаг байсныг би ойлгодог. Тэр жижиг зүйлүүдэд ч онцгой анхаарал тавьдаг байсан учраас түүний хийсэн ажилд бусад хүн итгэдэг байсан бөгөөд хийсэн ажил нь хамгийн сайн чанартай байвал захиалагчид үүнд талархана гэж сэтгэл хангалуун байдаг байсан.

Зарим тохиолдолд хийх хэрэгтэй ажлаа хэр сайн хийснийг тань Их Эзэнээс өөр хүн мэдэхгүй ч байж болно. Гэвч Их Эзэн та нарын хичээл зүтгэлийг мэддэг нь тодорхой юм. Та нар хамгийн сайнаараа хийх үедээ өөрсдийнхөө талаар сайхан сэтгэгдэлтэй байж, үнэнч шударга зан, бие даах чадвар болон хэрэгтэй



ур чадваруудыг хөгжүүлсэндээ баярлах болно.

Та нар туршлагаараа дамжуулан Их Эзэний: “Хүн юу тарьснаа л хурааж авдаг” хэмээх ургац хураалтын хуулиас суралцах болно (Галат 6:7; түүнчлэн С ба Г 130:20–21-ийг үзнэ үү).

Хандлага бүх зүйлд нөлөөлдөг

Халуунд удаан хугацаагаар суурийн нүх ухах нь хэцүү бөгөөд би үүн дээр үргэлж сайн ханддаг байгаагүй гэдгээ хүлээж байна. Намайг ажлын талаар гомдоллож байхыг харах бүрдээ ээж минь “Болгоомжтой байгаарай. Чи адислалаа алдаж магадгүй шүү, чи тэртээ тэргүй ажиллах хэрэгтэй!” гэж хэлдэг байв (С ба Г 58: 28–29-ийг үзнэ үү.) Ээжийн минь зөв байлаа. Гомдоллоосноор ажил хэзээ ч дуусдаггүй бөгөөд энэ нь сэтгэл хангалуун байдлыг болон ажил хийснээр ирдэг олон адислалыг холдуулдаг.

Ээжийнхээ үгийг дагаж, ажлаа баяр хөөртэй зүрх сэтгэлээр хийхэд цаг илүү хурдан өнгөрч, ажил ч илүү сайн үр дүнтэй болж, гомдоллодог үеийнхээсээ хавьгүй илүү аз жаргалтай болдгийг би олж мэдсэн юм. Хандлага бүх зүйлд нөлөөлдөг.

Хамгийн чухал ажил бол Бурханы ажил

Номлолд үйлчлэх нь миний хувьд чухал туршлага болсон юм. Би ямар ч ажил Тэнгэрлэг Эцэгийн ажлаас илүү чухал биш гэдгийг ойлгосон билээ. Энэ ажил Түүний хүүхдүүд болох бидний амьдралыг: “Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” хэмээн адисалдаг (Моисе 1:39).

Та нар Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг адислах Түүний ажилд оролцсоноор Алмагийн адил “бодгалиудыг наманчлалд авчрахад

Бурханы мутар дахь зэмсэг байж болох нь . . . [та нарын] баясал” (Алма 29:9) гэдгийг олж мэдэх болно.

Урилга

Тэгвэл ажил хөдөлмөр хэнд хэрэгтэй вэ? Бид бүгдэд! Ажил хөдөлмөр бол энэ амьдрал дахь бие даасан байдал, амжилт бүтээл, баяр баясгалангийн эх ундарга мөн. Таныг ажлаа урам зоригтой, ханцуй шамлан хийхэд эргэн тойрны тань бүх хүн арвин ургац хурааж авна. Учир нь та үрийг нь суулгасан шүү дээ.

Та нар долоо хоногийн турш ажиллах үедээ миний мэдэж авсан сургамжийн талаар бодож, туршиж үзэхийг би та нараас хүсч байна. Тухайлбал дараагийн удаа ямар нэг ажил аваад үүнийгээ хамгийн сайнаар, баяр хөөртэй хийгээд юу болохыг нь хараарай. Энэ нь та нарыг ямар их аз жаргалтай, сайхан мэдрэмжтэй болгосонд та бүхэн гайхаж магадгүй. ■

ШАВАРТАЙ ГУТАЛТАЙГАА ХООЛОЙ ЗӨӨСӨН НЬ

Рэимонд М.Аллтон

“Бишоп Роули, танд баярлалаа. Бид туслахдаа тун баяртай байх болно.” Диконы чуулгын зөвлөх Хулэт ах бишопын гараас самбарыг авч, “Надад сүмийн тариан талбайд сайн дураараа ажиллах хүмүүсийн нэр бичих цаас байна. Ирэх долоо хоногт бид бүгдээрээ тусалбал Их Эзэн баяртай байх болно гэдэгт би итгэлтэй байна” хэмээн зарлав.

“Яг юу хийж туслах юм бол?” гэж би сулавтархан асуулаа. Сүмийн тариан талбайн ажил тийм ч таатай сонсогдсонгүй.

“Энэ долоо хоногийн бидний даалгавар бол усалгааны хоолой зөөх.”

Би дахиад нэг ч шүршүүрийн хоолой зөөхийг хүсэхгүй байлаа.



Хоолой зөөх өө! Эдгээр үг намайг айдсаар дүүргэлээ. Зун ажил олж хий гэж ээжийн хэлж байсан нь санаанд орлоо. Манай жижиг сууринд хоолой зөөх—байнга хийх нэг л ажил байсан юм. Би зуны турш үеэл Скоттойгоо хоолой зөөсөн билээ.

Зуны ажлын эхний өдөр бид царгасаар дүүрсэн асар том газрыг харж зогслоо. 40 тохой урт (12 м) хоолойнууд хоорондоо тэгшхэн холбогдсон байсан бөгөөд хэдэн бээр үргэлжилсэн мэт харагдаж байв. Скотт бид хоёр богинохон сургалтад хамрагдсаны дараа хоолойнуудаа салгав. Скотт өөрийнхөө талыг өргөхөд хүйтэн ус миний теннисний гутал руу асгарав. Бид хоолойг нялцгай шавар дундуур өргөж, өндөрлөгч дээр тавиад дахин холбож байлаа. Бид дараагийн хоолойг авахаар алхаж байхад шавар болсон гутал минь улам хүндэрч байв. Удалгүй шавар, ус, бидний хөлстэй нийлэн, хувцас болон сүнснийг нэвт норгож орхив.

Миний бодол санаа сүмийн тариан талбайд ажиллах эсэхээ өөрийн дураар шийдэхэд хүргэлээ. “Би би очиж чадахгүй байх аа. Өглөө бүр өөрийнхөө ажилд явах ёстой” гэж би хэлэв.

“Наадах чинь асуудал биш ээ. Бид сүмийн талбай руу дандаа үдээс хойш явна” гэж Хулэт ах хэлээд нэр бичих цаасыг дамжуулав. “Та нар бүгдээрээ санваарт томилогдохдоо Бурханы нэрээр үйлдэх хүчийг хүлээн авсан. Бид бусдад үйлчлэх замаар Түүнд үйлчлэхдээ Түүний нэрээр үйлддэг шүү дээ. Үүнээс гадна бүгдээрээ хийвэл ажил амархан бүтдэг” гэж тэрээр хэллээ.

Нэрсийн жагсаалт над дээр ирэв. Хүн болгон энэ долоо хоногт ажиллахаар нэрээ бичсэнд би итгэж чадахгүй байв. Тэд энэ ажил хэцүү гэдгийг мэдээгүй юм байх даа? Гэвч би маш зөв шударга шахалтыг мэдэрсэн юм. Тэгээд нэрээ дурамжхан гэгч бичээд цааш дамжуулав.

Даваа гаргийн үдээс хойш ажлаасаа ирээд өрөөндөө амарч байтал гадаа Хулэт ахын дуут дохио дуугарахыг би сонсов. Би хэсэг бодсоноо үнэр орсон, ажлын нойтон хувцсаа буцааж өмслөө.

Бид удалгүй сүмийн тариан талбайд ирэв. Надаас бусад нь талбай руу яаран алхална. Би нэлээн хойно хоцорч, толгой гудайлган, чулуу өшиглөн явж байтал мөрөн дээр хэн нэгэн гараа тавихад гайхав. “Бидэнтэй хамт ирсэнд баярлалаа” гэж Хулэт ах намайг урамшуулаад “Өнөө өглөө их ажилласныг чинь мэднэ ээ” гэлээ. Бид хоёр хэсэг хугацаанд чимээгүй хамт алхав. Тэгээд тэр бүлгийг зохион байгуулахаар урагш түрүүлэн алхлаа.

Би түүнийг хараад надад хэлсэн үгийг нь бодлоо. Би тэр өглөө их ажилласан. Би ядарч, надаас эвгүй үнэр гарч байсан болохоор гэртээ харихыг хүсэж байсан. Гэхдээ Хулэт ахын хувьд ямаршуу байсан бол? Тэр ч бас өглөө их ажилласан шүү дээ. Энд байгаа залуус бүгд л их ажилласан. Тэгсэн ч гэсэн тэд яагаад энд ирсэндээ баяртай байгаа юм бол?

Би бусдыгаа гүйцэж очоод ажиллаж эхлэв. Эхлээд би хийж буй том золиослолынхоо талаар бодож, өөрийгөө зоригжуулахыг хичээв. Гэвч би удалгүй өөрийнхөө талаар бодохыг больж, бид хүн бүрийн оролцоотойгоор ямар хурдан ажиллаж байгааг анзаарсан. Бид инээлдэн, ярилцаж байсан ба удалгүй би цагийг тун зугаатай өнгөрүүлж байгаагаа мэдэрсэн юм. Хэдхэн цагийн дотор бид ажлаа дуусгаж чадсан.

Өмнө нь дааж давшгүй золиослол мэт санагдаж байсан ажил өчүүхэн зүйл байсныг би гэртээ харих замдаа ойлгож билээ. Чухамдаа хүн бүрийн тусалцаатайгаар энэ нь золиослол байсан мэт огтхон ч санагдсангүй.

Хулэт ах машинаа манай байшингийн өмнө зогсоогоод над руу харж, инээмсэглэн, “Өнөөдөр тусалсанд чинь баярлалаа. Чиний оролцоо бидний ажлыг ч хөнгөлсөн шүү” гээд нүдээ ирмэв.

“Баярлалаа, бүгдийн оролцоо ажлыг хөнгөвчилсэн” гэж хэлээд би мөн хариу ирмэж, машинаас буун хаалгыг хаав.

Хулэт ах араагаа солиод ухрангаа цонхоороо цухуйн, “Маргааш уулзъя, тэгэх үү?” гэв.

“Тэгье. Маргааш уулзъя” гэж би хэллээ. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.





Би найзуудтайгаа сүмийн талаар ярилцах үед сүм хэт олон дүрэм журамтай учраас тэд үүнийг сонирхдоггүй гэж хэлдэг.

Би тэдэнд юу гэж хэлж болох вэ?

“Дүрмийн” талаарх хандлага маань бидний үзсэн, дассан зүйлтэй маш их холбоотой. Хэрэв найзууд чинь хэзээ ч шүдээ угааж хэвшээгүй, харин та нар өдөр болгон шүдээ угаах ёстой гэж заалгасан тохиолдолд та нар тэдэнд шүдээ угаа гэж хэлбэл тэд үүнийг хатуу дүрэм мэтээр хүлээн авч болох юм. Харин энэ нь хэвшил буюу амьдралын хэв маяг болсон учраас та нар үүнийг дүрэм гэж огт боддоггүй байж болно. Тэд шүдээ огт угаахгүй байх нь нэг төрлийн эрх чөлөө гэж бодож болох ч харин та нар үүнээс үүдэн гарах асуудлуудыг болон цэвэрхэн, эрүүл шүдтэй байх нь хэчнээн сайхныг мэддэг.

Сүмийн “дүрмүүд” үүнтэй адил юм. Та нарын найзууд бидний дагадаг жишгүүдийг хязгаарлагдмал гэж бодож болно. Гэвч Их Эзэн болон Түүний үйлчлэгчид бидэнд илүү сайхан амьдралтай байж, Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход туслахын тулд эдгээр дүрмийг өгснийг та нар мэднэ. Түүнчлэн, Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь адислалуудыг үргэлж авчирдаг бөгөөд тэдгээрийн нэг нь Ариун Сүнсний нөхөрлөл юм. Та нар эдгээр ашиг тус болон адислалыг найзууддаа дүрслэн хэлээд “дүрмүүд” нь Бурханаас ирсэн эсэхийг олж мэдэх цорын ганц арга зам бол тэдгээрийг туршиж үзэх явдал юм гэж тэдэнд хэлж болно (Иохан 7:17). ■

Бурхан яагаад биднийг бүтээсэн юм бол?

Бурхан биднийг оргүй хоосон зүйлээс “бүтээгээгүй” гэдгийг ойлгох нь чухал. Биднийг бүрдүүлэгч зарим үндсэн зүйл бидний сүнсний төрөлтөөс өмнө оршиж байсан юм. “Эхлээд хүмүүн тэрчлэн Бурхантай хамт байсан юм. Оюун билиг буюу үнэний гэрэл нь бүтээгдээгүй буюу хийгдээгүй юм, мөн чухамдаа ийм байж ч чадахгүй болой” (С ба Г 93:29). Бид үүнийг мэдэх учраас Тэнгэрлэг Эцэгийн биднийг бүтээх хүсэл зориг нь тохиолдлын эсвэл санаандгүй зүйл биш бөгөөд харин гүн гүнзгий зорилготой гэдгийг бид бас мэдэж чадна. Бошиглогч Иосеф Смит “Бурхан сүнснүүд болон алдар суунуудын дунд байсан ба тэрээр илүү оюун ухаантай байсан учраас үлдсэн сүнснүүдэд өөртэйгөө адил дэвших боломж олгохын тулд зохих ёсны хуулиудыг үндэслэсэн юм” хэмээн заажээ (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 210; түүнчлэн Мосе 1:39-ийг үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг маань биднийг өсөж хөгжин, Түүнтэй адил болоосой гэж хүссэн учраас Тэр бидний сүнсийг бүтээж, энэ дэлхийн амьдралыг зайлшгүй багтаасан авралын болон аз жаргалын төлөвлөгөөгөөр хангасан юм. Тэгэхээр энэ асуултын хамгийн энгийн бөгөөд шилдэг хариулт нь Бурханы хийдэг бүх зүйлийн талаарх асуултад хариулах явдал юм. Яагаад гэвэл Тэр биднийг хайрладаг. ■

АЛИВАА ЗҮЙЛ ХАРАГДАЖ БАЙГАА ШИГЭЭ ДАНДАА БАЙДАГГҮЙ

Зугаа цэнгэл, адал явдал тань та нарыг
аюултай замд оруулахгүй байхад анхаар

(Хиламан 3:29-ийг үзнэ үү.)





ЗӨВ ШАЛТГААНААР

Расим Малуфф

2011 онд би амьдралынхаа хамгийн чухал шийдвэрүүдийн нэгийг гаргасан юм. Энэ нь миний амьдралын хамгийн агуу эрдэнэсийг надад авчирсан. Би номлолд үйлчлэх шийдвэр гаргасан бөгөөд энэ нь амар хялбар байгаагүй.

Хүүхэд байхдаа болон өсвөр насандаа хөл бөмбөгөөр хичээллэх боломжийг Их Эзэн надад өгсөн. Би олон улсын тэмцээнүүдэд Парагвайг төлөөлж, улсынхаа өсвөрийн хөл бөмбөгийн шигшээ Либэртад багийнхантай Европ, Ази, Өмнөд Америкийн орнуудаар аялдаг байв.

Аз болоход манай аав, ээж хоёр спортын үйл ажиллагааг маань зохих боловсрол болон сүнслэг хүмүүжилтэй холбосон юм. Миний өөрийн итгэл, гэрчлэл ээжийн минь итгэл, гэрчлэлийн үр жимснээс соёолон ургасан нь гарцаагүй билээ. Ээжийнхээ итгэлтэй байдлын ачаар би спортын маш шахуу хуваарийнхаа хажуугаар семинарт явдаг байсан.

Хэдийгээр би хүүхэд байхаасаа л бүрэн цагийн номлолын талаар сонссон ч номлолд үйлчлэх тал дээр баттай шийдвэр гаргаж чаддаггүй байлаа. Аав манай тойргийн бишопын зөвлөлд үйлчлэх дуудлага хүлээн авснаар энэ байдал өөрчлөгдсөн юм. Аав намайг спортын ажил мэргэжилтэй болохыг ихэд дэмждэг байсан учраас энэ нь түүний хувьд хүнд шийдвэр байсан. Аав миний хөл бөмбөгийн бэлтгэл болон тэмцээнүүдэд үргэлж ирж, бид хоёр олон цагийг хамтдаа өнгөрөөдөг байв. Энэ шалтгааны улмаас бишопын зөвлөлд үйлчлэх дуудлагыг хүлээн авсан нь намайг дэмжих цагаа багасгах ёстой гэсэн үг байлаа.

Аавыг дэмжин баталсан ариун ёслолын цуглааны үеэр миний оюун санаанд нэгэн хүчирхэг бодол орж ирсэн юм. Хэрэв би чухал зүйлүүдээ зөв шалтгааны төлөө золиослоход бэлэн биш байгаа бол бусдын золиослол оргүй хоосон зүйл байх болно гэдгийг энэ нь

надад ойлгуулсан билээ. Гэрчлэлийн цуглааны үеэр нэг хүн хэрэв бид дуулгавартай байвал бидний гэр бүл үүрд мөнх оршиж чадна гэсэн санааг хуваалцсан. Энэ бодол миний зүрх сэтгэлд хүрсэн бөгөөд би гэр бүлтэйгээ үүрд мөнх хамт байхын тулд чадах бүхнээ хийхээр шийдсэн юм. Тэр ням гаргийн хичээлийн үеэр зарлигуудад дуулгавартай байхын ач холбогдол хэд хэдэн удаа дурдагдав. Сүнс Их Эзэнд үйлчлэхэд намайг маш хүчтэй өдөөж байсан бөгөөд гэр бүлийн үдшийн дундуур би номлолд

.....
Өөр юу ч нагад ийм агуу баяр баяслыг мөн ийм агуу амар амгаланг өгөөгүй буюу миний номлолын үйлчлэлийн авчирсан шиг тийм гайхамшгуудыг өөр юу ч нагад авчраагүй юм.
.....

НОМЛОЛД
ЯВАХ ЦАГ ЧИНЬ
БОЛЖЭЭ

Шинэ Зеландын
регби тоглогч
Сидни Гөүин-
гийн тухай
видео бичлэгийг
(монгол хэл
дээрх) [lds.org/go/
going363](https://lds.org/go/going363) хаягаар
орж үзнэ үү.



ҮЙЛЧЛЭХ НЬ

үйлчлэх шийдвэрээ гэр бүлдээ хэлсэн юм.

Энэ шийдвэрээс болж, би дээд сургуульд суралцахаа түр хойшлуулж, хөл бөмбөгийн клубтэй байгуулсан таван жилийн гэрээгээ хүртэл нэг тийш болгон шийдэх хэрэгтэй болсон юм. Их Эзэн эхнээсээ л үүд хаалгуудыг нээж мөн хүмүүсийн зүрх сэтгэлд нөлөөлсөн болохоор гэрээгээ сайнаар шийдэж чадсан билээ.

Би номлолын өргөдлөө явуулсныхаа дараа 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулганыг сонсов. Чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн мэргэжлийн регбигийн тоглогч, Шинэ Зеландын улсын шигшээ багийн гишүүн Сидни Гөүингийн номлолын туршлагыг хуваалцсан юм. Гөүинг ах номлолд үйлчилснийхээ дараа мэргэжлийн спортдоо эргэн ирж, спортоороо хичээллэхээ үргэлжлүүлсэн нь надад нэгэн зүйлийг заасан. Номлолынхоо туршид болон өнөөдрийг хүртэл энэ тухай ахин дахин сонссон нь

намайг адисалж, миний зүрх сэтгэлд амар амгаланг авчирсан билээ. Гэр бүлийнхний маань болоод тойрог ба гадасны гишүүдийн өөр өөр үед хуваалцсан тоолж баршгүй олон гэрчлэл нь үйлчлэх тухай миний шийдвэрийг баттай болгоод зогсонгүй номлолын хүнд үеүдэд надад урам хайрлаж байлаа.

Номлолын талбарт үйлчлэх миний шийдвэр дотны гурван найзын маань номлолд үйлчлэх шийдвэрт нөлөөлсөн нь илүү их сэтгэл ханамжийн бас нэг эх сурвалж болдог. Тэд дараа нь бүсийн удирдагч, номлолын ерөнхийлөгчийн туслах, бүр салбарын ерөнхийлөгчөөр хүртэл үйлчилсэн. Бид одоо Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд буцаж очих боломжийг бидэнд олгох зам дээр хараагаа чиглүүлээд байна.

Би гурван жилийн өмнөх тэр хүн биш болсон. Миний хамгийн агуу хүсэл бол Их Эзэний хүслийг биелүүлэх явдал юм. Их Эзэн намайг “зуу дахин” адисалсан (Матай 19:29).

Надад Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хайртай Хүүгийн тухай, Есүс Христийн Цагаатгал болон Бурханы Ариун Сүнсний цэвэршүүлэгч хүч мөн хожмын өдрүүд дэх эдгээр ер бусын ажил болон гайхамшгийн тухай түүнчлэн сайн мэдээ бошиглогч Иосеф Смитээр дамжин газар дэлхий дээр сэргээгдсэн тухай амьд бөгөөд жинхэнэ гэрчлэл байгаа (Исаиа 29:14-ийг үзнэ үү).


Энэхүү ариун нандин цаг мөчийн төлөө болон Уругвайн Монтевидео номлолын ах, эгч нартай танилцаж, тэднийг хайрлах боломжтой байгаадаа миний зүрх сэтгэл хайр, талархлаар дүүрэн байна. Цөөхөн адислал ч тэдний дунд үйлчлэх агуу адислалтай эн зэрэгцэж чадна. Өөр юу ч надад ийм агуу баяр баяслыг болон ийм агуу амар амгаланг өгөөгүй буюу миний номлолын үйлчлэлийн авчирсан шиг тийм гайхамшгуудыг өөр юу ч надад авчраагүй юм. ■

Энэ өгүүллийн зохиогч Парагвайд амьдардаг.

МОРМОНЧУУД БУРХАНД ИТГЭДЭГ



Гэрээсээ хол байхгаа нисэх онгоцны буудал дээр нэг танихгүй хүнтэй сайн мэдээг хуваалцах боломж надад олдож билээ.



Брэнда Хэрнандез Руиз

Би Мексикээс АНУ-ын Монтана руу аялах замдаа Колорадогийн Денверт түр буудалласан юм. Би нисэх буудал дотор алхангаа газардаж, хөөрч буй онгоцуудыг том цонхоор харж байлаа. Би өмнө нь хэзээ ч нисч үзээгүй учраас сандарч байв. Нисэх буудал маш том санагдсан.

Би тасалбараа хараад онгоц нисэх хүртэл надад хоёр цаг байгааг мэдэв. Би онгоцондоо суух хүртлээ суугаад юм уншиж болох газар олохоор шийдэв. Би суух газар хайж явахдаа хүмүүсээс бага зэрэг цэрвэж байв. Бараг бүх сандал хүнтэй байлаа. Би ганцаараа сууж байсан нэг ахимаг насны эмэгтэйн хажууд суухаар шийдэв. Зөвхөн тэр л надад айж цэрвэм санагдсангүй.

Түүнтэй ярилцах шийдвэр гаргатай бараг нэг цаг өнгөрөв. Намайг өөрийгөө танилцуулахад тэр ач, зээ нарынхаа амжилтуудаас их л найрсгаар, тун дуртай ярьж

байв. Тэр надаас миний талаар бага сага юм асуухад нь би түүнд Мексикт өнгөрүүлсэн бүх амьдралынхаа тухай ярьсан юм. Тэгтэл надад түүнтэй сайн мэдээг хуваалцах өдөөлт гэнэт төрлөө. Тэр надаас миний шашны талаар асуухад би түүнд өөрийгөө Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн гэдгээ хэлэв.

Тэр энэ нэрийг хэзээ ч сонсож байгаагүй гэлээ.

Би инээмсэглэн, “Хүмүүс биднийг мормончууд гэдгээр нь мэддэг” гэж хэлэв.

Түүний хандлага гэнэт өөрчлөгдөв. Нүүрнийх нь хувирал болон надтай ярьж буй байдал нь өөр болж, тэрээр юу гэж хэлэхээ мэдэхгүй байгаа бололтой харагдав. Бидний яриа ингээд дууслаа гэсэн мэдрэмж надад төрсөн боловч би түүнтэй яриагаа үргэлжлүүлэхийг хичээсэн юм. Би түүний шашны талаар асуув. Тэр ямар ч эргэлзээгүйгээр “Би католик шашинтай” гэв.



Тэгээд тэр “Би сайн ойлгосонгүй. Чи их сайн охин шиг байна. Аятайхан ч ааштай юм. Чи яагаад мормон байхыг хүсдэг юм бэ?” гэж асуув.

Энэ үг намайг цочирдуулсан болохоор би хэрхэн хариулахаа мэдсэнгүй. Би чимээгүйхэн залбирч, хожмын үеийн гэгээнтэн байх нь миний хувьд ямар утга учиртайг тайлбарлахад туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйв. Би сүмийн гишүүн байгаадаа баяртай байдгаа мөн сайн мэдээний заадаг зүйлсийн ачаар илүү сайн хүн болж, аливаа зүйлсийг үүрд мөнхийн талаас нь харах боломжтой болсон гэдгээ түүнд хэлэв.

Тэр гайхсан янзтай харснаа “Мормончууд Бурханд итгэдэггүй шүү дээ” гэх нь тэр.

Би энэ үгийг сонсоод инээхгүй байхыг хичээв. Харин би инээмсэглээд энэ бол үнэнийг түүнтэй хуваалцах боломж гэдгийг ойлгосон юм. Би итгэдэг үндсэн зүйлүүдээ

түүнд тайлбарлаж, авралын төлөвлөгөө болон гэр бүлүүдийн ач холбогдлын талаар заалаа. Тэр итгэсэн байдалтай харагдахгүй байсан учраас би түүнтэй гэрчлэлээ хуваалцахаар шийдэв. Тэр том нисэх буудалд би Иосеф Смитийн тухай болон амьд бошиглогч, төлөөлөгчдийн талаар мөн сайн мэдээг болон Мормоны Номыг хайрладаг хайрынхаа талаар гэрчлэлээ хуваалцах зоригоор адислагдсан юм.

Би цаг харав. Онгоцондоо суух цаг болсон байв.

Энэ туршлага урьд өмнө үзэж байгаагүйгээр гэрчлэлийг минь хүчирхэгжүүлсэн юм. Би түүнтэй гэрчлэлээ хуваалцаж, сүмийн гишүүдийн талаарх түүний ойлголтыг өөрчлөхөд туслах боломжтой байсандаа жаргалтай бас талархалтай байлаа. Одоо хэн нэгэн хүн сүмийн талаар асуувал би өөртөө илүү итгэлтэй байж чадна. ■
Энэ өгүүллийг бичигч Мексикийн Чуауад амьдардаг.




Ерөнхийлөгч
Бойд К.Пакэр

Арванхоёр
Төлөөлөгч
ийн чуулгын
ерөнхийлөгч

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүд бол Есүс Христийн онцгой гэрчүүд юм.

Бид Сүнстэй хамт байхуйц **ЗОХИСТОЙ** **БАЙХЫН** тулд юу хийж чадах вэ?



Урам хайрлах дуу хөгжим сонс.



Хүндэтгэлтэй ярь.



Алдаа гаргасан үедээ наманчил.



Даруу хувцасла.

Хэрэв чи эдгээр зүйлийг хийвэл хамгаалагдах бөгөөд Ариун Сүнс чамайг удирдах болно.

Итгэлийн тухай миний заасан хичээл



Эмма Р., нас 11, АНУ, Техас

Хэдэн жилийн өмнө би гэр бүлийн үдэш дээр итгэлийн тухай хичээл зааж билээ. Яагаад бидэнд итгэл хэрэгтэй талаар ахад минь асуух зүйл байсан учраас манай гэр бүл итгэлийн тухай ярихад их цаг зарцуулсан. Жижигхэн аяганд хадгалж байсан амтат гуаны үрийг би тарилаа. Итгэл бол үртэй адил гэж би гэр бүлдээ хэлэв. Хэрэв та нар үүнийг сайн арчилбал энэ үр ургах болно.

Бид цэцэг, ногоо ургуулахад хэзээ ч амжилттай байж үзээгүй. Гэхдээ би энэ үрийг ургуулж, итгэлийн сайн жишээ болгохоор найдсан юм. Би үртэй аягыг цонхон дээр тавьж, түүнийг арчилж байв. Үрээ ургуулахын тулд би хүлээж бас залбирсан.

Би бараг л шантарч эхлээд байлаа. Гэвч долоо хоногийн дараа би ногоон навч цухуйхыг харав. Дахин нэг долоо хоног цонхон дээр байлгасныхаа дараа аав, ээж хоёр гадаа хашаан дахь цэцгийн мандалд үрийг шилжүүлж суулгах газар олж өгч, надад тусалсан юм.

Би үрээ сайн арчилж, усан, зэрлэг ургамлыг түүсэн. Амтат гуаулам том болсоор байв. Би маш их баяртай байлаа.

Хэдэн долоо хоног өнгөрсний дараа би цэцэг ургахыг ажиглав, дараа нь жижигхэн жимс ургаж эхлэв. Миний ганц жижигхэн үрээс долоон амтат гуа ургахыг бид харлаа. Миний хувьд энэ нь гайхамшиг бас миний залбирлуудын хариу байсан юм. Жимс нь чихэрлэг байлаа. Алма 32:42 дээр “Мөн энэ нь та нарын дотор

үндэслэж болохын тулд, та нар үгийг арчлахдаа зориулсан шаргуу байдал хийгээд та нарын итгэл түүнчлэн та нарын тэвчээрийн учир, болгоогтун, удахгүй та нар үүний жимсийг, хамгийн эрхэм, амтат бүхнээс дээд амтат түүнийг түүх болно” гэж хэлсэнчлэн байв.

Энэ туршлага намайг маш их жаргалтай болгож, надад болон миний гэр бүлд итгэл бол Есүс Христийн сургаалын үнэн зарчим гэдгийг заасан билээ. ■

ЧИНИЙ ЭЭЛЖ

Бид та нартай хамт үр суулгахыг хүсч байна: Чи *Лиэхона* сэтгүүл дээр туршлагаа хуваалцах талаар бодож байсан уу? Есүс Христийн сургаалаар та нарын хэрхэн амьдардаг тухай үнэн түүхүүдийг бид дуртайяа хүлээж авна. Тухайлбал: залбирал чинь хариулагдаж байсан үеийнхээ тухай эсвэл найзыгаа сүмд урьсан тухай бичиж болно.

Түүхээ онлайнээр liahona.lds.org, э-мэйлээр liahona@ldschurch.org эсвэл 3-р хуудсан дээр байгаа хаягаар явуулахад эцэг эх тань тусалж чадна. Тойрог эсвэл салбарынхаа нэр болон эцэг эхийнхээ зөвшөөрлийг хавсаргаарай.



БИЕ МАХБОДТОЙ БАЙХЫН ЮУ НЬ САЙХАН БЭ?

Бидний бие махбод маш чухал бөгөөд ариун юм. Иймээс Их Эзэн бие махбодыг ариун сүм гэж нэрлэдэг (1 Коринт 3:16–17-г үзнэ үү). Бие махбодтой байх нь бас хөгжилтэй шүү! Бие махбод гүйх, дуулах, авирах, инээх, зурах, сэлэх, бүжиглэх гээд бусад олон хөгжилтэй үйлдлийг хийж чаддаг. Мөн бид суралцах, хүмүүст туслах, гэр бүлтэй болоход түүнчлэн энэ дэлхийг илүү сайн газар болгоход махбодоо ашиглаж чадна.

ЯАГААД БИДЭНД БИЕ МАХБОД БАЙДАГ ВЭ?

Бид төрөхөөсөө өмнө бие махбодгүй сүнс байсан. Бие махбодтой болох хүртэл бидэнд хийж чадахгүй зүйл олон байсан бөгөөд Бурхан биднийг бие махбодтой болгохын тулд дэлхий рүү илгээсэн юм. Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болохын тулд бидэнд сүнс, бие махбод хоёулаа хэрэгтэй. (С ба Г 88:15-ыг үзнэ үү.)




Миний бие бол

ХЭРЭВ МИНИЙ БИЕ МАХ- БОД ЗАРИМ ТАЛААРАА НАДАД ТААЛАГДАХГҮЙ БАЙВАЛ ЯАХ ВЭ?

Зарим үед бидний бие махбод бидний хүссэн шиг харагдаж, хөдөлдөггүй буюу ажилладаггүй. Бидний бие махбод одоо ямар байгаагаас үл хамааран бид үүнийхээ төлөө талархалтай байж, үүгээр энэ дэлхий дээр сайн зүйлүүдийг хийхээр сонгож чадна. Гэвч хэзээ нэгэн өдөр бид бүгд амилуулагдах бөгөөд төгс төгөлдөр бие махбодтой болно (Алма 40:23-ыг үзнэ үү). Мөн бидний бие махбод ямар байгаагаас үл хамааран Бурхан биднийг хайрладаг бөгөөд бид ч бас өөрсдийгөө хайрлаж чадна.

ЯАГААД ХҮН БҮР АДИЛ БАЙДАГГҮЙ ВЭ?

Бие махбод нь янз бүрийн өнгө, хэлбэр, хэмжээтэй байдаг бөгөөд энэ нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг юм. Хэдийгээр хүн болгон өөр ч гэсэн бид бүгдээрээ Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн (Эхлэл 1:26-г үзнэ үү). Тийм болохоор бидний бие махбод түүний төгс биеийн загвараар бүтээгдсэн гэсэн үг. Хүн бүр бидний хайрт Тэнгэрлэг Эцэгээс ирсэн бэлэг учраас хүн бүр үзэсгэлэнтэй.



БИ БИЕ МАХБОДДОО ХЭРХЭН ХАНДАХ ЁСТОЙ ВЭ?

Бид ямар нэг хэмжээлшгүй үнэт эрдэнэстэй хэрхэн харьцах байсан—бие махбоддоо тийм л байдлаар, хайр болон хүндэтгэлтэй харьцах ёстой. Бошиглогчдоор болон Мэргэн ухааны үгээр дамжуулан Тэнгэрлэг Эцэг бидний бие махбодод юу муу, юу сайн болохыг хэлж өгсөн билээ. Бие махбоддоо санаа тавихын тулд хийж болох маш олон зүйл байдаг.

- Эрүүл хоол хүнс идэн, дасгал хийж бай.
- Даруу хувцаслаж, бие махбоддоо цэвэр байлга.
- Бусдын бие махбодод хүндэтгэлтэй ханд.
- Биендээ шивээс хийлгэх юм уу цоолж, зэрэмдэглэж болохгүй.
- Мансууруулах бодис, архи, тамхи, кофе эсвэл цай бүү хэрэглэ.
- Аюулгүй бөгөөд зугаатай тоглоомуудаар тоглож, аюултай үйл ажиллагаануудаас хол бай.

Бид бие махбоддоо сайн анхаарснаар Ариун Сүнснийг илүү сайн мэдрэх чадвартай болдог.

**Бид Бурханы зарлигласны дагуу
бие махбоддоо анхаарал тавих юм
бол адислагдах болно! (Мозая 2:41;
С ба Г 89:18–21-ийг үзнэ үү.)**

АРИУН СҮМ

Марисса Виддисон

Сүмийн сэтгүүлүүд



Бид баптисм ба гишүүний баталгаагаар дамжуулан сүмийн гишүүд болдог

Жэннифер Мадди

Мариела сургуулиасаа гэртээ хөмсгөө зангидан хүрч иржээ. “Юу болоо вэ?” гэж ээж нь цэцэрлэгтээ цэцэг тарих зуураа асуув.

“Сониа надтай тоглоно гэж амлачихаад тоглоогүй” гэж Мариела хэлээд ээжийнхээ хажууд, газарт суув.

“Харамсалтай л юм болж дээ. Амлаалтаа сахих нь тун чухал шүү. Ирэх долоо хоногт чи баптисм хүртэж, гишүүнээр батлуулахдаа гэрээнүүд гэдэг маш чухал амлалтуудыг хийх болно” гэж ээж нь хэлэв.

“Тийм үү?” гэж Мариела асуув. Тэр

баптисм хүртэх гээд сэтгэл нь догдолж байлаа.

Ээж нь газарт хэдэн шар цэцэг тавив. “Чи зарлигуудыг дуулгавартай дагана гэж амлах болно. Чи бас Есүс Христийн нэрийг өөр дээрээ авахаар амлана. Харин эдгээр зүйлийг хийсний чинь төлөө Тэнгэрлэг Эцэг чамд юу амладаг вэ?”

Мариела Хүүхдийн хэсэгт сурсан зүйлийнхээ талаар бодлоо. “Намайг Ариун Сүнтэй хамт байх болно гэж амласан.”

“Тийм шүү” гэж ээж нь хэлэв. “Чи мөн Есүсийн сүмийн гишүүн болно. Харин чи зарлигуудыг дуулгавартай дагах амлаалтаа хэрхэн биелүүлж чадах вэ?”

“Би найрсаг байж, үнэнийг хэлж чадна” гэж Мариела хэлээд “Есүсийн нэрийг өөр дээрээ авна гэж юу гэсэн үг вэ?” гэж асуув.

“Энэ нь чи Түүнтэй адилхан байхыг хичээж, Түүний хийгээсэй гэж чамаас хүссэн зүйлүүдийг хийхийг хэлж байгаа юм” гэж ээж нь хэлэв. “Чи

Есүстэй адил байхын тулд юу хийж болох вэ?”

Мариела хурууныхаа завсар ягаан цэцэг эргэлдүүлэнгээ “Би сургууль дээрээ шинэ ирсэн охинтой хамт сууна. Мөн би Сониятай найрсаг байхыг хичээж чадна” гэж хэлэв.

“Их аятайхан санаанууд байна. Чи ариун ёслолоос хүртэхдээ амлалтуудаа санах болно” гэж ээж нь хэлэв.

Мариела инээмсэглээд “Би өөр нэг амлалт мэднэ—цэцгүүдээ услах юм бол бид үзэсгэлэнтэй сайхан цэцэрлэгтэй болно!” гэлээ. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

Дуу ба судар

- “Баптисм,” *Children’s Songbook*, 100 (1 ба 3-р бадаг)
- Иохан 3:5

Гэр бүлээрээ


ярилцах санаанууд

Мариела Есүс Христийг дагах замаар баптисмын гэрээгээ сахих арга замуудын талаар бодлоо. Танайхан гэртээ, сургууль дээрээ мөн бусад газарт Есүстэй илүү адилхан байх арга замуудыг бодож олж чадна. Ариун ёслолоос хүртэх үедээ баптисмын гэрээнийхээ тухай боддог байх гэр бүлийн зорилго тавиарай.



Би баптисмын гэрээгээ сахиж чадна

Баптисмын гэрээнийхээ тухай кино хийхийн тулд хүрээ болон зургийн хэсгүүдийг хайчил. Зургийн хоёр хэсгийг нэг урт туузан дээр цавуугаар юм уу наалддаг туузаар наа (А, Б хоёрыг залган). Мөн хүрээ болон зургийн хэсгийг хатуу цаасан дээр цавуугаар юм уу наалддаг туузаар наа. Хүрээн дээр байгаа тасархай шугамнуудын дагуу хайчилж, хоёр ухлаадас гарга. Зургуудаа ухлаадсанд хийхэд зурагнууд хүрээний урд харагдах болно.



**БИ БАПТИСМЫН
ГЭРЭЭГЭЭ
САХИЖ ЧАДНА**



A



Би зарлигуудыг дагахаар амладаг.

Би баптисм хүртэхдээ



Тэнгэрлэг Эцэгтээ амлалт өгдөг.



Намайг баптисмын гэрээгээ сахиx үед Тэнгэрлэг Эцэг Ариун Сүнснийг надтай хамт байлгана гэж амладаг.



Би ариун ёслолоос хүртэхдээ Тэнгэрлэг Эцэгт өгсөн амлалуудаа санах болно.



Би Есүс Христийг санаж, Түүнтэй адил байхыг хичээнэ гэж амладаг.

B



БИДНИЙ ХУУДАС



Экватор, Лэсли Кю., нас 6



Экватор, Лэди Кю., нас 9



Индонез, Сатя С., нас 11



“Мормоны Ном,” Бразил, Виллям М., нас 10



Би нэг жилийн Хүүхдийн хэсгийн танилцуулах арга хэмжээнд “Би тэнгэрт амьдардаг байсан” дууг төгөлдөр хуур дээр тоглосон. Дараа жил нь “Би ариун сүм харах дуртай” дууны дохионы хэлний хувилбарыг удирдсан. Ирэх жилийн миний зорилго бол “Хэрэв би зүрх сэтгэлээрээ сонсвол” дууг сурах явдал юм. Их Эзэн надад олон авьяас өгсөн бөгөөд би тэдгээрийг хөгжүүлж, бусдыг адислахын тулд үүнийгээ ашиглах юм бол миний авьяас чадвар өснө гэдгийг би мэднэ. Би Бурханы охин. Мөн Есүс Христ миний төлөө амиа өгсөн гэдгийг би мэднэ.

Аргентин, Луна Марисол И., нас 8



Ахлагч
Эдуардо Гаваррэт
Дал

ҮЙЛЧЛЭХЭЭР БЭЛТГЭГДСЭН

*“Насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун”
(Алма 37:35).*

Би Уругвайн Минас хотод өсөж том болсон юм. Намайг зургаан настай байхад миний ээж, эгч нар сүмд баптисм хүртсэн. Аав сүмд нэгдээгүй боловч биднийг сүмд явахад үргэлж баяртай байдаг байсан. Тэр Мэргэн ухааны үгийг сахиж, аравны нэг төлдөг байв.

Манай салбар маш жижигхэн байлаа. Бас бидэнд сүмийн байр байгаагүй. Бид түрээсийн байшинд цугладаг байсан юм. Тэр байшин гаднаа жижиг усан сантай байсныг бид баптисмд ашигладаг байв.

Найман насны төрсөн өдөр маань ойртох тусам би баптисм хүртэх гэж байгаадаа улам баяртай байв. Гэвч баптисм хүртэх өдөр бороо ороод маш хүйтэн байлаа. Цаг агаар хүйтэн байсан учраас тэр өдөр баптисм хүртэх хэрэггүй гэж ээж надад хэлэв. Гэвч тэр өдөр миний төрсөн өдөр байсан болохоор би тэр өдөр л баптисм хүртэхийг хүссэн юм.

Би цагаан хувцсаа өмсөөд баптисм хүртэхээр усан сан руу орсноо санаж байна. Ус хүйтэн байгаа гэдгийг би мэдэж байсан ч хүйтнийг нь мэдрээгүй юм. Би зөв зүйл хийж байгаагаа мэдэж байсан

болохоор надад дулаахан сайхан мэдрэмж төрж билээ.

Их удалгүй манай салбарын цуглааны байр баригдсан юм. Тэр үед сүмийн гишүүд цуглааны байр барихад тусалж болдог байлаа. Миний үүрэг бол газар унасан хадаас, эрэг боолтуудыг

авч өгөх ажил байсан юм. Энэ бол энгийн боловч миний хувьд маш чухал ажил байсан юм. Энэ нь надад хэрхэн үйлчлэхийг зааж, ирээдүйн сүмийн үйлчлэлд бэлтгэхэд тусалсан. Хэдийгээр та нар балчир ч гэсэн одоо хийдэг зүйлүүд тань та нарт нөлөөлдөг. ■





ДЭЛХИЙ ДАЯАР НАЙЗУУДАЙ БОЛОХ НЬ

Би Бразилын Педро байна

Эми Жэйн Лэвиттэй хийсэн ярилцлагаас

Педро Өмнөд Америкийн хамгийн том орон—Бразилд амьдардаг. Тэр Бразилын Парана мужийн нийслэл Куритибад амьдардаг юм. Педро аав, ээж, ах болон дүү охинтойгоо хамт цагийг өнгөрөөх дуртай. Тэд ариун сүм рүү явж, далайн эрэг дээр очих дуртай. Педро хэзээ нэгэн өдөр номлогч болохыг тэсч ядан хүлээж байна! ■

** Португалаар "Сайн уу, найзууд аа!"*

Ола, амигос!*

Би өглөө бүр сургуульдаа явахаасаа өмнө гэр бүлийнхэнтэйгээ судруудаас уншиж, залбирдаг. Миний дуртай сэдвүүд бол Бразилын индианчуудын урлаг болон түүхийн тухай сэдвүүд юм. Сургуулийн найзуудын маань олон нь сүмийн гишүүн биш. Би итгэдэг зүйлийнхээ тухай тэдэнтэй ярилцаж, тэднийг надтай хамт сүмд очооч гэж урьдаг.





Миний дуртай судрын түүх бол Нифай гуулин ялтсуудыг авахаар Иерусалим руу буцсан тухай түүх юм. Би зорилго тавьж, түүнийгээ биелүүлэх дуртай. Би 12 нас хүрэхээсээ өмнө Бурханд итгэх итгэлийн шагналаа авахаар төлөвлөж байна.

Би зураг зурах дуртай. Долоо хоногт би олон цагийг зураг зурж өнгөрөөдөг. Би бас номын санд очиж, урлагийн номуудыг үзэх дуртай.



Би хөл бөмбөг тоглох дуртай. Миний бас нэг дуртай спорт бол Солонгосын тулааны урлагийн нэг төрөл болох хапкидо юм.



БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Манай гэр бүлийнхэн Куритиба дахь ариун сүм рүү очиж, цэцэрлэг дундуур хамт алхах дуртай. Ариун сүм баригдах үед би дөнгөж дөрвөн настай байсан. Гэхдээ би нээлттэй хаалганы өдөрлөгөөр ариун сүм дотуур явснаа санадаг. Энэ нь миний хувьд онцгой дурсамж юм.

ЯВАХАД БЭЛЭН БОЛЛОО!

Педрогийн цүнх түүний дуртай зүйлсээр дүүрэн байна. Эдгээр зүйлийн алийг нь та нар цүнхэндээ хийх байсан бэ?



Би том болоод номлогч болж, Манауст үйлчлэхийг хүсдэг. Учир нь энэ хот Амазоны ширэнгэн ойн дэргэд байдаг юм. Дараа нь би загвар зохион бүтээгчээр ажиллахыг хүсдэг.



Нэгдүгээр сарын паспортын тамга байхгүй байсныг та нар анзаарсан уу? Та нар үүнийг хайчилж аваад нэмж болно!



Сара алхсаар л байв

Хэйди Поэлмэн

Бодит түүхээс сэдэвлэв



Сара үсэрч, харайж байв. Тэр гэрийнхэнтэйгээ хамт Силвэр гэдэг нуурыг тойрон, явган аялал хийхэд бэлэн байлаа. Түүний ах Жош түрүүнд нь явж байв.




Удалгүй Сарагийн гарыг нар халуу оргитол төөнөв. Хөл нь ч цуцаж эхлэв.

“Санаа зовох хэрэггүй дээ. Бид одоохон машин дээрээ буцаж очно” гэж ээж нь хэллээ.

Тэгтэл Сара замыг хааж уясан том улбар шар олсыг харлаа. “Гүүр эвдэрсэн байна. Бид буцаад нуурыг тойрч алхах хэрэгтэй” гэж аав нь хэлэв.

“Гэхдээ би үнэхээр их ядарч байна шүү дээ!” гэж Сараг хэлэхэд Жош газарт суугаад царайгаа барйлгав.



“Чи анхдагчдын түүхийг санаж байна уу?” гэж ээж нь асуулаа. Сара толгой дохив. Тэр анхдагчдыг хайрладаг байлаа.

“Анхдагчид асар хол замыг явган туулахаас аргагүй байсан юм. Заримдаа маш халуун, заримдаа дэндүү хүйтэн байдаг байсан ч тэд алхсаар л байсан. Тэд шинэ нутагтаа ирээд олон байшин, олон ариун сүм барьсан шүү дээ” гэж ээж нь хэлэв.

Анхдагчид зогсолтгүй алхсаар байсан гэдэгт Сара баяртай байлаа. Тэр ч бас үргэлжлүүлэн алхахыг хүсэв. Тэгээд Жош руу гараа сунгалаа. “Алив босоорой. Бид дахиад жаахан явах хэрэгтэй байна” гэж ах нь хэлэв. ■

Энэ өгүүлийг бичигч АНУ-ын Ютад амьдардаг.





Та нарын амьдрал эртний аль
нэгэн анхдагчийн амьдралаас юугаараа өөр вэ?
Юугаараа адилхан бэ?

ЭРЭГ РҮҮ ХАР

Ричард М.Ромни

Сүмийн сэтгүүлүүд

Каное завиар ойролцоох үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн нэгэн арал руу хийсэн аялал маань хүүтэйгээ ойр дотно болох төгс боломж мэт надад санагдлаа. Манай тойргийн Аароны санваарын удирдагчид болон залуу эрэгтэйчүүд энэ аялалд хэдэн сарын турш бэлтгэсэн бөгөөд тэдэнтэй хамт явах боломж надад олдсон юм.


Миний хүү Маккэй ахлах сургуульд байхдаа спортын гурван төрлөөр хичээллэдэг байсан учраас бие бялдар сайтай байлаа. Тийм учраас л удирдагчид биднийг нэг каное завинд суулгасан нь хэрэг гарвал тэр сайн сэлүүрдэж чадна гэдгийг тэд мэдсэн байх л даа. Надад каное завь залуурдах багахан туршлага байсан учраас бид сайн баг болсон юм шиг санагдаж байв.

Би бас нууран дээр ярилцах цаг гарасай гэж тэсгэлгүй их хүсэж байлаа. Маккэй ээжийгээ нас барснаас хойш олон зүйл үзэж туулсан бөгөөд би түүний хэрэгцээ, сонирхолд үргэлж хамгийн сайнаараа хариулж чаддаггүй байсан.

Бид сургалт авсан ба аврах хантаазтай ч болж, сэлж ч мөн чаддаг байсан. Бас биднийг туршлагатай удирдагчид удирдаж байлаа.

Бидний тооцоолоогүй нэг зүйл бол салхи байлаа. Бид хэдэн км сэлүүрдээд нуурын дунд хэсгийг өнгөрч, эрэгт ойртох үед хүчтэй салхи бидний өөдөөс салхилав.

Бусад каное завинууд эрэг рүү хүрч чадсан ч Маккэй бид хоёрын завь хоцорч байлаа. Давалгаанууд улам томроход бид урагш ахихын тулд байдаг чадлаараа сэлүүрдсэн ч



*Хүү маань
надад юун дээр
анхаарал төвлөрүүлэх болон
хэрхэн тэвчээртэй байх
талаар нэгэн
чухал сургамж
өгсөн юм.*

замаасаа хазайгаад байв. Би маш их ядарч, бас айж эхэллээ. Би завиа зөв чиглэлд оруулахыг хичээж, бүх хүчээрээ сэлүүрдсэн ч бид нэг дороо л байгаад байх шиг санагдав.

Завь маань хөмрөх аюул тулгарахад цаашаа явах чадал надад байгаа эсэхийг мэдэхгүй л байна шүү гэж эцэст нь би хэллээ. Тэгэхэд миний хүү “Та давалгаа руу хараад байна, аав аа. Ингээд байвал та эрэг рүү хүрч чадахгүй. Та эрэг рүү харах хэрэгтэй. Тэр толгод дээрх модыг харж байна уу? Тэр мод бол бидний хүрэх газар. Модон дээр анхаарлаа төвлөрүүл, тэгвэл бид тэнд хүрч чадна” гэлээ.

Түүний зөв байлаа. Би анхаарлаа модон дээр төвлөрүүлж эхлэнгүүт зүг чигээ алдахгүй байж чадсан юм. Миний гарын хүч сэлбэгдэх шиг болов. Маккэй сэлүүрдэх хэмнэлийг жигд байлгаж, “Сэлүүрд. Амар. Сэлүүрд. Амар” гэж байлаа. Бид тогтмол хурдаар урагшлав.

Биднийг эрэгт хүрэхэд хүмүүс ч туслахаар ирж, бид амьсгаагаа дарахаар суув. Тэр шөнө бид хоёр болсон явдлын талаар майхан дотроо ярилцсан юм.

Ерөнхийлөгч Томас С.Монсон Их Эзэний гэрэлт цамхгийн талаар: “Энэ нь биднийг амьдралын шуурган дундуур дууддаг. Энэ нь ‘Аюулгүй зам энд байна; гэртээ харих зам тань энэ байна’ хэмээн дууддаг” гэж заасныг бид хоёр хамтдаа санаж билээ.¹

Тэр өдрийн үдээс хойш эрэг дээрх мод бидний гэрэлт цамхаг болсон юм. Намайг бууж өгөхийн даван дээр хүү минь давалгаа руу биш харин эрэг рүү харах ухаалаг зөвлөгөө өгч билээ. Ингээд бид нэгээс илүү олон арга замаар хамтдаа сэлүүрдсэн юм. ■

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Standards of Strength,” *New Era*, 2008 оны 10-р сар, 2.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЭРТ Т.БАРРЕТТ

ЕРӨНХИЙЛӨГЧ ТОМАС С.МОНСОН

Томас С.Монсон бага байхдаа туулай, тагтаа тэжээдэг байжээ. Түүнийг найрсаг зангаар нь олон хүн таньдаг болсон бөгөөд тэрээр талархлын баяраар хоол хэрэгтэй байсан гэр бүлд тэжээвэр туулайнуудаа өгч, Христийн мэндэлсний баярын бэлэггүй хөвгүүнд өөрийнхөө галт тэргийг өгч байжээ. Тэр өсөж том болоод *Deseret News* гэдэг хэвлэлийн компанид ажилладаг байв. Төлөөлөгчийн хувиар тэр Зүүн Германд анхны гадсыг зохион байгуулсан бөгөөд **Германы Фрэйбэргийн ариун сүмийг** барих зөвшөөрлийг сүмд авч өгсөн байна. Ерөнхийлөгч Монсон сүмийн бүх гишүүнийг тусламж хэрэгтэй хүмүүсийг аврах ажилд уриалан дуудсан юм.

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ




Христээр ТӨГӨЛДӨРЖИХ НЬ

42

Аврагчийн үнэгүй өгдөг цагаатгагч хайрыг ойлгох нь биднийг төгс төгөлдөр байдал гэж юу болох тухай буруу, бодитой бус хүлээлтүүдээс чөлөөлж чадна.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



48

БУРХАНЛАГ ГЭРЭЭНҮҮД ХРИСТЭД ТУУШТАЙ ИТГЭГЧДИЙГ ТӨРҮҮЛДЭГ

Бурхантай хийсэн гэрээнүүд маань бидэнд хүч чадлыг хэрхэн авчирдаг вэ? Гурван арга замыг доор дурдав.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Итгэлийн тухай миний заасан хичээл

Эмма гэр бүлдээ итгэлийн талаар заахын тулд хулуу тарив.



67

